

ИХ ОЮУНЛАГ

ХҮН

ЦУВРАЛ
СЭТГҮҮЛ
ҮНЭГҮЙ
ТАРААГДАНА

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ
БАГШ ЧИН ХАЙ

АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛ
ГЭЖ ЮУ ВЭ?

ЗӨВ ЗАМ МӨР

СҮНСЛЭГ АДИСЛАЛТ
ШУЛУУН,
ДИВААЖИНГИЙН ҮҮД

ТАМЫН ЗАМ, ГАРЦУУДЫН
ТЭРГҮҮНҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨ




**1994 он Хүмүүнлэгийн
Төгс Улгэр Жишээ
медаль**

Филиппин дэхь Ази номхон далайн залуучуудын эрх
чөлөөний лигийн ерөнхийлөгч др. Рене Г. Сантос
гардуулав.



**1994 он Дэлхийн
Иргэн хүмүүнлэгийн
шагнал**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд Олон Улсын Энх
Тайвны Радио болон Даян Дэлхийн Боловсролын Их
Сургуулийг ундуслэгч, ТББ-ын чиглэлээр НҮБ-ын Эдийн
Засаг, Нийгмийн Зөвлөлдөх Хорооны зөвлөх др. Ричард
Шнайдер гардуулав.



**1994 он Олон Улсын
Хүмүүнлэгийн шагнал**

Шагналыг Гиллермо
Миндосагийн нэрэмжит
Тэтгэлгийн Сан ба Нийгэм
Амжиргааны Хөгжлийн
Филиппино хүрээлэнгээс Төгс
Гэгээрсэн Их Багш Чин Хайд
гардуулав.



**1994 он “Эрхэм Ариун
Амьдрал Үйлсийн Од”**

Шагналыг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хүн
төрөлхтөнд оруулсан гарамгай хувь нэмрийг үнэлж
Тайландын Засгийн Газар ба хэвлэл мэдээлээс гардуулав.



**1994 он Дэлхийн Оюун Санааны
Удирдагч шагнал, 2-р сарын 22-н Төгс
Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр**

АНУ-ын Иллинойс, Айова, Уисконсин, Канзас, Миссури,
Миннесота муж улсуудын захиргач нар Дэлхийн Соёлын
Харилцааны Нийгэмтэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Чен Хунг
Квангийн хамт Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд дээрх зурган
мужийн уерт нэрэзэгдэгдэд үзүүлсэн энэрэнгүй тусlamжинд нь
талаархан дээрх шагнажуудыг тус тус гардуулав.



ИХ ОЮУНЛАГ ХҮН СЭТГҮҮЛ

Үүсгэн байгуулагч:
ЭХ ДЭЛХИЙГЭЭ АВАРЦГААЯ САН

Эрхлэгч:
Л.Алтанхуяг

Редактор:
Д.Наран

Дугаарыг бэлтгэсэн:
Г.Лхагва, Д.Идэш, Т.Ундрал

Дизайнер:
С.Даш-Очир, Б.Чулуунсүрэн

Эх сурвалж:
www.Ikhagva.mn

Сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл, зураг материалыг
редакцын албан ёсны зөвшөөрөлгүйгээр
бүрэн ба хэсэгчилсэн хэлбэрээр нийтлэх, цахим
сайтад байршуулах болон бусад хэлбэрээр
ашиглахыг хориглоно

“Их оюунлаг хүн” сэтгүүлийн нийтлэлийн
бодлого, өнгө төрхөд нийцэх нийтлэл болон
нийтлэлийн санааг редакцын
и-мэйл хаягаар хүлээж авах болно

РЕДАКЦЫН ХАЯГ:

Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол,
42-р байр 6 тоот
Утас: 96667428, 99873776
E-mail: Altan_erin67@yahoo.com

Улсын бүртгэлийн дугаар: 9071009067

“СЭЛЭНГЭПРЕСС” ХХК-ийн
хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Эрхлэгчийн зуравс

Эрт цагт нэгэн бясалгагч Энэтхэгт байсан бөгөөд түүнд багшийнхаа намтар түүхийг бичих ариун үүрэг оногдсон байна. Хэдэн сарын дараа хүмүүс түүнээс бичиж дууссан уу? гэж асуухад бичиж дуусаагүй гэж хариулжээ. Мөн хэсэг хугацааны дараа асуухад “Энэ түүхийг бичиж дуусгах аргагүй, би багшийнхаа эрдэм чадалд хүрч чадахгүй. Түүний бодит ба бодит бус үйл ажиллагааг бүрэн ойлгож чадахгүй, учир нь миний багш ертөнцийн хамаг амьтдаас хэтийдсэн юм” гэж хариулсан гэдэг. Түүнтэй нэгэн адил энэ ертөнц дээр амьд ахуй залран буй Тэнсэлгүй Оройн Дээд Багшийнхаа тухай бүрэн дүүрэн бичнэ гэдэг ямар ч бололцоогүй зүйл билээ.

СУМА ЧИН ХАЙ бол гэгээрсэн их багш биш бөгөөд есдүгээр түвшин (ертөнц)-ээс бууж ирсэн Бурхны шууд дүр, Дээд Аватор юм. Иог бол төгс гэгээрсэн сүнс юм. Харин гэгээрсэн сүнснээс өндөр түвшинд хугас Аватор, түүнээс өндөр түвшинд Дээд Аватор байдаг. Иог бол цөөхөн хэдэн хүнтэй харьцах чадвартай. Аватор бол хамаг дэлхийн үйл хэрэгт оролцдог. Иог аниргүйхэн үйлдэнэ. Аватор эрч хүчтэй үйлдэж, итгэл төгс ярина. Зүйрлэн хэлбэл Иог бол бут сөөг, Аватор бол агуу том, асар өндөр мод юм. Аватор бол цаг ямагт Оройн дээд ертөнц хийгээд хамгийн доод ертөнцөд үйл хэргээ зэрэг явуулдаг. Аватор бол их далай. Иог бол гол мөрөн эсвэл цөөрөм. Хүн төрөлхтний ухамсыг дээшлүүлэх гэж оролдохдоо Иогууд заримдаа хорвоо дэлхийн мунхагийн харанхуйд автах нь бий. Харин Аватор бол хамгийн дээд, хамгийн доод хоёрын аль алинд нь зэрэг орших ба хамгийн доодод байлаа ч гэсэн түүний нөлөөнд автдаггүй. Хүн төрөлхтнийг хувирган өөрчлөх их үйлсэд Аваторын юу хийж гүйцэтгэж чадах нь Йогийнхтой харьцуулахад хязгааргүй билээ. (Шри Чинмой Самади ба Сидхи, монгол орчуулга, 2010, тал 137)

Хамаг дэлхий болон хүн төрөлхтний үйл хэрэгт эрч хүчтэй, шууд оролцож, мунхагийн харанхуйд живсэн хамаг амьтны сүнсийг сэрээж, билгийн мэлмийг нь агшин зуур нээж, сансрын хүлээнээс үе үеэр нь, сая саяар нь чөлөөлж, мянга мянгаар нь гэгээрэлд хүргэж, шавь нарынхаа өмнөөс урьд цаглашгүй төрлийнх нь үйлийн үрийг өөртөө авч байсан ийм аугаа үйл хүн төрөлхтний түүхэнд байсангүй.

Их Багш Чин Хай хамгийн дээд есдүгээр ертөнцөөс бууж ирсэн Бурхан болохоо 2005 оны Унгарын олон улсын даяан бясалгалын үеэр, мөн 2010 онд Мексикийн Канкунд “Байнга өөрийгөө огоорон өгөөмөр хандах нь” ном тайлахдаа баталсан юм. Оройн Дээд Их Бурхан өөрийгөө хүлээн зөвшөөрөх нь бүх л орчлон ертөнцөд хамгийн дээд адислал байдаг гэж Бхагавад Гита номд тэмдэглэсэн байдаг билээ.

ХАМАГ ТӨРӨЛХТӨН АВРАГДАН ГЭТЭЛГЭГДЭХ БОЛТУГАЙ


Таныг хүндэтгэсэн



Л.Алтанхуяг

ГАРЧИГ

| | |
|---|----|
| ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ | 3 |
| АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛ ГЭЖ ЮУ ВЭ? | 9 |
| АВШИГ ХҮРТЭХҮЙ..... | 11 |
| ДЭЛХИЙ НИЙТИЙН БЯСАЛГАЛЫН ЦАГ | 12 |
| ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ДЭЛГЭРЭЛТ | 13 |
| ЗӨВ ЗАМ МӨР | 14 |
| ОЮУНЫ ХҮЧ УЛС ОРОНД ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛ АВЧИРДАГ | 15 |
| БЯСАЛГАЛ ЧУХАЛ БОЛОХ НЬ..... | 16 |
| ПАРИСЫН ДИЯАН..... | 18 |
| БЕРМУДЫН ГУРВАЛЖИН БА ҮЙЛИЙН ҮР | 20 |
| ТАМЫН ЗАМ, ГАРЦУУДЫН ТЭРГҮҮНҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ..... | 22 |
| СҮНСЛЭГ АДИСЛАЛТ ШУЛУУНУУД БОЛОН ДИВААЖИНГИЙН ҮҮД | 24 |
| ОНЧ МЭРГЭН ҮГСЭЭС..... | 25 |
| СЭРЖ СЭХЭЭРЭГТҮН..... | 26 |
| ШАВЬ НАРЫН БАЙГУУЛСАН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД | 27 |
| ИХ БАГШИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ | 28 |
| НҮБ-ААС МОНГОЛ ХҮН ШАГНАЛ ХҮРТЖЭЭ | 30 |
| БОГД ОЧИРВААНИЙ ТАХИЛГА БЮУУ ИХ БАГШИЙН ХАЙР АДИСЛАЛ | 31 |
| ИХ БАГШ ЧИН ХАЙН САНААЧИЛСАН ШАГНАЛЫН ЭЗЭД | 32 |
| ГЭГЭЭЛЭГ ХҮН УЛАМ ОЛОН БОЛОХ БОЛТУГАЙ | 34 |
| ИХ БАГШ ЧИН ХАЙН ГЭРЭЛТ БАРИМАЛ СҮНДЭРЛЭЛЭЭ | 36 |
| ХҮН БАЙХЫН ҮТГА УЧИР | 37 |
| УРГАМАЛ ХООЛНЫ ЗООГИЙН ГАЗРУУД | 39 |
| ИХ БАГШИЙН НОМУУД | 41 |





ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ




Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Вьетнамд (Ау Лакт) 1950 онд төрсөн. Хүүхэд ахуй цагаасаа мацаг хоол идсэн. Сурагч байхдаа эмнэлгийн өвчтөнүүдийг асран, сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, ядарч зүдэрсэн хүмүүс, шархадсан зовсон амьтдад өөрийн чадлын хэрээр тусалдаг байжээ. Насанд хүрмэгцээ Их Багш Чин Хай Европт очин суралцаж, тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт орчуулагчаар ажиллаж байхдаа шинжлэх ухаан, анагаах ухааны хошой докторын зэрэг хамгаалсан Герман эмчтэй гэрлэж аз жаргалтай амьдарч байсан хэдий ч амьдралын зорилго болсон оюун санааны гэгээрлийг зогсолтгүй эрж хайсаар байжээ.

Нөхөр нь Их Багшийн мятаршгүй чин эрмэлзлийг дэмжиж, гэрлэлтээ цуцлахыг зөвшөөрсний дүнд тэrbээр Үнэн Ёсыг хайж олохоор Гималайг зорьсон юм. Олон жил хайсны эцэст хүмүүн бидний жинхэнэ мөн чанар болсон дотоодын Гэрэл ба Аялгууг бясалгадаг Арьябалын номын цогцыг уламжлан өгсөн амьд сэргүүн багшаа олж, төгс гэгээрэлд хүрчээ.

**Шинэ Эринийг Гийгүүлэгч
Бурхан Төгс Гэгээрсэн Их Багш Чин
Хай, дэлхийн оюун санааны удирдаач
түүхэн энэ хүн хэн бэ?**

“Очир огтлогч” сударт тэмдэглэснээр Бурхан Багш бээр ирээдүйн таван зууны эцэст дээдийн ном машид эвдрэхийн цагт ариун энэ үзлийн судрын номлолд эзэн болох бурхад бодьсадва нар төрөхийг айлдсан байна. Эртний Энэтхэгийн Бурхны шашны уламжлалд Ялж Төгс Нөгцсөн (Шагжамуни) Бурхны шашныг “тав, таван зуун” жил оршин дэлгэрнэ хэмээх бөгөөд тэдгээрийн “төгсгөл цаг” бүр нь таван зүйлийн цөвийн улмаас шашин доройтно гэж үздэг байна. Бурхны шашин 2500 жилийн дараа буурна гэвэл энэ нь Монгол орны хувьд ардын хувьсгалын үетэй таарч байна. Энэ цагаас шашны гол агуулга болсон гэгээрэл үндсэндээ орхигдоод байхад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бээр гэгээрлийг аль нэг шашны харьялал, өмчлөлөөс салгаж, дэлхийн хүн төрөлхтний үйл хэрэг болгон мандуулж байгаа билээ.



XIX зууны физикч, гэгээнтэн, зөнч хатагтай Блаватская (1831-1891)-гийн зөгнөлд: "Гэгээрсэн нэгэн 1950-иад онд Азид төрнө. Бид Калийн харанхуй эриний 5000 жилийг ардаа хийх гэж байна. Ингээд Гэрлийн эрин үе эхэлнэ. Оюун санааны шинэ залуурч Барууны ертөнцөд 1975 онд очно" гэжээ. Их Багш Чин Хай 1950 онд Өмнөд Вьетнамд төрж, 1972 онд Европт очиж, 1975 онд европын иргэн болжээ.

XI-XII зууны Францын зөнч Жаны шүлэглэсэн зөгнөлийн номыг "Le livre des prophètes," нэртэйгээр Editions Jean-Claude Lattes хэвлэлийн газар 1994 онд хэвлэжээ. Энэ зөгнөлд Их Багш Чин Хай, түүний сургаал номлол шинэ эринийг хэрхэн залахыг ихэд дэлгэрэнгүй буулгасан байна. Тухайлбал: "2000 оны хавиас зөвхөн эрэгтэй хүн Их Багш байхаа болж, нэгэн эмэгтэй тодрон шинэ эриний аугаа ээж болно. Мянганы дараах мянганы эх тэр бээр мянганы дараах мянганыг Гэрлийн эринд шилжүүлнэ. Энд зөвхөн энэрэл хайр, өглөг буян, мөрөөдөл ноёрхлоо тогтоож, хүсэл бүхэн биелнэ (Их Багшийн Гэрэл, аялгууны бясалгал, баясалгагчдыг хэлж байна). 2000 оны хавьд ийм зүйл тохиосноор хүн төрөлхтний билгийн мэлмий ашгүй нэг нээгдэж, оюун ухаан нь сэтгэл болон биед хоригдсон хоригдол байхаа болино"… Мянганы дараах Мянганы эхний харанхуй өдрүүдийн хойно аз жаргалтай өдрүүд эхэлнэ. Хүн төрөлхтөн жинхэнэ хүний зам мөрийг дахин олж, эх дэлхий зөв голдрилдоо орно" гэжээ. (Цөвүүн цаг буюу Калийн эриний эхний харанхуй 5000 жил гэж зарим зөгнөгчийн нэрлэсэн энэ үе 2000 оны хавьд дуусч Гэрлийн эрин эхлэхийг зарим зөгнөгч Мянганы дараах мянган гэж нэрлэжээ).

Бүх зөгнөл нь биелсэн гэгддэг сэргэн мандалтын үеийн францын алдарт зөнч, эмч Ноstradamus Их Багш Чин Хайн төрөхөөс эхлээд сургаал номлол нь даян дэлхийд түгэхийг зөгнөн хэлсэн байна. Тухайлбал:

..“Ирээдүйг айлдагчийн шувтаргын өмнөх нэр, Эмэгтэй бээр өөрийн чимээгүй өдрийн адилаар Дианагийн өдрийг бий болгоно:
Тэр гайхмаар зах хязгааргүй аялж,
Хүмүүсийг үй олноор нь зовлонгоос гэтэлгэж чөлөөлнө.”

Зөнчийн нэр болох NostradAMUS-ын шувтаргын өмнөх нэр нь Сума гэсэн нэр байгаа нь Их Багшийн нэртэй (Сума Чин Хай) тохирч байна.


"Эмэгтэйн чимээгүй өдөр" гэдэг нь дуу хураасан даяан бясалгалыг хэлж байхын дээр Их Багш жил бүрийн сарны баярыг даяан бясалгалын өдөр болгосон байдаг. Ийнхүү Диана (Cap)-гийн өдөр гэдэг нь сарны бясалгалыг хэлжээ.

“Эмэгтэй бээр гайхмаар зах хязгааргүй аялж,

Хүмүүсийг үй олноор нь зовлонгоос гэтэлгэж чөлөөлнө.”

Их Багш бээр дэлхийн бараг бүх оронд айлчилж, 325 удаа ном тайлжээ. 1999 онд зөвхөн 1 сарын дотор л Европын 18 оронд

айлчилсан байж жишээтэй. Ийнхүү дэлхийн олон сая хүнд Авшиг хүртээжээ. Хэн нэг нь Их Багшаас Авшиг хүртвэл урагш 5-7 үе нь чөлөөлөгдөж, үүнээс ч илүү үеийг, өөрөөсөө хойших мөн төчнөөн үеийг гэтэлгэх ба энэ үеүдэд хамаарах мал, нохой, муур ч чөлөөлөгдөх юм. Тухайн авшигтны ах дүү, хамаатан садан төдийгүй анд найзууд, таньдаг хүмүүс цөм чөлөөлөгдхийг Чин Хай Багш бээр 1993 онд Женевт “Биднээр дамжуулан үйлдэхийг Бурханд зөвшөөрчих” ном тайлахдаа айлджээ. Гэтэлгэж чөлөөлөх гэдэг нь дээш Зертэнцийг давуулж ахин төрөл авахааргүй болгохыг хэлж байна. Их Багшаас Авшиг хүртсэн олон сая хүний цаана энэ олон үе, олон хүн, амьтныг хамарсан чөлөөлөлт явагдаж байна гэвэл энэ нь үгээр хэлж, тоогоор илэрхийлэх ч амаргүй үйл явдал юм. Их Багшийн “Агшин зуур билэг нээгдэхийн түлхүүр” 4-р ботид тэмдэглэснээр Авшиг аваад Будда болох юм. Энэ Будда нь харсан бол, сонссон бол гэтэлгэнэ гэвэл энэ дэлхийд ямар их чөлөөлөлт явагдаж байгааг төсөөлж болно.





Дараагийн зөгнөлд Их Багшийн төрөхийг болон сургаал номлол нь дэлхий даяар түгэн дэлгэрэхийг тодорхой зөгнөжээ.

“Цөхрөнгөө барсан тэр цаг дор замаасаа нэгэнт хазайсан сүм хийд эмэгтэйн агуу төгс бурханлиг чанарыг оройлон дээдэлнэ... тэрбээр дэлхийнхнийг хүлиэнгүй боолчлогдоос аварч Марсын хамгаалалтанд авна. Савнаасаа хальж бадарсан тэрхүү гал хэдийнээ дэлхий даяар түгнэ...”

Шашны гол үүрэг болох хүмүүний гэгээрэл орхигдон, лам сүмийн ажил нь ойр zuурын заслаар хязгаарлагдсан шашны бууралтын үе нь Чин Хай Багшийн төрсөн, өсөж торnisон цаг хугацаатай давхацдаг. Их Багш Чин Хай эдүгээ нэгэнт дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн зүтгэлтэн бөгөөд Тэрээр 1999 онд Өмнөд Африкт болсон дэлхийн шашны их хурлыг нээж үг хэлсэн билээ.

“Тэрбээр дэлхийнхнийг хүлиэнгүйн боолчлогдоос аварч Марсын хамгаалалтанд авна...” Энэ хүлиэнгүй боолчлогдол гэсэн нь оюун санааны харанхуй байдлыг хэлжээ. Хүмүүний хөдөлгөгч хүч нь тархи бус сүнс болохыг мэдсэнээрээ дэлхийн сая сая хүн эдүгээ энэ боолчлогоос чөлөөлөгдж байна. Марс гэж гал буюу гэрлийг хэлжээ. Гэрэл бол Бурхны мөн чанар бөгөөд ийнхүү дэлхийн хүмүүс Бурхны авралд багтахыг зөгнөжээ.

“Савнаасаа хальж бадарсан тэрхүү гал хэдийнээ дэлхий даяар түгнэ...” Энд яригдаж буй “гал” бол эдүгээ нэгэнт дэлхий даяар дэлгэрсэн Их Багш Чин Хайн Гэрэл, Аялгууны бясалгал юм.

Дараагийн зөгнөлд Чин Хай Багшийн гэгээрлийг мадаггүй зөгнөж хэлсэн байна.

“Уулын оргилд мандсан шөнө дундын сар, Билгүүн залуухан бүсгүй түүнийг оюуны мэлмийдээ тольдоно:

Шавь нар нь Түүнийг үхэшигүй мөнхлөхийг чармайна

Бүсгүйн билгийн мэлмий, мутар бас цээж, хамаг бие нь гал дотор оршино.”

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бясалгал нь бурхны гэрэл (зөгнөлд гал гэж зөв нэрлэжээ) ба аялгутай холбогдоноор бясалгагч өөрөө гэрэл, аялгуу болон хувирч буй дотоод хүчний хийгээд билгийн мэлмий нээгдэх буюу нээгдсэн үеийн бясалгал юм. Сүнсийг ийнхүү төгөлдөржүүлснээр хүмүүн бээр үхэшигүй мөнхийн хутгийг олдог буюу энэ нь гэгээрэл болой. Ийм бясалгалын явцад сар, нар, бурхны орон, бурхад, байгаль гэх мэт нь билгийн мэлмийд үзэгдэхийг зөгнөлийн эхэнд сараар төлөөлүүлэн *“Уулын оргилд мандсан шөнө дундын сар, билгийн мэлмий, мутар бас цээж, хамаг бие нь гал дотор оршино.”*

Гэрэл, аялгууны бясалгалын мөн чанарт хүрч, хүмүүн оюун ухааныхаа гэрэл дотор хамаг цогцороо мандсан байдлаар Их Багшийн гэгээрлийг зөгнөлд гайхмаар оновчтой тайлсан байна.

Хос биет (хувилгаан бие) хүүхдийг сүм олзуурхаж,

Ламын баатарлаг хийгээд аль удмын цус гэчижээс нь өмнө:

Эмэгтэйн алдар хүнд хэл яриагаар, адистат аялгуугаар түгж,

Цагаас урьтаж төрсөн эрүүл саруул хос биетийг тэр мөн гэж хэн нэг нь таана.

Зөгнөлд хос биет гэсэн нь Их Багшийн хувилгаан биеийг хэлжээ. Их Багш Сума Чин Хай хэмээх Бурхан бээр Гиммлайн их ууланд 450 настай Кудачи багшийгаа олж, залуудаа Төгс Гэгээрэлд хүрсэн нэгэн билээ. Шинэ эриний залуурчийн төгс гэгээрсэн тэр мөчөөс хүн төрөлхтний Алтан үе эхэлж 30 шахам жил болж байна. Гималайгаас буух Тайваньд оршуулгын газрын дэргэдэх жижиг сүмийн буруу харсан жижиг өрөөнд битүүмжлэн бясалгаж байхуйд нэгэн бороотой орой тэндхийн хэсэг хүн ирж, Багшийг төгс гэгээрсэн нэгэн гэж мэргэ төлөгт буулаа гэлцэн адис хайрлахыг гүйснаар дэлхийг адислах Бурхны аврал түгэн дэлгэрсэн түүхтэй. Үүнийг зөгнөлд *“Эмэгтэйн алдар хүнд хэл яриагаар, адистат аялгуугаар түгнэ”* гэсний хэл яриагаар гэдэгт Их Багшийн хүмүүнлэгийн их үйл хэргийг хамтатган зөгнөхийн дээр “Адистат аялгу” нь Түүний Гэрэл ба Аялгууны бясалгал дэлхийд түгэн дэлгэрэхийг хэлжээ. Их Багшийн бясалгалын төв дэлхийн 77 орны 202 хотод ажиллаж байна.

“Үдтэл хүлээлгэсэн тэрбээр ирж өгөхгүй дунишаар.

Азид мэндэлж Европт суурьшина,

Агуу Гермесээс (галаас) илгээгдэх нэгэн,

Азийн бүх хаадуудаас дээр өргөмжлөгдөнө.”

Багш Чин Хай Өмнөд Вьетнамд төрж, Англи, Франц, Германд боловсрол олсон ба европын хоёр орны иргэн, АНУ-ын хүндэт иргэн юм.

“Агуу Гермесээс (галаас) илгээгдэх нэгэн.” Агуу Гермес бол эртний Грекийн Бурхны элч. Энд Бурхны элч гэгдэж буй Их Багш Чин Хай бээр 1983 онд Энэтхэг, Тайвань, Германд, 1984 онд Америкт Авшиг өгч эхэлсэнээс хойш бясалгал нь бүх шашин шүтлэгтэй хүмүүсийг хамарч, дэлхийн олон арван сая хүнийг оюун санааны хөгжилд удирдан залж байна .

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 2006 оны Гусигийн Энх Тайвны Шагнал, 27 дахь Телли шагналын тэргүүн байрын мөнгөн цом (2006), Лос Анжелесын хөгжмийн долоо хоногийн сайшаал (2002), Дэлхийн оюун санааны удирдагч шагнал (1994), Дэлхийн хүмүүнлэг иргэн (1994) зэрэг шагнал хүртжээ. АНУ-ын төр засгаас жил бүрийн 10 дугаар сарын 25 болон 2 дугаар сарын 22-ны өдрийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өдөр” болгосон байна. Их Багш Чин Хайд АНУ-ын Ерөнхийлөгч Брак Obama Сайн үйлсийн төлөөх Ерөнхийлөгчийн шагналыг 2010 онд хүртээжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дуу хөгжмийн “Дуу хөгжмөөр энх тайван, эв нэгдэлд хүрэхүй” хандивын концертыг АНУ-ын Лонг Бийч (1996), Вашингтон (1997), Холливудод (1998) тоглож, орлогыг нь өнчин хүүхдийн асрамжийн газруудад хандивлажээ.

Хүн төрөлхтний оюун санааны удирдагч, соён гэгээрүүлэгчийн төдийгүй хүмүүнлэгийн хийгээд цаг уурын өөрчлөлтийн тулгамдсан асуудлаар хийж буй Их Багш Чин Хай хэмээх түүхэн хувь хүний асар далайцтай ажлууд нь зөнчийн зөгнөснөөр үнэндээ Азийн хаадаас ч давж дэлхийн хэмжээнд хүрчээ.

*“Жинлүүр барууны орнуудыг удирдаж гэмээнэ,
Тэнгэрийн болон дэлхийн хуульд нийцүүлнэ,
Азийн хүч сулрахыг хэн ч үзэхгүй,
Ямартаа ч долоо амжилттай журамлагдах
хүртэл.
Их долоо дахь тоо тохиох жил, |2+0+1+4|
Амьтны амь хөнөөж тоглогчидтой нүүрэлдэж
Их мянган |2000|-аас холгүй,
Үхдэлүүд булинаасаа өндийхүй дор,
Эрт орой хэдий боловч та их өөрчлөлтийг
үзэх болно.
Хэтийдсэн тэрхүү аймшиг, гаслан гамигийн
дараа,
Сар Сахиусан тэнгэрийн залуурт эргэн очиж,
Диваажин амсхийнэ.”*

Жинлүүр гэдэг нь Их Багшийг хэлжээ. Жинлүүрийн орд тохиосон 1972-1984 онд Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд өөрийн номлол сургаалаа хайлаж эхэлсэн ба 1972 онд Тэрээр Европт сурьшиж, 1983 онд Энэтхэг, Тайвань,



Германд, 1984 онд АНУ-д айлчилж Авшиг хүртээж эхэлсэн байна. Ийнхүү 1983 оноос эхлэн дэлхийн хүний хөгжил, үйл ажиллагаа нь тэнгэрийн хуулинд зохицон явагдах боломж нээгдэж, энэ нь эдүгээ дэлхий дахиньг хамарч байна. Их Багш 1995 онд Германы Гамбургт айлдахдаа “Авшиг бол сая жилд ганц тохиох боломж”, 2001 онд АНУ-ын Флоридад “Авшиг хүртэх нь орчлонгийн хамгийн том бэлэг” гэснээс үзвэл энэ нь улс орнуудыг удирдахтай жишимгүй, хүн төрөлхтний хувь заняны жинхэнэ удирдлага болох нь харагдаж байна.

Тэнгэрийн хууль гэдэг нь Хайрын хууль, Үйлийн үрийн хууль бөгөөд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай айлдахдаа: “Хайр юм бүхнийг угаан ариусгаж, эвдэн нурааж, хил хязгаар бүгдийг уусган ариусгадаг. Энэ агуу их дотоод хүчийг яагаад хайр гэж нэрлэдэг вэ? Яагаад гэвэл энэ хайр хамаг нүгэл хилэнцийг маань учлан өршөөж, угаан ариусгадаг юм. Урьд өмнө ямар муу үйл хийсэн нь хамаагүй. Хайранд нүгэл хилэнц, зааг хязгаар, өнгөрч улирсан гэж үгүй, зөвхөн одоо л гэж бий. Энэ хайртай холбогдох, үүнийг мэдрэх л юм бол нялх хүүхэд мэт ариусдаг. Тиймээс л хайр гэж нэрлэдэг юм” гэж айлдజээ.

Улс орны удирдлагыг тэнгэрийн болон дэлхийн хуульд нийцүүлснээр “Азийн хүч сулрахыг хэн ч үзэхгүй”, энэ байдал “Ямартаа ч долоо амжилттай журамлагдах хүртэл.” үргэлжлэх болж байна. “Азийн хүч сулрахыг хэн ч үзэхгүй” гэсэн нь өрнө, дорнын шинжлэх ухааны болон уламжлалт гүн ухааны байр суурийг хэлж буй бөгөөд Их Багш Чин Хайн сургаал номлол дорныг улам алдаршуулахыг зөгнөжээ.

Зөгнөлийн дараагийн хэсэгт дэлхийг сүйрэлд хүргэх аюул, түүний шалтгааныг, тухайлбал: тонилгосон амьтдынх нь хүүр өндөлзөн босч амь хөнөөж тоглогч нартайгаа нүүр тулснаар хэтийдсэн аймшиг, гаслан гамшигийг үүднэ хэмээн зөгнөжээ. Өөрөөр хэлбэл, амьтдыг үй олноор нь алж хядсаны гайгаар дэлхий хэтийдсэн их аймшиг, гаслан гамшиг нэрвэгдэх болж таарч байна.

АНУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тайлан болох “Мал аж ахуйн урт сүүдэр” номонд бичсэнээр дэлхийн хүний хэрэглээг хангахын тулд жилд 56 тэрбум мал, гахай нядалж, АНУ дангаараа цагт 1 сая шувууны амь

хороодог гэвэл цаана нь шувуу, загас хичнээн тэрбумаараа бидний гарг амиа алдаж байгаа балмад явдлын хариуцлага дэлхийн хүн төрөлхтөнд хэрхэн ирэхийг зөгнөжээ. "Хэрэв бид бусдын амь насыг хохирохгүй бол бидний амь нас ч аюулд өртөхгүй. Энэ бол учир шалтгаан, үр дагавар, үйлийн үрийн хууль юм" гэж Их Багш Чин Хай "Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ" номондоо айлдсантай Нострадамусын зөгнөл таарч байна.

Их Багш Чин Хай 1994 онд "Шүүлтийн өдрийн сүйрлээс эх дэлхийгээ аварья" сэдвээр Токиод ном тавихдаа: "Хэрвээ бид амьдралын хэв маягаа өөрчилж, цагаан хоолтон болж, мод тарьж эхэлвэл дэлхий маань 10 жилийн дотор л одоогийнхос өөр болж бид аврагдах болно" хэмээн айлдаж уриалсан боловч энэ их буяныг бид нэгэнт алдсан билээ.

Дэлхийн байдал хүндэрсээр байгаатай холбогдон цагаан хоолны буян бидний үйлдсэн гэм нүглийг цайруулж дийлэхээ нэгэнт болж, эдүгээ хүмүүс нийтээрээ ногоогоор хооллох буяныг эрхэмлэх авралын ганцхан зам үлдээд байгаа билээ.

Сар Сахиусан тэнгэрийн залуурт эргэн очиж, Диваажин амсхийнэ.

"Адислагдсан Андын найрсаг аялгуу газрын доорх зүрх болно,

Хүмүүний гал тэнгэрийн аялгуунд сүлэлдэнэ

Сахиусан тэнгэр гэдэг нь Их Багшийг хэлжээ. Дэлхийн зовлон дуусахад диваажин ч мөн амсхийж байна. "Адислагдсан Андын найрсаг аялгуу газрын доорх зүрх болно" гэсний "Адислагдсан Анд" нь Их Багшаас Авшиг хүртсэн шавь нар, "найрсаг аялгуу" гэдэг нь бурхны дуу хоолойтой нэгдэх аялгууны бясалгал, энэ бясалгалыг битүүмжилсэн байдалд хийдэг тул бясалгалын төвүүдийг газрын доорх зүрх гэж зөгнөх боломжтой юм. Их Багш бээр анхны бясалгалын төвүүдийг байгуулсны эхнийх нь болох Тайваний Мияоли дахь Шиху төвд 1988-1989 онд газар доорх бясалгалын 176 агуй байгуулсныг чухамхуу "газрын доорх зүрх" гэж онож зөгнөжээ. Ийнхүү бясалгаснаар энд "гал" гэж нэрлэсэн дотоодын гэрэл хийгээд тэнгэрийн аялгууны хүчээр "Хүмүүний гал тэнгэрийн аялгуунд сүлэлдэнэ" гэсэнчлэн хүмүүн бээр гэгээрлийг олцгоохыг мадаггүй зөгнөжээ.

Хамаг амьтныг гэтэлгэхийн тухайд гэгээрлээс өөр арга зам гэж үгүй бөгөөд Их Багш Чин Хайн олон шавь нар нь гэгээрлийн баталгаа болж, нэг жилийн өмнөх байдлаар 400 гаруй шавь нь тав дахь түвшинд хүрчээ. Тав дахь түвшин нь Бурхан Багшийн заларч буй, Их Багш хэмээгдэгч бурхдын суудаг орон мөнийг Тэр бээр 2006 онд НҮБ-ын төв байранд тавьсан "Чанагуух ертөнцийн нууц" айлдвартай тайлбарласан байдаг. Бурхны зэрэгт хүрнэ гэдэг нь тоолшгүй олон амьтныг нэгээхэн ч бээр хоцроолгүй таалалдаа болгоон, бүхнийг мэдэгч төгс төгөлдөр билэг билгүүнийг эрхшээсэн хүний хөгжлийн өндөр түвшин юм. Үүнээс ч олон шавь нь бодьсадвагийн түвшинд хүрснийг дээрх тоо харуулна ...

*"Диана хийгээд Меркурийн их мөнгөн эрдэнэс, Төрхөө нуурнаа тольдоно
Урлал шинэ ертөнц рүү тэмүүлнэ,
Бусгүй шавь нартайгаа алтанд умбана"*

Диана бол эртний Грекийн домгийн сарыг эрхшээгч бурхан, Меркурий бол отторгуй хийгээд илч гэрлийн бурхан гэвэл Их Багшийн уран бүтээлийг эдгээр бурхдын их мөнгөн эрдэнэсээр төсөөлөн үзж болох юм. "Диана хийгээд Меркурийн их мөнгөн эрдэнэс," нь Их Багшийн уран зураг, яруу найраг, хувцас болон гоёл чимэглэлийн үнэт эдлэлийн загвар, зохион бүтээлт зэрэг бүх хэлбэрийн уран бүтээлийн дээд ертөнцийн лугаа өнгө зохирлыг, тэдгээр бурхдын их баялагийг дэлхийд буулгасан юм шиг асар цар хүрээг илтгэнэ.

Их Багш бээр уран зураач, яруу найрагч, хувцас болон гоёл чимэглэлийн үнэт эдлэлийн загвар зохион бүтээгч бөгөөд уран зургийн үзэсгэлэн нь европын хэд хэдэн оронд, мөн зохион бүтээсэн хувцасны загварыг нь 1995 онд дэлхийн загварын ертөнц гэгдэх Лондон, Парис, Милан, Нью Иоркт үзүүлжээ. Их Багшийн загвараар үйлдсэн үнэт эдлэлүүд Швейцарын Байзел хотноо болсон Дэлхийн шилдэг загварын үзэсгэлэн, Парисын олон улсын үнэт эдлэлийн үзэсгэлэнд тус тус тавигджээ. Их Багшийн яруу найргийн "Эрвээхэйн мөрөөдөл", "Хуучин цаг", "Алтан дурсамжууд" зэрэг 10-аад номын "Аяндаа бөмбөрөх нулимс", "Эрин зууны хайр" зэрэг ном нь дэлхийн 38 хэл дээр орчуулагдаж, "Миний амьдрал дахь ноход", "Шувууд миний амьдралд", "Эрхэм ариун амьтад" хэмээх уран сайхан, фото зургийн номууд нь дэлхийн шилдэг борлуулалттай номоор шалгарсан байна.

Номын сангийн олон улсын холбооны гишүүн агсан Тайваний Карл Мин Ку "Их Багш Чин Хайн уран бүтээлд хайрын адислал хийгээд эгэлгүй орчлонгийн чанарууд шингэж гоо үзэсгэлэн хийгээд мөнх оршихуйн ертөнцийг цогцлоодог юм" гэсэн нь дээрх зөгнөлийг тодотгож байна.

"Төрхөө нуурнаа тольдоно" гэсэн нь Их Багшийн айваний Шиху-д байгуулсан бясалгалын төвийн дэргэдэх Баруун нуур бөгөөд Багшийн уран бүтээлийн гол газрын нэг, загвар бүтээлийг нь түрүүлж харж тольдог газар юм.

Их Багшийн уран бүтээл нь ямагт дэлхийгээс хальсан өөр хэмжээст хамааралтай байдаг ба басхүү тэрхүү ертөнцуудийг мэдэх хүний хувиар урын сан нь өөр сэтгэлгээгээр баяжсан байдгийг *"Урлал шинэ ертөнц рүү тэмүүлнэ"* гэжээ. Их Багшийн уран зураг, гоёл чимэглэлийн бүтээлийн нэр хүртэл зөгнөлийг батална. "Диваажингийн цэцэг", "Зохирол", "Гэгээрэл", "Хамтдаа дэвшье", "Эрх чөлөө", "Нямба", "Шинэ эрин", "Диваажингийн бороо", "Чөлөөлөлт", "Ирээдүйн Будда", "Билгийн нүд", "Сүнсээр тольдохуй", "Сүнсний хавар", "Гэгээн хун", "Гэрэл, аялгуунд бясалгахуй", "Бяцхан сахиусан тэнгэр" гэх мэт. *"Бусгүй шавь нартайгаа алтанд умбана"*. Их Багшийн гоёл чимэглэлийн алт, мөнгөн үнэт эдлэлүүд нь Түүний сая сая шавь нарын төдийгүй дэлхийн хүмүүсийн байнгын хэрэглээ болсныг нүдээр үзсэн юм шиг зөгнөжээ.



Шинэ эриний оюун санааны залуурч Их Багш Чин Хай, Түүний хүн зон, дэлхийг адислан гийгүүлэхийг зөгнөсөн олон бадаг зөгнөл ийн цааш үргэлжилжээ. Бурхныг таниасай билээ гэх чин эрмэлзэл хүмүүнд хүрээсэй хэмээн залбирч зөгнөлийг үүгээр жаргаасуу.

Хамаг амьтан цаглашгүй олон төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэж, б төрлийг дамжин төрж, өвдөж, үхэж зовж шаналсан энэ гамшгаас хагацан чөлөөлөгдөж, гурван ертөнцийг гэтлэх З боломжийг Чин Хай Багш номлосон байна.

1.Итгэн дагах. Их Багш болон Гэгээнтнүүдийн аль нэгэнд итгэн сүсэглэж, хорвоог орхих үед тань гэтэлгэж өгөхийг гүйх.

2.Их Багшаас авшиг хүртэх. Энэ нь зөвхөн өөрийгөө төдийгүй хамаг амьтан хийгээд гэр бүл, үр удмаа хэдэн үеэр нь аварч чадах хамгийн эрхэм зам.

3.Авшиг хүртсэн хүний садан юмуу найз байх. Энэ тохиолдолд та нас нөгчөөд бүр тамд унаачихсан байлаа гэж бодоход ач тань Их Багшаас авшиг хүртэх юм бол та нэн даруй чөлөөлөгдөн тэнгэрийн оронд очих болно. Бас хэрвээ бид авшиг хүртсэн хүний найз нөхөр нь бол Багшийн тусыг хүртэнэ.

Та бурхангүй үзэлтэн байж мэднэ. Гэвч энэ нь таныг учлах шалтаг болохгүй биз ээ. Бидний ойлгодоггүй олон юмын л нэг нь. Шинжлэх ухааны мэдлэг гээчээр түрүү барьж зөрүүдэлснээрээ бидэнд хожсон юм нэгээхэн ч үгүй, харин алдсаныг нь тооцож баршгүй. Бид өөрсдийгөө таних аргагүй болсон нь хамгийн том алдсан юм маань. Шинжлэх ухаан

харамсалтай нь энэ хохирлыг төлж өгч чадахгүй. Та бидний өөрийгөө гэж бодож байгаа маань бид хараахан биш аж. Та бид махбод, хувцсаа л харж байна. Таны харьялал бол оюун ухаан тань. Бидний ойлгохгүй юм их бий. Үүний нэг нь Гэгээрэл, Их Багшийн “Гэгээнтэн бүхэнд өнгөрсөн бий, гэмтэн бүхэнд ирээдүй бий” гэсэн айлдварт хүмүүний боломж хийгээд чадамж бүхэлдээ цогцолно.

Бурхангүйн үзэл нь өөрөө бурангуй үзэл, хүмүүний харанхуй мунхагийн хэмжүүр, үр дүн нь оюуны хоосрол юм байна. Амьдаа өөрийн бурханлиг чанарыг таньж гэмээ нь юутай гайхамшигтай вэ. Үүний учир хүн бүрийн төлөө залбирсуу.



Их багш Чин Хайн зурсан “Чулуун агуй” зураг



АРЬЯАБАЛЬН БЯСАЛГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Та бүхэн гэгээрэлд хүрдэг янз янзын арга, бясалгын тухай сонссон байх. Үнэхээр ч олон янзын арга байдаг. Гэхдээ төгс гэгээрэлд хүргэж өгч чадах цорын ганц арга л бий. Эхэндээ та янз бүрийн зам мөрөөр явж болох л юм. Гэвч та оргилд хүрэхийг хүсч байгаа бол энэ зам мөрт л орох хэрэгтэй болно. Энэ арга бол чанагуух ертөнцийнх бөгөөд хүний үг хэлээр тодорхойлон гаргах аргагүй юм.

Цаглашгүйн дээд их багш маань энэ талаар дурдахдаа "Бясалгын энэ эгэл жирийн аргатай танилцахаас өмнө би өөрөө олон янзын аргыг туршиж үзсэн. Тухайлбал: Тувдийн Бурхан шашны нууц тарнийн ёс, Тайланд, Бирмийн янз бүрийн бясалгын сургаал гэх мэт... энэ бүхэн маш их цаг хугацаа авахаас гадна ийм аргаар бясалгахад өдий төдий багаж хэрэгсэл шаардлагатай болдог. Харин Арьяабалын /Гуан Инь/ бясалганд ийм зүйл хэрэглэдэггүй. Энэ арга бусдыгаа бодохноо хамгийн энгийн. Та хаана дуртай газраа цэцэрлэг, автобус, галт тэргэнд бясалгал хийж, Бурхны энергитэй нэвтрэлцэж болно. Аврал хамгааллыг мэдрээд зогсохгүй Бурхантай нүүр нүүрээ харалцах болно. Би та бүхнийг надад итгэ гэж гүйж ятгахгүй. Гагцхүү та өөрөө өдөр бүр бясалгаж, туршлага дээр амсаж мэдэрч үз гэсэн билээ..


Мөн Арьяабалын бясалгын аргыг танд уламжлан өгсний дараа та бясалгал хийж, өөрт тань

байгаа энэ нь юу гээчийн хүч юм, өөрөө мартаж орхисон юу гээчийн авьяас чадвар юм, оюун ухааны ямар хэсгийг ашиглагдаг вэ, та хэн юм бэ, ертөнц дахинд ямар байр суурь эзэлж байна гэдгээ дотоод талаасаа эрэн хайх болно. Та эрэн эрсээр, нэгэн цагт олно гэсэн байдаг.

Энэ ертөнцийн болон чанагуух ертөнцийн гэсэн хоёр төрлийн дуу аялгуу байдаг. Энэ ертөнцийн нь бидний сонсгол ба сэтгэлийн ая тухтай байдал. Харин чанагуух ертөнцийн дуу аялгуу нь биднийг Бурхан луу эргэн очиход хөтөлдөг. Хэрвээ бид энэ Үг ба аялгууны урсгалтай ямар нэг харилцаа холбоо тогтоож чадвал тэр цагт Бурхныг яаж олохoo мэднэ эсвэл холбоо тогтоож чадна. Энэ дуу аялгуутай холбогдох чадсан хүмүүсээс амьдралд нь асар их хувирал өөрчлөлт гарахыг үзээгүй хүн нэг ч үгүй. Үүнийг л бид "гэгээрсэн хүн" гэдэг. Бид зөвхөн оюун санааны хувьд төдийгүй материаллаг болон ер нь бүх талаар хөгжин дэвшдэг юм.

Арьяабалын бясалгыг хийхэд амьд сэруүн буй гэгээрсэн багшийн удирдамж хэрэгтэй. Учир нь дараах 2 шалтгаан байна.

Нэгдүгээрт: Багш бидэнд бясалгал хийхийн хамаг үндэс, дүрэм юу болох, бясалгын ёс суртахуун ямар байх, сэтгэл цэвэр ариун, хүсэл эрмэлзлэл нэн өндөр байх хэрэгтэй гэдгийг зааж жолоодно. Ингэвэл бясалгал буруудаж ад оршихгүй, адад мэхлэгдэхгүй.



Хоёрдугаарт: Бид бясалгал хийх үед одоогийн Багшаа олж үзвэл Түүнийг танина. Учир нь бид багшийнхаа гадаад дүрийг таньдаг. Гэтэл одоогийн Багшгүй бол, бясалгал хийж байх үед урьд үеийн Их Багш ирээд биднийг дагуулан аваачих буюу ном тайлж сонсговол энэ нь өнгөрсний жинхэнэ Их Багш мөн эсэхийг бид мэдэхийн аргагүй. Учир нь бид ерөөс үзээгүй. Шагжмуни Будда нөгчөөд нэгэнт 2500 жил болж буй, Есүс Христ яваад бас бараг 2000 жил болж буй. Бидний олж үзсэн нь хүмүүс дүрслэн бодсоноороо зурсан зураг эсвэл гэрэл зураг болно. Иймээс бясалгалын үед тэд бидний дотор илэрч үзэгдэвэл үнэн худлыг нь мэдэх аргагүй. Гагцхүү одоогийн багшаа олж үзвэл сая үнэн худлыг мэднэ.

Жинхэнэ багшийг хэрхэн таних вэ? Энэ маш амархан. Бурхан зөвхөн өгөхөөс биш хэзээ ч авдаггүй учраас жинхэнэ Багш бол юуны өмнө өөрийн ашиг тусын төлөө ямар ч өргөл барьц авдаггүй. Багш танд гэгээрлийн ямар нэг нотолгоо баталгаа өгөх ёстай. Тийм биш бол тэр танд ямар нэг зүйл өгөх чадвартай эсэхийг та хэрхэн мэдэх билээ? Хуурамч Багш цаг ямагт өөрийн бага сага ид шидээ зарлан гайхуулдаг бол жинхэнэ Багш хэзээ ч ийм зүйл хийдэггүй. Зөвхөн оюун санааных нь дэвшилд юмуу санаа сэтгэлийн хувьд нь туслах, өвчин эмгэгийг анагаах, аюул осолтой нөхцөл байдлаас мултлан гаргах хэрэгтэй болсон тохиодолд л шавь нь мэддэг. Тэр үед л шавь багшийнхаа учир холбогдлыг, Багш нь үнэн хэрэгтээ хэн гээч болохыг мэднэ. Жинхэнэ багш хэзээ ч авахгүй. Гагцхүү өгч л чадна.

Бясалгал хийгээд ямар нэг хүслэnt ахуйд хүрвэл тэд яг гэрийн дээвэрт тулсан юм шиг болж хичнээн хүчлэвч түүнийг гэтлэн давж чадахгүй болдог. Зөвхөн Багш ирээд биднийг татах, энэ түр зуурын харш саадыг гэтлүүлэхээс өөр аргагүй болдог. Тэгсний дараа бид үргэлжлэн цааш явна... Багш тусалж хаалга онгойлгон оруулах болно. Багш маань орчин тойрны байдлын замч шиг гэр маань хаана байгааг сайн мэдэх бөгөөд цоожийг онгойлгох тулхүүртэй, хаалга хаана байгааг мэддэг болохоор хаалгыг онгойлгомогц бид дээд хүслэnt ахуйн дуу аялгуу болон ахуйн байдлын талаар ойлголттой болно...

Бид угаас гэрэлтэй бөгөөд дотоодын дуутай байдаг. Үүнийг бидний "Уг чанар", эсвэл "Будда чанар" гэж хэлсэн ч яг адил... Ийнхүү гэрэл аялгууны бясалгалаар бидний үйл түйтгэр угаан цэвэрлэгддэг.

Багш яагаад хүмүүсийг мацаг хоол идуулэх гээд байдаг вэ? гэж олон хүн асуудаг... Max иддэг бясалгагч 2-р зэргийн гэрлийг олдог боловч жинхэнэ үнэнийг олдоггүй. Тэд яаж бясалгасан ч цөм зургаан муу заняаны сансрын хурдэн дотор байдаг. Учир нь сахилгүй

бол жинхэнэ "Самади" байхгүй, жинхэнэ самадигүй бол "Билгүүн ухаан" байхгүй. Хамаг амьтан цөм дотооддоо аялгуутай, билиг ухаантай байтлаа яагаад энэхүү дуу аялгууг "ажиж" чаддаггүй вэ? Учир нь түлхүүргүй болохоор дуу аялгуу хаана байгааг мэддэггүй. Тиймээс хаалгыг онгойлгож өгөх Багшийг эрэх хэрэгтэй байдаг...

Үйлийн үр гэж юу вэ? Ертөнцийн ба хүмүүний гэсэн үйл үрийн 2 хэв маяг байдаг. Ойлгоход амаргүй үл үзэгдэх хүч хүмүүний хуулиудыг жолоодж байдаг. Авшиг хүртсэний дараа урьд насны үйлийн үр арилж алга болно. Гэхдээ Багш энэ амьдралын тань үйлийн үрийг хөндөлгүй үлдээдэг юм. Эс тэгвэл та тэр дороо л ангижирчихна шүү дээ. Бид найз нөхдөдөө тусалж, дэлхий ертөнцөө адислахын төлөө энд хэсэг хугацаанд үлдэх ёстай юм. Дараа нь бид тэнгэрт гарч болох бөгөөд хэрэв та хүсч байвал дуртай цагтаа эргэн ирж болно. Үйлийн үр гэдэг бол нэн шударга, нэн хүчтэй үл үзэгдэх хүч юм. Хийж үйлдсэн бүхэн маань эргээд өөрсдөд маань буцаж ирдэг... Энэхүү ертөнцөд болж байгаа бүхнийг бичиж тэмдэглэх зориулалттай уураг тархи, ухаан бодол, энэ "компьютер" байгаа учраас бидний үйлийн үр байдаг...

Үйл түйтгэр гэж... бидний анхны төрөлдөө хийсэн зүйл бүрийн муу явдал болон төрөл төрөлдөө гаднах үзэгдлээс олсон муу бүхнийг хэлж байгаа юм. Багшаа харах, Багштайгаа хамт байхад бүдүүлэг үйл түйтгэр угаагдан арилах нь тодорхой. Гэвч харагдахгүй мөртлөө баригдахгүй, мэдэгдэхгүй нарийн үйл түйтгэрийг заавал харагдахгүй мөртлөө баригдахгүй нарийн дуу аялгууны урсгал сэтгэгдэшгүй хүчтэй байдаг...

Хэрхэн бясалгах вэ? Анхаарлаа мөнгө зоос юмуу өөр юм руу биш ердөө л Бурхан луу хандуул. Бясалгах чадвар танд угаасаа байж байдаг. Тиймээс ердөө л анхаарлаа Бурхны оронд чиглүүл... Нам гүм газар хөлөө завилж сууснаар ямар нэг зүйл олж чадахгүй. Юуны өмнө та дотоодынхоо хүчтэй харилцаатай болсон байх ёстай. Тэр үед л дотоодын жинхэнэ "Би" тань бясалгал хийж өөрөө өөрийгөө сэргээх болно. Хэрвээ та сэрчихсэн бол таны жинхэнэ "Би" дотоодын тань Бурхан хүч бүхнийг хяналтандaa авна. Жинхэнэ бясалгал гэж юу болохыг гагцхүү жинхэнэ Багш таныг сэргээж арга уламжилж өгсний дараа л та мэдэх болно. Тийм биш бол энэ нь зөвхөн өөрийн бие махбод хийгээд сэтгэл ухамсартайгаа тэмцэлдэж, цаг барсан хэрэг болно. Бясалгах үедээ өөрийн энергиэ нээгээд тэр хэвээр нь орхичихоос болгоомжил. Гэхдээ одоо амьд буй Багш тань таныг муу нөлөөнөөс хамгаална.



Авшиг хүртэх

Авшиг хүртэхүй

Авшиг хүртэх гэдэг нь мөн чанартаа сүнсийг нээх гэсэн угтатай. Бид ил далд янз бүрийн саад тогторг бүрэн автсан байдаг болохоор авшиг гэгддэг зүйл бол бидний "Би" хэмээгчийг болон ертөнцийг адислахын тулд Билгүн ухааны хаалгыг онгойлгож, сүнсийг ертөнц рүү нэвтрүүлэх үйл явц юм. Авшиг хүртэх нь таны амьдрал шинэ урсгалд орсныг илтгэн харуулна. Тэр нь багш таныг гэгээнтнүүдийн хүрээний нэг хүний хувиар хүлээн авлаа гэдгийг илэрхийлдэг. Энэ үеэс та цаашид жирийн хүн байхаа болж яг их сургуульд элсүүт дунд сургуулийн сургач байхаа больдогтой адилаар нэг шат ахисан хэрэг болох юм. Эрт цагт үүнийг авшиг хүртэх буюу бодьмөрт ирэх гэж хэлдэг байжээ.

Авшиг хүртэх үедээ бид тийм ч цэвэр ариун байдаггүй ч дотоодод орших Бурхны хүч болон багшийн нигүүслэлийн ачаар цэвэршин ариусдаг. "Шорон"-гийн хаалгыг цөмлөн гарах үедээ бид дуу аялгуу сонсож гэрэл гэгээ хардагийн учир гэвэл тэдгээр нь материаллаг ахуйн хил хязгаарын цаана байдаг юм. Энэ нь авшиг хүртэх үед бид дээд ертөнцтэй холбогдон цаашид түүнээс салж хагацахгүй болсныг илтгэж байгаа юм.


Билгийн нүд бол тэнгэрт хүрэх хаалга бөгөөд та нар үлэмжийн их ертөнцөд нэвтрэн орох болно. Энэ аргыг дамжуулах үед бид юу ч ярьдаггүй байтал та нар хамгийн дээд гэгээрлийг олж авдаг. Урьд өмнө нь танд хэзээ ч байгаагүй ямар нэгэн зүйлийг олж авах бөгөөд урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй тийм гэм зэмгүй, тийм сайн сайхан, тийм сул чөлөөтэй, хөнгөн байдалтай болж хувирна. Үүнд л авшиг хүртэхийн ач холбогдол оршдог юм. Та Бурхны дуу хоолойн дотоод хэлбэлзлийг энэ чихнийхээ оролцоогүйгээр сонсоно. Бурхны гэрлийг энэ нүднийнхээ туслалцаагүйгээр олж үзнэ. Цаглашгүйн дээд багш Чин Хай маань "Энэ тухай би ярьж чадахгүй нь. Үг хэл, ухаан сэтгэлгээ бол матери ба оюун санааны хүрээнд хамаардаг шүү дээ. Тийм учраас би түүнийг чимээ аниргүй, нам гүмд л дамжуулж чадна. Тийм болохоор бид үүнийг зүрхнээс зүрхэнд, сэтгэлээс сэтгэлд уламжлах гэж нэрлэдэг юм" хэлсэн байдаг.

Авшиг хүртсэний дараа биднийг "жинхэнэ гэрт" маань хүргэж өгөхийн тулд дотоодын гэрэл, аялгуу маань Диваажинд хүрэх замыг гэрэлтүүлэн гийгүүлнэ. Тэгмэгц бид энэ ертөнцөд одоог хүртэл хэзээ ч мэдээгүй явсан тийм их аз жаргал, жинхэнэ ахуй амьдралаа олж авна. Та осолд орох хүндрэл бэрхшээлтэй учрах юм уу хэнд ч хандах аргагүй болсон үедээ ид шидийг үзэж мэднэ. Тэр үед та бурхны хүч чадлыг ухаарч ойлгоно. Тэгээд бурхан таныг хайлж хамгаалж байдгийг мэдэх болно.

Авшиг хүртэхүй гэдэг бол урьд үеийн бүх үйлийн үрийг үгүй болгох бөгөөд аливаа амьтан ирээдүйд эргэх буцаж ирэх боломжийг нь тасалдаг юм. Мөн таны урьд насын бүх нүгэл хилэнц ариусч, заяа төөргийг тань дэлхийн ямар ч төлөгч хэлж чадахааргүй болох юм.

Авшиг нь хүмүүний билгийн мэлмийг нээж сүнсийг хөгжүүлэх адислал, үйл ажиллагаа. Төгс Гэгээрсэн Их Багшаас авшиг хүртэх. Энэ нь зөвхөн өөрийгөө төдийгүй хамаг амьтан хийгээд гэр бүл, үр удмаа хэдэн үеэр нь аварч чадах хамгийн эрхэм зам.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шавь нартаа "Та нар дампуурдаггүй компаний даатгуулагч нар" гэж орчин цагийн үг хэлээр хүн бүрд ойлгогдохуйц айлдсан нь Их Багш бээр шавь нарынхаа, бас өөрт нь итгэдэг хүн бүхний хувь заяаг хариуцахаар батлан дааж буй хэрэг юм.



Их багш Чин Хайн зохион бүтээсэн дэнлүү.

ДЭЛХИЙ НИЙТИЙН БЯСАЛГАЛЫН ЦАГ

*Веган дэлхий
Амгалан дэлхий*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 2011 оны 4 сарын 21-ний өдөр АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелос хотод байрлах Суприм мастер Телевизийн ажилчидтай хийсэн видео конференцоор бясалгал болон залбирал хийхийн ач холбогдол хийгээд хүн төрөлхтөнд хандаж гаргасан уриалгыг танилцуульяа.

Бүх шашны бүлгүүд, янз бүрийн итгэл үнэмшил бүхий оюунлаг сүнслэг бүлгэмүүдийн бүхий л гишүүдэд хандаж чин сэтгэлээсээ уриалах нь:

Орчлон өртөнцийн бүх зүйл энергиэс бүтсэн бөгөөд түүнийг бид туурвигч хүч гэдэг. Энэхүү энерги зүг бүрт тархан цацарч янз янзын өртөнц төрөлтөн болж хувирдаг. Тэгээд энэ төрөлтнүүд өөр өөрийн сэтгэлгээ буюу ухамсын түвшинтэй болж бие биетэйгээ харилцан шүтэлцэж байгаагаас хамааран өөр маягийн энергийг үүсгэнэ. Бид түүнийг хоёр төрөлд хуваана. Эхнийхийг нь эерэг энерги буюу эзэн бурханлаг чанар, оюун санааны хүч, бурхан чанар гэдэг. Хоёр дахь төрлийг сөрөг хүч, сайн сайхантай эсрэгцэдэх хорт муугийн буюу ҳаранхуйн хүч гэдэг. Иймд сайн сайхан эерэг энерги нь сөрөг энергитэй зэрэгцэн оршиж байдаг. Хэрэв сахиусан тэнгэр, дэлхийн хүмүүс аливаа төрөлтөн сайн сайхан, эвлэрэл зохицол, хайр нигүүслэлийг төрүүлж хамтран зүтгэж байвал энэ энерги нь эзэн бурхны хүч эерэг хүчиний төрөлд багтана. Хэдийчинээ олон төрөлтөн ийм сайн сайхныг үүсгэнэ, манай дэлхийн төлөв байдал төдийчинээ эерэг хүчтэй байх болно. Хэрэв үзэн ядалт, сөрөг хандлага, үг хэл, үйл хөдлөл гаргавал сөрөг нөлөөнд нэмэр болно. Үүнийг бид хорт муу зүйл гэнэ. Энэ нь дэлхий болон өөр өртөнц дээр ч тэр их үзэн ядалт, дайн байлдаан болон үл

Хэд хэдэн цагийн хуваарийг та бүхэнд санал болгоё.

Дэлхий Нийтийн Бясалгалын Цаг:

- A. Улаанбаатарын цагаар өдөр 11:00 - 12:00 цаг**
- Б. Улаанбаатарын цагаар өдөр 16:00 - 17:00 цаг**
- В. Улаанбаатарын цагаар орой 19:00 - 20:00 цаг**
- Г. Улаанбаатарын цагаар шөнө 03:00 - 04:00 цаг**

зохицлыг авчирдаг. Бидний дэлхий дээрх эн тэргүүний үүрэг бол дэлхийгээ бурхны орон болгохын төлөө, хамаг амьтан таатай сайхан амьдрахын зэрэгцээ өндөр дээд ухамсар луу алхам алхмаар дэвшихийн төлөө дэлхийгээ адислах явдал билээ. Өөрөөр хэлбэл бид дотооддоо байх бурханлаг хүчээ сэрээн ашигласнаар орчлон өртөнцийн өөрчлөлт хөгжилтөнд тус дэм үзүүлж байдаг юм.

"Та өөрийн сонгосон ямар ч замаар байсан хамаагүй эерэг сайхан энергиэр гараг дэлхийгээ аврахын тулд боломж гарах бүрт дээрх цагуудад бясалgal хийгээрэй. Хэрэв та бясалгаж мэдэхгүй байвал биднээс суралцах бүх боломж нээлттэй байна. Та энэхүү бясалгалын аргыг www.SupremeMasterTV.com-оос лавлаарай.

Хэрэв та бясалgal хиймээргүй байгаа бол залбирал үйлдээрэй. Та бүхий л зүрх сэтгэлээрээ, хайраар бурханд хандан хичээнгүйлэн залбираарай. Олуулаа бясалгаж залбирах тусам олны хүч оломгүй далай гэгчээр энд хүн бүрийн хүчин чармайлт их чухал шүү. Олон хүний нэгдмэл энерги маш их хүчтэй болох тул нэгэн цагт нэгэн хичээл зүтгэлээр нэгдэж бясалгаж, залбирваас маш их эерэг сайхан үр дүнд хүрэх болно. Ингэснээрээ манай дэлхий өршөөл энэрэл нигүүлсэлтэй гараг болон өөрчлөгдж, бид дэлхий дээрээ өнө мөнхийн амар амгаланд орших болно. Эрхэм хүмүүс та бүхэнд амжилт хүсье" гэжээ.



ТӨГС ГЭГЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ДЭЛГЭРЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургаал номлол сүүлийн 30-аад жилд дэлхий дахинаа түгэн дэлгэрч, сургаалыг дагаж дэлхийн янз бүрийн шашин шүтлэгтэй олон арван сая хүн ухамсырын өндөр түвшинд хүрэх бодит замналыг дагаж, улмаар цагаан хоолтой энэрэнгүй үзлийг баримталж, цэвэр ёс суртахууныг өөриймшүүлж байна.

Их Багш Чин Хайн сургаал номлолын агуулга болсон "Агшин зуур билгийн мэлмий нээгдэх" хэмээн томьёологдог оюун санааны дээд бясалгал нь хүмүүнийг дотоод хүчтэй нь барилдуулж, мөн чанарыг нь таниулж, улмаар дээд ухамсырын бүх түвшинд хүргэх явдал юм. Их Багш бээр дотоодын гэрэл, аялгуунд түшиглэсэн энэхүү дээд бясалгалын мөн чанарыг тайлж "Гэрэл, аялгуу бол бидний мөн чанар юм. Бясалгалаар та өөр руугаа орно гэсэн үг. Таныг өөрөөст тань илүү юу сайхан болгож чадах билээ. Загас усандaa байхаас илүү загасыг юу сайхан болгох вэ. Та өөрөө гэрэл юм. Бүх орчлонг бүтээж буй тэрхүү чичиргээ нь та өөрөө юм. Орчлонгийн дарга, удирдлага нь та өөрөө юм" гээд "Бясалгал бол биеийг тань хооллох хамгийн сайн хоол, дээд тан, тархийг тань хөгжүүлэх хамгийн хүчтэй энерги, оюун ухааныг тань тэлэх хамгийн сайн ном юм" хэмээн айлджаа.

Гэгээрсэн Их Багш Чин Хайн үйл ажиллагаа нь дараах хүрээг хамран хэрэгжиж байна.

Хүмүүнийг дотоод амар амгаланд хүргэх: Дэлхий даяар хийх өдөр тутмын болон нэгдсэн бясалгал, цагаан

ба ногоо хоолонд суурилсан энэрэнгүй үзэл, цэвэр ариун ёс суртахуун (амьтны амь хороох, худал хэлэх, хулгай хийх, садар самуунд татагдах, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх зэргийг цээрлэх), хүмүүний оюун санааны хөгжлийн арга зүй (ном, сэтгүүл, DVD, CD гэх мэт), тэнгэрлиг уран бүтээл туурвил (уран зураг, яруу найраг, хувцас загвар, гоёл чимэглэлийн үнэт эдлэлийн загвар зохион бүтээлт гм).

Дэлхийн энх тайвны төлөөх стратеги: "Суприм Мастер" телевиз, цаг уурын өөрчлөлтийн тулгамдсан асуудлаарх теле бага хурлууд, гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх тусlamж, ногоогоор хоол үйлдэх зоогийн газруудын олон улсын сүлжээ, үзэсгэлэн, сайн үйлсийн төлөөх Их Багшийн хүмүүнлэгийн шагналууд, цаг уурын өөрчлөлтийн асуудал болон ногоо хоолны гарын авлагууд, санхүүгийн хандив, тусlamж, улс орнуудад хүрч ном тайлах дэлхийн аян.

Их Багшийн цогцлоосон Гэрэл, Аялгууны бясалгалын төв болон төлөөлөл нь Африкийн 12 орны 19 хотод, Америк тивийн 15 орны 75 хотод, үүнээс АНУ-д 42, Азийн 21 орны 49 хотод, Европын 27 орны 45 хотод, Номхон далайн 2 орны 14 хотод ажиллаж, тэдгээрт янз бүрийн шашин шүтлэгтэй сая сая бясалгагч хамрагдаж байна. Их Багшийн өөрийн хөрөнгөөр байгуулсан "Суприм Мастер" телевиз нь хүмүүнлэг энэрэнгүй нэвтрүүлгийг 5 тивийн үзэгчдэд 30 гаруй хэлээр 24 цагаар өдөр алгасалгүй нэвтрүүлэн хүн төрөлхтнийг соён гэгээрүүлэх их ажлыг 5 жил гаруйн хугацаанд цуцалтгүй гүйцэтгэсэн байна.

Их Багш Чин Хай 1989 оноос хойш дэлхий дахинаа хүрч 400 удаа ном тавьснаас зөвхөн 1993, 1999 оны хоёрхон жилд гэхэд л 38 оронд уригдан 48 удаа ном тайлж байжээ.

Олон улсын бясалгалын төв дэлхийн 77 орны 202 хотод ажиллаж байна. Их Багш Чин Хай бээр 1983 онд Энэтхэг, Тайвань, Герман, 1984 онд Америкт Авшиг өгч эхэлснээс хойш бясалгал нь бүх шашин шүтлэгтэй хүмүүсийг хамарч, дэлхийн олон арван сая хүнийг оюун санааны хөгжилд удирдан залж байна.

Их Багшийн айлдвэр, сургаал номлолын 20 ном, 325 DVD, түүний уран зураг, дизайны 3 ном, 200 гаруй шүлэг, яруу найраг, дуу багтаасан 22 ном, CD, DVD нь дэлхийн 38 хэлээр, "Агшин зуур билгэ нээгдэх түлхүүр" оршил ном нь 74 хэлээр орчуулагдан хэвлэгдсэн байна.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Энэтхэг. Плюун. 1997 оны 11 сарын 22
(Эх нь Англи хэлээр)

ЗӨВ ЗАМ МӨР

Бидэнд амьдрах цорын ганц арга бий тэр бол зөв зам мөр. Өөр арга байхгүй. Хэдийгээр Энэтхэгийн гүн ухаанд бид бүгдээрээ Бурхан, дотор тань Бурхан оршдог хэмээн сургадаг ч амьдралдаа хийсэн сонголтууд маань биднийг Бурхан эсвэл Бурхны-эсрэг нэгэн болоход хүргэдэг. Хэрэв буруу сонголт хийвэл бид буруу тийшээгээ л явна. Бурхан гэрэл хийгээд харанхуй, сайн болоод мууг хоёуланг нь бүтээсэн, ингэж гэмээнэ бид зөв зам мөрөө сонгохын тулд ойлгож, мэдэж, билгүүн ухаанаа ашиглах чадвартай болно. Зарим маань хааяа сул дорой байдалд хөлөө алдаж, хүч чадал болон хүсэл зорилгодоо хүрэхийн үнэ цэнийг мартдаг гэтэл энэ нь материаллаг ололт амжилтаас хэд дахин аугаа зүйл байдаг. Тиймээс бид түүнийхээ төлөө тэмцэн зөв зам мөрийг сонгож, өөрийгөө хүндлэх ёстай.

Бурхан бидэнд чөлөөт хүсэл тэмүүлэл хайрласан. Мэдээж “Чи ингэх ёстой, тэгэх ёстой, үгүй бол чамайг шийтгэнэ” гэж Бурхан хэзээ ч хэлэхгүй. Шийтгэл биднээс, сэтгэлээс маань ирдэг. Буруу зөвийг нь мэдсээр байж, муу юм хийсэн үед бие сэтгэл нэг л таагүй болчихдог, энэ л бидний шийтгэл юм. Сэтгэл хийсэн муу үйлдээ гэмшиж дургүйцэх нь тамиас ч долоон дор. Харин хийсэн зүйлдээ сэтгэл ханамжтай байгаа бол, Бурхны хүсэл тааллаар үүнийг хийжээ гэсэн үг. Тиймээс ч Бурхан бидэнд сонголт хийх чөлөөт хүсэл тэмүүлэл өгч, өөртөө болоод дэлхийн бусад хүмүүст Бурхны зам мөрийг сонгох учиртайг сануулахыг зөвшөөрдөг. Өөрийгөө Бурхан гэж бодож байгаа юм бол өөрийгөө илэрхийлэх цорын ганц арга бол энэ. Бурхантай нэгэн цогц, бүр Бурхан дотор минь оршдог гэж бодож байгаа л юм бол бид түүнийгээ илэрхийлэх ёстай.





ОЮУНЫ ХҮЧ УЛС ОРОНД ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛ АВЧИРДАГ.

Төгс Гэгээрсэн Их багш
чин хайн айлдвар

Засгийн газрын ухаалаг зөв бодлого ард түмэнд аз жаргал, хөгжил дэвшлийг авчирдаг нь эрт үеэс тодорхой болсон зүйл юм. Үүний хариуд хүмүүс төр засгаа, удирдлагаа хүндэлдэг ба ийм байдлаар улс орон найрамдалтай, бас хөгжин цэцэглэж байдаг. Бид ямар ч төрлийн буу зэвсэг, хүч хэрэглэх шаардлагагүй, зөвхөн хайр энэрэл, хүндлэлийг өөр хоорондоо төлөвшүүлснээр улс эх орон цэцэглэн хөгжих болно. Үүний тулд ухаалаг хүмүүс улсыг удирдаж, мөн ухамсарт удирдагчаа ухаалгаар хүлээн зөвшөөрч, ингэснээр хоёр талд хамтран ажиллаж, эх орноо хамтдаа дэлхийн тэргүүлэгч орны нэг болгодог.

Хүн бүр л алдаа гаргадаг, эсхүл заримдаа нийтийн дургүй зүйлийг хийдэг. Энэ бол байх л зүйл. Бид ч гэсэн алдаа гаргадаг. Гэхдээ бид өөрчлөгддөг, бясалгал хийж, сайн санаа тус нэмрийг шүтэн, байгалийн хуулийг даган мөрдөж илүү дээр болгодог. Түүнчлэн гэр бүлдээ ёс зүйт дээдэлж, оюуны хөгжлийг эрмэлзэн дээшлүүлснээр улс орныхоо хөгжил дэвшил, энх амгалан байдалд байнгын их дэмжлэг болдог. Үүнийхээ үрээр бид өөрсдөө өдөр өдрөөр дээрдэж илүү сайн сайхан болно. Яагаад гэвэл бидний дэс

дээшилсэн хэрэг. Амьдралын ийм өндөр түвшинд байж, ийм зарчмаар амьдарч байгаа хүмүүс илүү оюунлаг байдаг. Засгийн газар ч ялгаагүй. Хэрвээ төр нь энэрэнгүй, ард иргэдээ ивээж үндэстнийхээ төлөө чин сэтгэлээр ханддаг бол тийм засгийн газар илүү оюунлаг байдаг. Магадгүй удирдагч нар арай өөр түвшнээс ирсэн байж болох ба тийм бол тэд өөртөө хайр энэрэл, мэргэн ухааныг аль хэдийн агуулж, энэ дэлхийд зөвхөн хүмүүст туслах зорилгоор ирсэн ч байж болно. Тэгвэл тийм удирдагч нь тодорхой дэсэд хүрсэн Гэгээнтнүүд юм. Хэрвээ удирдагчаа нийтээр ойлгон ухаарч, хамтран ажиллаж, улс орноо ёс суртахуун, дэг журамд дулдуйдан хөгжүүлэх аваас иргэд нь ч мөн тодорхой түвшинд Гэгээнтэн болох буюу оюунлаг дэст хүмүүн болно. Та надтай учрахаасаа өмнө, гэрэл болон аялгуу бясалгахаасаа өмнө аль хэдийн оюунлаг нэгэн байсан байгаад оюуны тэрхүү өндөр түвшнээс эхлэх юм бол бид бусад ямар ч орноос, өөр ямар ч үндэстнээс илүү хурдан хөгжинө. Тиймээс зөвхөн мөнгөтэй, эрх мэдэлтэй, хүчтэй байх нь хангалтгүй. Хэрэв бид үүнээс гадна оюуны хүчтэй байх аваас бүрэн төгс болно. Сэтгэлийн ийм илүү дээд түвшинд нэгэнт хүрсэн хойно тэр нь төдийчинээ удаан үргэлжилнэ.



Их Багши Чин Хайн “Бясалгал Чухал Болох нь” лекц

Хүн бүр өөр өөр физик зохилдолгоотой байдаг. Хүн бүрт өөр өөр хэрэгцээ байдаг. Үнэндээ Есүс хэлсэн байдаг “Хүн дан ганц талхаар амь зогоох учиргүй” гэж. Олон хүн хоолгүй амьдарч чадаж байгааг бид харж байна. Хоол идэх мөн тодорхой амтанд дурших зэрэгт бид гагцхүү дассанд л гол учир байгаа. Бид энийг тэрийг идэх дуртай. Бид маш энгийн хүнсээр амь зуугаад байж болно... Заримдаа идэх хоол хөнгөн байх тусам бид илүү эрүүлждэг. Илүү их шим тэжээл хүртэх тусам улам бүр ядардаг.

Заримдаа бие бидний идсэн янз бүрийн хоолыг шилж ялгасаар, жишээ нь лууванг яаж боловсруулах, будаа, жижиг төрлийн шошны нахиа, мөөг зэргийг боловсруулах гэсээр ядардаг. Заримдаа бид хэтэрхий их, хэтэрхий олон төрлийн хоол иддэг ба энэ нь яланг боловсруулах явцыг хүндүүлдэг. Их ядраадаг.. Урьд нь сүмд амьдардаг байхдаа өдөрт нэг удаа иддэг байсан. Тэр үед, би дөнгөж гэлэнмаа болсон байсан тул сахилаа их чанд сахидаг байв. Өдөрт нэг удаа иднэ, үдээс хойш огт идэхгүй. Сүмийн хамба надаар хошигноод, хэлнэ “Чин Хай Багшийн нэг удаа иддэг хоол нь бидний гурав дөрвөн хоолтой тэнцэхээр хэмжээтэй” гэж даажигнадаг байсан. Үнэндээ, би их иддэггүй байсан, тэр хэтрүүлсэн юм. Тэр зүгээр надаар тоглож байв. Тэгэхээр нь би “За, тэгвэл би бүр идэхээ больё” гэсэн. Би больсон.. Зүгээр л би хоол идэхгүй байж чадна гэдгээ мэдэрсэн юм... Гэхдээ хүссэн үедээ

хэзээд идэхээ больж чаддаг байв. Тэгээд би хэдэн долоо хоног юу ч идээгүй. Хамба ихэд сандарсан. Тэр намайг уурандаа идэхээ барьчихлоо гэж бодсон. Тэр үргэлж намайг идүүлэх гэж хичээж байв. Хүн болгон идэх байхдаа намайг ширтдэг байв, би нэлээд хэсэг хугацаанд юм идээгүй. Идэхээ барьсны дараа би өвдөөгүй. Би идэхээ барьсон ч, хийдэг ажлаа хийсээр байсан. Би их энергитэй байсан. Их хөнгөн, сайхан санагдаж байсан. Сүүлд тэд намайг хэтэрхий их шахсан тул би дахиад идэх эхэлсэн.

Удаан хугацаанд хоолгүй байсны дараа анх удаа идэхэд, надад үүлнээс унах мэт санагдсан. Яг л доош татагдаад унасан мэт. Би маш их өвчин мэдэрсэн. Анхны хоол их өвчин мэдрүүлж байсан. Гэхдээ сүүлдээ би дассан. Бид юм бүхэнд дасаж чаддаг их сонин шүү. Хоолтой, хоолгүй, зовлон, жаргал бүхэнд дасдаг. Энэ бүхэн дассан ойлголтоос болж байгаа. Бид өөрсдийн ойлголтоо өөрчлөх хэрэгтэй.. Ядуу хүмүүст идэх зүйл байхгүй үед, тэд өвчилж эсвэл өлсөж үхдэг. Тэдний ойлголт, ухамсар өөрчлөгдөөгүйгээс тэд зовдог. Тэд хоолгүй бол үхэл гарцаагүй гэж боддог. Тэд ядуу байх өрөвдөлтэй гэж боддог. Гэтэл сайн дураараа идэхгүй байгаа хүмүүс маш жаргалтай, эрүүл байдаг. Энэ бүхэн гагцхүү тогтсон ойлголт. Тиймээс ч Будда “Бүх зүйл бодлоос бий бодлог” гэсэн. Яг ийм юм. Гэхдээ хэрэв та нар ямар нэг шинэ зүйл оролдох гэж байгаа бол аажуу эхэл. Энэ их чухал зүйл шүү. Биеийг

хэтэрхий их бүү хүчил. Өөрийн тэвчээр, хатуужлыг хэтрүүлж хэрэггүй. Өөрийн нөхцөлд зохицуул. Хэрэв хүчтэй хэвээр бол зүгээр. Бид юу ч хийсэн анхааралтай байх хэрэгтэй. Алхам алхмаар хий. Хэрэв урагшилж чадахгүй бол арагш алх, тэгээд дараа нь урагшлах гээд ахин оролд, хүчлэх хэрэггүй. Жишээ нь, бид замд явж байтал бөөн чулуу зам тагласан байж. Түүнтэй тэмцэлдэж байхын оронд бид тойроод явах хэрэгтэй, эсвэл ухарч илүү сайн харах. Эсвэл хамтраад хад зайлцуулах хүн хайж болно. Хадтай нүүр нүүрээрээ мөргөлдөөд байх хэрэггүй. Ид шидийн хүчтэй л биш бол хадыг хөндлөн гарах гэх хэрэггүй. Энд бол хэрэв та нар бусдад туслахыг хүсвэл, бясалгах хэрэгтэй, доод тал нь 4 цаг, зөвхөн 2,5 биш. Хоёр цаг хагас бол зөвхөн өөрт нэмэртэй мөн жоохон бусадтай хуваалцахад хангалттай. Хэрэв та нар үнэхээр бусдад туслахыг хүсвээс жишээ нь, өдөрт доод тал нь дөрвөн цаг бясалга.

Юу хүссэнээ ид. Гол нь юу идэж байгаагаа маш тодорхой мэдэж байх ёстой. Заримдаа бид их идэх тусам бие илүү хүнд болж, ядардаг.. Тиймээс бид хэтэрхий их зүйл идэхэд, сүнслэг бие мөн доош татагдан унадаг. Ийм шалтгаанаар эрт дээр үеэс Будда, Есүс Христ зэрэг хүмүүс гутал өмсөх дургүй байсан, учир нь энэ ертөнцөөс аль болох багыг авах тусам, тэр хэрээр илүү их тайван, аз жаргалтай болдог. Ийм учраас тэд тийм өндөр түвшинд хүртэл бясалган дэвшиж чадсан. Одоо цагт, бидэнд маш их материаллаг зүйлс байдаг, тиймээс ч бидэнд бясалгах хэцүү байдаг юм. Энэ үнэхээр ийм билээ. Үүнийг би өөрийн туршлагаас мэднэ. Илүү их бясалгах тусам илүү сайхан болдог. ойролцоогоор 90%.


Тиймээс надад эм хэрэглэх шаардлага байхгүй, витамин мэдээж болно. Би өдөрт хоёр удаа иддэг, маш бага, их биш. Би их жимс иддэг, маш их жимс, мөн олон болгоогүй жимсэн төрлийн ногоо иддэг.! Санаагаа улам зовоох тусам тэр хэмжээгээр эрүүл мэнд чинь дордож, сүнс чинь мөн тэр хэрээр супрана. Улмаар бүр дархлаа чинь супарсаар, супарсаар тэгээд өвчин тусна. Хамгийн чухал зүйл бол түгшиж зовохгүй байх. Бусад хүмүүс чамд дарамт болохыг бүү зөвшөөр. Заримдаа хайртай хүмүүс дарамт өгдөг. Хайр бол болзол нөхцөлгүй байх учиртай. Хайр бол эзэмшихээс өөр. Зарим хүмүүс хайртай гэж хэлдэг, гэвч тэд маш их эзэмших дуртай байдаг ба энэ нь эргээд их ядраадаг. Тэд чамд хайртай учраас чи юм хэлэх юм уу, орхиод явж чаддаггүй.

Тэгсэн боловч тэднээс яаж ангижрахаа чи мэддэггүй Хэрэв хэтэрхий олон гэр бүлийн гишүүдтэй мөн хүн бүр өөр өөр зүйл хүсдэг бол энэ нь ихээр тамир авдаг. Тэд санаатай ингэдэг юм биш. Тэрчлэн энэ нь тэдний өмнөх амьдралуудаас нь өвлөгдсөн карма (үйлийн үр) байдаг. Урьдын амьдралын дайснууд эргэж ирээд хайртууд болдог. Хайрт байх бас л их ядраадаг. Тэднээс хол байж, тэднийг бага зэрэг зайнаас ажиллуул. Ажилдаа татан оролцуулж, алхам бүрт оролцохыг

бүү зөвшөөр. Тэгвээс бүтэхгүй. Тэд туслах тусам бид улам бүр завгүй болно. Тэд хайрлах тусам, бид илүү их ядарна.

Чи бясалгах хэрэгтэй. Өөрөө бясалгал хийх хатуу шийдмэг байх ёстой. Учир нь хэрэв та нар бясалгахгүй бол сүнс чинь үхнэ. Улмаар бие чинь ядарч эхэлнэ... Та нар үнэхээр бидний бясалгальн аргаар шамдан бясалгах хэрэгтэй. Бясалгах боломж гарах бүр бясалгах хэрэгтэй. Тав, арван минут байсан ч, төвлөрөх хэрэгтэй. Та нар өөрсдийгөө цаг үргэлж хамгаалж байх учиртай. Эс бөгөөс энэ дэлхий хэтэрхий бохир, мөн сүйрлийн чанартай. Хэзээд гэмтэж, аюулд өртөх боломжтой. Хэдийгээр та нар цагаан хоолтон, найрсаг ч гэсэн, та нар мөн аюулд өртөж болно.

Тиймээс гагцхүү бясалгал мөн төвлөрөл биднийг хамгаалж чадна. Тэр дундаа энэ цаг үед, маш олон сорилтууд байна. Хэрэв дэлхийн хүмүүс өөрчлөгдөхгүй бол, удахгүй сөнөх болно. Тиймээс, бид хамгийн сайнаараа бясалгах хэрэгтэй. Үнэхээр, би дэлхийд туслахын тулд л та нарыг дуртай дургүй ажиллуулахаар илгээдэг. Эс бөгөөс хэрэв дэлхийн төгсгөлөөс сэргийлэх асуудал биш байсан бол, би та нарыг цаг үргэлж бясалга гэж зөвлөхгүй байсан. Учир нь хэрэв бид хангалттай бясалгахгүй бол, энэ дэлхийд ч мөн тусалж чадахгүй. Хэрэв намайг хүрээлэх хүмүүс сайн бясалгахгүй бол тэдэнд надад туслах их хэцүү байх болно. Тэд хүсэвч, чадахгүй. Тиймээс, та нар эхлээд бясалгах хэрэгтэй. Өөр бусдад туслахыг хүсвэл өдөрт дөрвөн цаг бясалга. Хэр их туслахыг хүсч байгаагаас хамаарна. Боломж л олдвол бясалга аль болох их бясалга, тэгж байж ашиглаж болох нөөц хуримтлуулна. Гагцхүү бясалгал мөн төвлөрөл биднийг хамгаалж чадна.





ПАРИСЫН ДИЯАН

-НЫ ҮЕЭР

ТӨГС ГЭГЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ ШАВЬ НАРЫНХАА
АСУУЛТАД ХАРИУЛСАН ЯРИЛЦЛАГААС

Багш -Битгий сөрөг мэдээлэл ярьж бай, таны бодож байгаа бодол бүхэн эерэг, зөв байх ёстой, сөрөг бодол бүхэн сөрөг зүйлийг бий болгодог. Тиймээс сөрөг бодлыг үүсгэхгүй байж, сөрөг үгийг амнаасаа гаргахгүй байж, таны бодож байгаа бүхэн тань эерэг байх ёстой, ингэснээрээ та хамгийн шилдэг нь байж чадна. Санаж яв, минут бүр, секунд бүр Бурханд төвлөр. Энэ бол Бурхнаас танд тавьж буй цорын ганц шаардлага бөгөөд таны хийх ёстой ганцхан зүйл юм. Тавьж буй энэ шаардлагыг биелүүлбээс таны бүх зүйл амар хялбар болж, хэцүү зүйл нэгээхэн ч үгүй байх болно.

Та юу ч хийгээгүй байсан ч, ямар нэгэн зүйлийг хийсэн байсан нь ч юунаас ч айхгүй байх болно, та чинь тэнгэр, газрын хоорондох сүр хүчит төрөлтөн шүү дээ. Бурхныг дурссанаараа та өөрийнхөө ямар их чадавхтайгаа, ... оюун санаа ямар бүтээлч гэдгийг мэднэ.

Шавь - Бурхан цаанаасаа бидэнд дадал зуршлыг буулгаж өгдөг юм уу? Эсвэл шууд автоматаар дадал зуршил гэгч зүйл бий болчихдог юм уу?

Багш - Эзэн бурханд төвлөр, бүх зүйл алга болж үгүй болно. Танд ямар ч буулгаж ирсэн дадал гэх зүйл байхгүй болно. Таныг Бурханд төвлөрч байхад ямар ч хийсвэр гэх ойлголт байхгүй болно, та автоматаар л ямар ч асуудалгүй болчихдог. Та өөрөө л дадал зуршил гэх зүйл бууж ирдэг гэж оюун бодолдоо боддогоос л ийм байгаа юм. Хэрвээ ингэж бодохгүй л бол та өдөр бүр Бурханд төвлөрч чадна.

...Шавь - За тэгэхээр зөвхөн Бурхан, оюун бодолд маань зөвхөн Бурхан

Багш - Тийм ээ ийм л байдаг юм. Орчлон ертөнц тэр чигээрээ Бурханд харьялагддаг, хэрвээ та дээдийн дээдийг хүлээвэл энэ чинь л боллоо, тэгээд л та дээдийн дээдэд хүрнэ шүү дээ.

Шавь -Тэгэхээр онигоо ярихдаа хүртэл бид сөрөг үг хэрэглэж болохгүй юу?

Багш - Тийм, тийм, тийм шүү. Яагаад Бурхан та нараас зөвхөн Бурхныг санан дурс гэсэн бэ? Учир нь Бурхныг санан дурсахад та үйл үрийн хуулиас чөлөөлөгдөх ба зөвхөн Бурханд анхаарлаа хандуулбал энэ нь хамгийн сайн арга байх болно. Бурхныг санаж дурсаж байхад юу ч оршин байдаггүй. Та нар энэ санааг ойлгохгүй байх шиг байна. Минут бүр, хором бүр Бурхантай хамт байх хэрэгтэй гэдгийг би ахин дахин онцолж хэлж байсан шүү дээ. Угаасаа л бүхий л гараг ертөнц тэр чигээрээ Бурхны харьялалд байдал, бүх зүйл нэг юм, ямар нэгэн юмны төлөө тэмцэх юу ч тэнд байхгүй. Ямар ч сөрөг юм байхгүй. Тиймээс би та бүхэнд Бурханд төвлөр, минут, хором бүр Бурхныг санан дурс ингэснээрээ бүх зүйлс зүгээр болно гэж дахин дахин хэлдэг. Бурхны сайн хийж чадахгүй юм гэж байдаг билүү? Зөвхөн физик тархи л таныг сатааруулдаг. Таныг Бурхантай нэг болсон үед ямар ч сөрөг зүйлс алга болдог. ...Бурхантай нэгдмэгц үлийн үрээр хийх нэгээхэн зүйл үгүй байх болно. Та бүхэн энэ үгийг хүн болгонд хэлж болно шүү. Бурхныг санан дурсч яв. Бусдадаа бурхныг санан дурсч яв гэж л хэлээрэй, тэгээд л тэд учир шалтгааны ертөнцөөс чөлөөлөгдөх болно. Ингэх нь үнэхээр хялбар юм.


Шавь - Бид хүн болгонд энэ мэт хэлээд байх уу?


Багш - Мэдээж тэгэлгүй яахав. Яагаад заавал өөртөө энэ үгийг хадгалаад байх ёстой гэж.

Шавь - Найз нөхөд, хамаатан садандаа, ангийн хандаа, мөн бидэнтэй барилдлагатай хүн болгонд хэлэх үү?

Багш -Тийм ээ, бүгдэд нь хэлэх хэрэгтэй.

Шавь - Тэгээд л тэд нар үйл үрийн хуулиас чөлөөлөгдөнө гэж үү?





Багш - Мэдээж тэгэлгүй яахав. Яг л чам шиг. Бурхныг минут, хором бүр санан дурс, энэ л хамгийн шилдэг хурдан арга юм. Бурхныг санан дурсахад, энэ бүх зүйлийг хийхэд Бурханд үнэхээр хялбар байдаг. Бүх зүйл аяндаа ямар ч төвөггүйгээр бүтдэг.

Шавь - Бие болон сэтгэлд үүсээд байгаа өвчлөл арилдаг уу?

Багш - Та энэ физик биетэй байгаа болохоор л өвчин тусаж байгаа юм. Учир нь энэ Дэлхий дээр үйл үрийн хууль үйлчилж байдаг юм. Таныг Бурханд төвлөрч байхад таны биед байгаа энэхүү өвчин болон та өөрөө үйл үрийн хуулиас чөлөөлөгднө.

Шавь - Өө, баярлалаа, баярлалаа. Уучлаарай дахиад нэг асуулт асууя. Хүүхдэд маань миний хайр маш их хэрэгтэй юм шиг надад санагдаад байна, хүүхдээ энэ чигээр л хайрлаад байх уу? Заримдаа бүр яахаа мэдэхгүй болчих юм аа. Түүнийг хайрлах ямар зам нь хамгийн дээр юм бол.

Багш - Зөвхөн Бурханд төвлөр. Бурхан түүнийг тань хайрлана.

Шавь - Тэгэхээр огт санаа зовохгүй байх уу?

Багш - Таны түүнд санаа зовж байгаа байдал хэрээс хэтэрсэн байна.

Шавь - Хөөх, тэгэхээр тэр зүгээр юм байна. Тэр бие махбодын хувьд болон сэтгэл санааны хувьд зэрэг төгс хөгжиж чадах уу?

Багш - Бүх хүн зүгээр. Таныг Бурханд төвлөрч байхад бүх юм зэрэг дэвшинэ, тэгээд л боллоо. Энэ нууцыг хүн бүрт хэлээрэй.

Шавь - Түүний бодол үүнийг бүрэн дүүрэн хүлээж авахгүй бол яах ёстай вэ?

Багш - Түүнийг үүнд итгэж байна уу?, үгүй юу? гэдэгт битгий санаа зов, та өөрөө л Бурханд төвлөр. Тэр тантай холбоотой байгаа. Бурхны хүч танаар дамжигдаад түүнд хүрч байгаа учраас тэр дээрдэнэ. Яагаад та түүнд

санаагаа зовоогоод байгаа юм бэ? Бурхан хүн бүрийг харж ханддаг юм.

Шавь - Түүний муу дадал зуршил гэх зүйл нь ч арилах уу?

Багш - Дадал зуршил нь түүнийх биш. Түүнийх биш.

Сайн, муу гэгдэх зүйлсүүд яагаад байдаг вэ? гэхээр таны бодол сайн муу гэгдэх зүйлсийг ялгаж чадахгүй л байгаа юм. Үнэндээ бидний хийж байгаа бүхэн төгс төгөлдөр байх ёстой, зөвхөн таны оюун бодол нь тэр зүйл сайн, тэр зүйл муу гэж боддог юм. Тодорхойлолт нь нэг ийм л байна даа: Бодол гэж байхгүй болбол сайн ч, муу ч зүйл байхгүй болно. Оюун бодолдоо зөвхөн Бурхныг тээж явбал, та бүхнийг муугаар биш, бүр төгс төгөлдөрөөр харах болно.

... **Шавь** - Ойлголоо, бүх хүмүүст Бурханд төвлөр гэж хэлэх юм байна.

Багш - Тийм ээ, минут бүр, хором бүр Бурхныг сана. Их Багшийгаа дурсан ярь, Бурхныг дурс, шүтэж явдаг бүхнээ дурс, бүгд зөв байх болно гэж бусдад хэлээрэй. Мэдээж Багш тань хамгийн дээдийн дээд. Хэрвээ буян хариулалтай хэн нэгэн байвал тэр л Их Багшийн нэрийг дурсана. Өөр зүйлийг хүлээж авч буй нь хамаагүй, энэ нь түүний дэсээс л хамаарна. Гэхдээ яг энэ цаг мечид дээдийн дээд нь Их Багш Чин Хай юм.

Шавь - Нэг зүйл дээр төвлөрөөд, төвлөрөх чадвараа хөгжүүлэх үү?

Багш - Тийм ээ таны зөв. Гэхдээ Бурханд төвлөрөх л хамгийн дээд зүйл байх болно. Би үүнийг та нарт дахин дахин хэлсээр ирсэн шүү дээ. Бурхныг санаж явж Бурхныг санаж яв. Бусад хүмүүст Есүс Христийг санаж яв, Их Багшийг санаж яв, Буддаг санаж яв, дээдийн дээд гэсэн болгоноо санаж яв гэж хэлээрэй, тэгээд "Үнэн ёс" болон энергийг, мөн Бурхныг дууд гэж хэлээрэй. Ингээд л боллоо. Үүнийг л санаж яв..

Бермудын гурвалжин ба үйлийн үр

Шавь: Сайн уу Багш аа. Бермудын Гурвалжинд алга болсон нисдэг болон усан онгоцнуудад тийм сөрөг орчинд очих ёстой сонгогдсон хүмүүс байдалг уу?

Багш: Тийм, тэгж хэлж болно. Хамтын энерги, тодорхой бүлэг хүмүүсийн хамтын үйлийн үр дагавар. Яг л тодорхой хүмүүс тодорхой улс оронд төрж, өөр тодорхой хүмүүс бусад тосгод, эсвэл гэр бүлд хамт төрдөгтэй ижил, мөн үү? Тиймээс тэр нь хамтын гинжин үйлийн үр гэх үү дээ. Гэхдээ тухайн үед аль нэг билиг оюунтай хүн тэнд байж таарвал тэд доод ертөнцөд татагдаж орохгүй, харин тэнгэрийн элчүүд тэднийг Диваажин эсвэл Дэлхий рүү ахин хүргэх болно. Гагцхүү тийм дорд ертөнцөд байх учиртай хүмүүс тийш очдог.

Шавь: Баярлалаа Багш аа, гагцхүү тамд очих ёстой хүмүүс тээсэн онгоцнууд зөвхөн Гурвалжинд алга болж, тамд очих ёсгүй хүмүүсийг тээгч онгоцнууд Гурвалжингаар юунд ч өртөлгүй дайрч гардаг уу? Санамсаргүй зорчигчид тэрхүү гарцаанд өртөхөөс хамгаалсан хамгаалагчид тэнд байдалг болов уу?

Багш: Үгүй, үгүй. Хамгаалагч байхгүй, учир нь билэг оюунтай хүмүүс эсвэл сайн оршихуйнууд тийм газар байхгүй, эсвэл тийм нөлөөнд нь өртөхгүй. Билэг оюунлаг хүмүүсийг тэртэй тэргүй тэнгэрийн элчүүд хамгаалж байдаг. Тэд тэнд үхлээ ч, тэд тийм ертөнцөд орохгүй. Тэд тийм гарцаад сорогдож ордоггүй, харин өөр замаар хөтлүүлдэг, илүү дээгүүр түвшин, эсвэл эргээд хүний төрлийг энэ эсвэл өөр ертөнц дээр олдог. Тэр орчимд явж байгаад сорогдсон хүмүүс, хажуугаар нь явсан хүмүүс там руу хараахан явдаггүй. Там бол өөр газар. Тэдгээр нь доод ертөнцүүд за? Гэхдээ тамд ойрхон.

Шавь: Сайн уу Багш аа. Хар нух нь муу энэргийг боловсруулах гэж оршдог гэж та дурдсан. Тэдгээр гарцууд нь мөн ялгаагүй дэлхийн муу энэргийг шингээх гэж оршдог уу? Тамын үүд байдалг гэж үнэн үү? Тэдгээр тамын үүдүүд нь

манай дэлхийн хар нүхнүүд шиг байдалг уу?

Багш: Тийм, тэд тийм. Тийм, хүний ёс суртахуун эсвэл Диваажингийн стандартыг зөрчсөн сүнснүүдийг авах зорилготой тамын үүдүүд байдалг, за?

Шавь: За Багш аа. Тэдгээр тамын үүдүүд нь хаана байдалг вэ?

Багш: Хэрэв тэдгээр очиж үзмээр байвал би та наарт хэлье. Тамын гарцууд бий. Там руу хөтөлдөг, олон бий, 20 байдал, тийм. **Говь цөлд 4 бий, Монгол, Хятадын нутаг дахь** Австралид 2 бий, Шинэ Зеландад 2, Афганистанд 5, Пакистанд 3, Иракт 2, Хойд Солонгост 2 бий. Дэлхий мөн Диваажингаас уйдвал очиж үзэж болно. Гэхдээ би та наарт хэлсэн. Тэдгээр нь энерги шингээх гэж байдаггүй. Тэдгээр нь хүний ёс суртахуун, Диваажингийн стандартыг зөрчсөн хүмүүсийг авах гэж байдалг.

Шавь: Бермудын Гурвалжны далаид эрт дээр оршиж байгаад живсэн иргэншил бий юу? Атлантиcs нь далаай доор байгаа гэсэн онол байдгийг бид сонссон?

Багш: Тэр нь Атлантис гэж би бодохгүй байна. Зарим нэг бий, зөвхөн ганц ч биш, ямар нэг бичээстэй нэр харахгүй байна, гэхдээ Атлантис гэж бодохгүй байна. Ямартаа ч хэрэгтэй зүйл биш, өнгөрснийг мэдэхийг хүсээгүй л бол. Тэгээд ч бидэнд баталгаа байхгүй, хэт эрт болсон. Бид одоодоо, энд өөрсдийн стандартыг сайжруулахдаа анхаарч төвлөрсөн нь дээр. (Тийм, Багш аа.) Улмаар бид өөрсдийн иргэншлийг илүү удаан хадгалан авч үлдэж, сайжруулах нь сайн.

Шавь: Хүмүүс өөрсдийн үйлээрээ буюу аллага, эсвэл амьтан болоод нэг нэгнээ хохибоож буй үйлээрээ тэдгээр тамын гарцуудыг бүтээдэг үү? Мөн сөрөг энэрги хуримтлагдах тусам тэдгээр гарцууд нь улам томордог уу?

Багш: Үгүй, үгүй. Тэдгээр нь анхнаасаа л тийм бүтээгдсэн Олон ангилал байдалг ч тэдгээр нь дэлхий нийтэд хангалттай байгаа.

Шавь: Бермудын Гурвалжин шиг тийм газруудыг богино хугацаанд бүтээж болдог уу, жишээ нь: мал үржсүүлгийн газар бий болгож байгаа шиг, эсвэл магадгүй зөвхөн дайн болсон газар шиг тэдгээрийг бүтээхэд урт удаан цаг ордог уу?

Багш: Үгүй, үгүй. Шинээр Бермудын төрлийн газар бүтээгдэхгүй... Гэхдээ замууд бий – шинэ биш. Доод ертөнцүүдтэй холбосон замууд байдаг. Бурхны авралаар бидэнд шинэ хэрэггүй. Тэдгээр нь бүх дэлхий нийтэд хангалттай том, би хэлсэн шүү дээ Тийм, там эсвэл доогур түвшин, бүх дэлхий болоод бүр илүү ихэд хангалттай. Тэнд олон ертөнцүүд багтах боломжтой, учир нь тэр нь физик биш. Сүнснүүд зовдог, гэхдээ энэ нь яг л физик бие зовж буй мэт санагддаг, учир нь тэндээ тэр бүгд нь физик бие юм? Астрал бие яг л физик бие шиг санагддаг, эсвэл бүр доор, бүр доор, учир нь хаана ч нуугдаж чадахгүй. Нэвт харагддаг болчихоор хүн бүгд чамайг хаанаас ч харах болно. Энэ физик дэлхий дээрх шиг нуугдах газар байхгүй. Тэнд тэгэхээр бүр доор.

Шавь: Багши аа, Бермудын Гурвалжиннд алдагдсан хүмүүс хаашаа явдаг вэ? Тэр нь Дэлхий дээрх физик газар уу, эсвэл зэрэгцээ ертөнц үү?

Багш: Тэр нь физик ертөнц биш. Зүгээр л доод астрал түвшин, тэнд үргэлжийн айdas, уй гашуу, өвчин зовлон, айдаст амьдарч байдаг, тэд өөр газрыг мэддэггүй, учир нь энэ дэлхий дээр эсвэл өөр хамгийн сүүлд байсан ертөнцүүд дээр физик амьдралд байхдаа тэд айdas, гамшиг, өвчин зовлон бий болгож, бусдын амар амгаланг сүйтгэж байсан байдаг. Тийм ч учраас тэд тэнд өөрсдийн буруу үлийн үрийг төлөх гэж байгаа юм. Тэд бусдад учруулсан зовлонг өөрсдөө амсах гэж тэр доод ертөнцөд байгаа, өөр амьдралдаа эсвэл үхэхээсээ өмнө энэ амьдралдаа, за?

Шавь: Багши аа, хүмүүс тийшээ хэр их очдог вэ? Үргэлж ийм зүйл болдог уу? Энэ тийм ховор тохиолдолуу эсвэл...?

Багш: Үгүй. Тийм ч их биш, гэхдээ хүмүүс үхсэнийхээ дараа тийшээ очдог. Зугтах арга байхгүй. Зарим нь бүр амьд байхдаа тийшээ явдаг. Ойлгож байна уу? Зарим нь онгоцноосоо шууд очдог.

Шавь: Бермудын Гурвалжин шиг ийм үзэгдэл Дэлхийн өөр хэсэгт болдог уу, эсвэл зөвхөн тэнд болдог уу? Бермудын Гурвалжнаас өөр өөр ижил сөрөг хүчтэй газар байдаг уу?

Багш: Тийм, байдаг. Ижил төстэй газрууд бий, гэхдээ эрч нь өөр байдаг, амьд физик биед байхдаа бусдад хэр их зовлон учруулсан түвшнээс хамаарч өөр өөр хүчтэй байдаг. Манай дэлхий дээр 15 төрлийн тийм гарц байдаг, учир нь зарим хүмүүс илүү их зовлон учруулдаг бол зарим нь арай багыг учруулдаг, тэгээд зовлон, эсвэл өвчин нь өөр өөр зэрэглэлтэй байдаг тиймээс өөр өөр зэрэглэлтэй доод ертөнцүүд байдаг, тэнд хүмүүс өөрсдийн муу үлийн үрийн төлөөсийг төлдөг юм. Австралид 2 бий, бурхан минь, дөнгөж сая Австралид там байдаг гэсэн.

Тамын хоёр гарцтай, одоо тэгээд Австралид доод ертөнцийн 2 гарц бас байдаг болж таарч байна; Афганистанд 3, Пакистанд 2 доогуур ертөнцийн гарц бий. Шинэ Зеландад 1 байдаг, Бермудын Гурвалжинд 4 бий. Яагаад тэнд дайн болгийг энэ тайлбарлаж байна. Тэдгээр улс орнуудад илүү их гарцууд байдаг тул илүү их дайн байна. Өөрөөр хэлбэл тамын гарц, доод ертөнцийн гарц их байх тусам дайн их байдаг. Тэгэхээр тэндхийн уур амьсгал арай өөр, хувь заяа нь арай өөр, амьдрал нь арай өөр байдаг. Бермудын Гурвалжинд нийт 4 байдаг. Магадгүй ийм учраас тийм олон онгоц, нисдэг онгоц тэнд живдэг байх.



Шавь: Хэрэв хэн нэгэн Бермудын Гурвалжин руу татагдан орвал, эсвэл ижил замаар там эсвэл Диваажинд очвал тэдяаж эргээд өмнөх ертөнцөө эргэж ирэх вэ?

Багш: Би аль хэдийн хэлсэн, доод ертөнц, тамиас буцаж ирэхийн тулд тэд ертөнцийн буян хураах хэрэгтэй, тодорхой сайн буян хурааж, өршөөл хүртэж, нүглээ наманчилж хоёр дахь боломжийг авах ёстой. Гэвч тэдний ихэнх нэг орсон л бол тэндээ үлддэг. Хэрэв тэд Диваажинд байгаа бол эсрэгээрээ, тэд Дэлхий рүү эргэж ирэхийг хүсдэггүй. Диваажинг мэдсэний дараа энэ дэлхий рүү эргэж ирээд жаргалтай амьдрах маш хэцүү байдаг. Бидэнд энд эргэж ирэхийг хүсэхээр юу ч байдаггүй. Та нар үхээд сэхсэн хүмүүсийн түүхийг санаж байна уу?. Тэд Диваажинд очиж үзсэнийхээ дараа эргэж ирээд олон долоо хоног, эсвэл сараар уйлдаг, эргэж ирдэг шалтгаан нь амьдралдаа шийдэгүй үлийн үрийн хүлээс байдаг. Тиймээс сүнснүүд энэ дэлхий рүү зөвлөсний дагуу эсвэл хүчээр ирдэг, Дэлхий рүү ирж үлийн үрийн хүлээс нь тавигдах хүртэл физик амьдралаа үргэлжлүүлдэг. Ийм л юм. Учир нь ийм. За. Та нар мэднэ, заримдаа бид нар хүртэл, Гуан Иний бясалгагчид бид бясалгах үедээ Диваажинд очиж үзээд эргээд энэ физик ертөнцөд ирээд харамсаж, гуньдаг,

Шавь: Багши аа, тамын хаалгаар орчихоод эргэж амьд гарч ирж байсан тохиолдол ер нь байсан уу?

Багш: Хэрэв цаг нь болоогүй бол тэд бүр тамын үүдээр орсноо ч мэдэлгүй, эсвэл мэдсэн ч, тамын ертөнцөд очоод эргээд ирсэн байдаг, би та нарт өмнө нь хэлсэн, учир нь тэдэнд тодорхой онцгой ач буян байдаг ба үүнийхээ үр дүнд хоёр дахь боломжийг хүртдэг юм. Тэгж сүнсээрээ орж үзсэн хүмүүс ихэнхдээ... За, жишээ нь хэн нэгэн өвчтэй орондоо хэвтэн, үл мэдэгдэм амьсгалж амьд байдаг шиг, тэгээд тэдний сүнс магадгүй там шиг, эсвэл доод ертөнцөд очиж, шүүлтээр орж, шалгуулсны дараа, доод ертөнцийн, тамын эзэн хоёр дахь боломж хүртэх эрхтэй гэж эргүүлэн илгээдэг. Гэхдээ эргэж ирээд сайн үйл хийнэ гэж амлавал шүү дээ, тэгвэл тэднийг эргэж ирэхийг зөвшөөрдөг. Тэгээд тэд ахин амьдардаг, тийм. Гэхдээ үүнийгээ олон нийтэд зарладаг нь ховор, учир нь хэн ч тэдэнд итгэхгүй. Зарим нь ном бичсэн байдаг. Ау Лакт (Вьетнам) тамд очсон хүмүүсийн бичсэн хэд хэдэн ном байдаг, тэд зовлон, бэрхшээл, айdas, уй гашуу, өвдөлтийг тэнд мэдэрсэн, тэд өөрсдөө ч гэсэн шийтгэл хүлээх шахсан, гэхдээ тэдэнд хоёр дахь боломжийг өгсөн байдаг, улмаар тэд эргэж ирээд өөрсдөдөө тохиолдсон зүйлсийн талаар ном бичиж үүгээрээ бусдад амьд байхдаа, боломж байгаа дээрээ илүү сайн зүйлс хийхийг анхааруулсан байдаг. Гэвч сонсдог хүн бараг угүй. Билэг оюун ихтэй хүмүүс тэрүүгээр ямар ч саадгүй өнгөрнө, магадгүй жаахан таагүй мэдрэгдэж болох юм.



ТАМЫН ЗАМ, ДООД ЕРТӨНЦҮҮД РҮҮ ХҮРГЭХ ДЭД ГАРЦ, ЗАМУУДЫН ТЭРГҮҮН НАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ

Хэрэв ямар нэг түвшний удирдагчийн ордон, эсвэл төв алба нь тамын "доод замууд", "доод гарцууд" эсвэл "доод дэд замууд" дээр байж таарвал тэд түрэмгийлэгч, дайны маягийн түрэмгийлэл үзүүлэх хандлагатай байдаг. Харин удирдагч, эсвэл эрх мэдэлтэй хүн тамын гарц, эсвэл дэд замын гарцууд, замын замууд дээр сууж таарвал тэд бүр их түрэмгий, дайнч хэрцгийллийн шинжтэй байдаг. Тэдэнд илүү их сөрөг, шуналтай, эзэгнэх донтой, дарамтлагч үйлдлүүд илэрдэг.

Хятад, Аулакт (Вьетнам) урьд нь шинэ хаан, эсвэл шинэ төр засаг сонгогдох үед тэд бүр нийслэлээ өөрчилдэг байсан. Магадгүй тэд мэддэг байсан байх, тэдэнд зарим нэг сүнслэг багш нар хэлсэн байх. Гэвч орчин үед тэд байраа сольдоггүй, нэг их сольдоггүй болжээ. Хуучин ордонд буюу "дайсан" гэгчийнхээ ордонд үлдэж, эсвэл өвлөн авдаг шалтгаан нь тэдний муу үйлийн үр байдаг ба үүнээс болж тэд тэнд хүлэгдэж, эсвэл тэднийг тийш хөтөлж, эсвэл тийш чирч, аваачсан байдаг. Тиймээс үргэлж өөрчилж байх нь дээр байдаг.


Хэрэв тэр нь азгүй бол, хэрэв тухайн хүн дайнд чинь ялгадж, чи ялж, тэднийг бүгдийг алж, туслахууд, зөвлөхүүд, гэр бүлүүдийг нь тэнд алсан бол тэр нь азгүй ордон байх ёстой тийм биз? Тэгвэл тэндээс хол байх ёстой. Хүмүүс дайсныхаа ордонг хүртэл авдагт би гайхдаг. Яаж тэнд амьдарч чадна вэ? Бүгдийг санасаар байх биш үү, тэгээд энерги чамтай зууралдаж, хүлэгдэнэ. Хэрэв азтай газар байсан бол тэр дайнд ялгадахгүй байсан, тийм биз? Тэр ордоо чамд алдахгүй байсан.

Би там, эсвэл доод ертөнцийн гарцууд, холбох газрууд гэх мэт зүйлс хэлж байгаа ч, энэ бүхэн нь тухайн удирдагчидтай хэр ойр байгаагаас шалтгаална. Төв албаных нь энд байлаа ч, удирдагчийн ширээтэй ойрхон биш байж болно, тэгвэл нөлөө нь бага байх болно, их бага хэмжээгээр, гэхдээ л нөлөө нь хүчтэй. Бага ч байж болно, их ч байж болно, удирдагчаас мөн хамаарна. Тийм, ёс суртахуун нь өндөр эсвэл муу, дотроо хүчирхийлэгч чанар багатай зэргээс хамаарна, бага бол нөлөө нь бага. Эсвэл зам, гарц нь өөр бусдаас хүч сультай байхаас хамаарах жишээтэй. Тиймээс энэ бүгдээс шалтгаалах хэдий зарим нь дэд гарц дээр сууж байх ч, уг дэд гарц нь өөр нэг дэд гарцаас хүчээр сул байж болно, эсвэл замын гарц, доод ертөнцийн гарц бусдаас хүч багатай байж болно. Там болон доод ертөнцүүд хүчний зэрэглэлтэй байдаг. Амьд байхдаа хүний хийсэн төлөөсөөс хамаарна.

Би та наарт зөвхөн удирдагч нарын байгаа газрууд, ордон, төвүүдийг хэлэх болно, учир нь тэдгээр нь бүх бүлэг, эсвэл нийт бүс нутаг, бүх дэлхийд нөлөөллөө үзүүлдэг хүмүүс. Бурхан минь би энэ бүгдийг дотроо шалгаж байх үедээ би аиж, маш их уйлж, ихээр харамсаж байлаа. Мэдээж хэрэв улс оронд илүү их сөрөг гарцууд байх тусам тухайн улс илүү эмзэг байх болно, зөвхөн удирдагч нь биш, шалтгаан нь удирдагч ганц хоёр сөрөг гарц дээр сууж буйгаас биш, харин нийт улс нь сөрөг бүс газар ихтэйгээс юм.



Афганистан :
Ерөнхийлөгчийн ордон, 1 доод ертөнцийн гарцтай, 1 доод замтай. Түүнд үзүүлдэг нийт сөрөг нөлөө 120%. Хөөрхий залуу. Одоо тэгээд ерөнхийлөгч байхыг хүссээр үү? Үгүй гэж найдаж байна. Афганистаны цэргийн төв газар хүртэл дотроо 1 том, доод гарц, 1 доод замтай, нөлөө нь илүү хүчтэй буюу цэргийн хүчинд 130%-ийн нөлөө үзүүлдэг, цэргийн удирдагчид үзүүлэх нөлөө нь. Мэдээж, цэргийн удирдагч нь бүх цэргийн хүчинд нөлөөлөх нь мэдээж. Талибаны төв дотор 1 доод зам байдаг, нөлөө нь зөвхөн 90%. Бурхандаа талархья. Магадгүй ийм учраас үйл ажиллагаа нь багассан байх, тийм үү? Өөрөөр хэлбэл тэдний үйлдэл, хааяа нэг, хаа нэгтээ гардаг болсон. Энэ хэдий аймшигтай ч хэрэв тэдний төв илүү сөрөг газар байсан бол бүр дор байж болох байсан.



Хятад :
Ерөнхийлөгчийн ордон, 1 дэд доод зам... 1 дэд доод гарц дотор нь бий, нөлөө нь

100%, 1 доод зам, доод гарц, доод ертөнцийн зам бас дотор нь бий, нөлөө нь бас л 100%, иймээс нийлээд 200%-н нөлөөтэй. Хятадын ерөнхий сайдын ордонд 1 доод зам бий нөлөө нь 100%. Нийлээд тэндхийн төр засгийн удирдагчид, тэргүүнүүдэд нөлөөлөгч сөрөг нөлөө 300%.

 Герман: одоохондоо юу ч байхгүй, гэхдээ түүхийг бодож... Би сониучирхсан юм. Хэрэв Германд ямар ч тамын гарц байхгүй, юу ч байхгүй байсан бол ягаад? Ойлгож байна уу?

Ягаад урьд нь Нацистуудын асуудал бидэнтэй тулгарав? Тиймээс би илүү нэмэлт судалгаа хийсэн. Сонирхолтой нь Фюрер, Гитлерийн төвд 1 дэд доод ертөнцийн гарц, тэр нь тэгэхдээ том, дэд гарц байсан ба мөн хоёр доод зам байсан, ойр хавьд нь хоёр доод зам 2-3 метрийн зайнд мөн 1 метрийн зайнд 1 тамын зам байсан, тэрчлэн дотор нь 1 тамын гарц, 1 тамын зам байсан. Маш олон сөрөг гарцууд, замууд байсан учраас тийм зүйл болжээ. Гайхах зүйлгүй. Эдгээр зүйлс нь үнэхээр бодолцвол зохих зүйлс. Хэн ч тэр төвийг ашиглахгүй гэж найдаж байна. Одоо музей болгосон.



Ирак: ерөнхий сайдын ордон дотор нь 1 том доод ертөнцийн гарц, 2 доод зам байдаг.

4 метрийн зайнд 2 доод ертөнцийн зам бий. Нөлөө нь 260%.

Иран: Ерөнхийлөгчийн ордонд 1 тамын зам бий; нөлөө нь 150%. Ираны цэргийн төвийн дотор 1 доод ертөнцийн гарц мөн 1 дэд доод гарц бий. Нөлөө нь нийтдээ 300%. Тэгэхээр ерөнхийлөгч болоод цэргийн удирдагч нарын шийдвэрт нөлөөлдөг, эсвэл тэдний хувийн сайн сайханд нөлөөлдөг сөрөг хүчний нөлөө нийтдээ 450%

Израиль: Ерөнхий сайдын ордонд 1 дэд тамын гарц, 3 тамын зам байдаг ба 2 метрийн зайд 1 тамын зам бий. Нийт сөрөг нөлөө 450%. Израилийн цэргийн төвд 1 дэд доод гарц, 1 тамын зам 4, 20 метрийн зайд байдаг, мөн 1 доод гарц... 1 доод зам бас ойрхон байдаг, тэрчлэн 3 доод зам дотор нь бий. Нийт нөлөө нь 360%. Би удирдагч ч бай угуу ч бай тэнд байхыг хүсэхгүй.

Либи: Удирдагчийн гэрт 1 дэд тамын гарц, 1 метрийн зайд 1 тамын зам, 2 метрийн зайнд 1 тамын зам, гэрт нь 3 тамын зам бий. Нийт сөрөг нөлөө 500%


Пакистан: Ерөнхий сайдын ордонд ойрхон 1 доод ертөнцийн зам бий, нөлөө нь 40%.

Ерөнхийлөгчийн Ордонд 1 том доод ертөнцийн гарц бий. Ерөнхий Сайдын ордон доод ертөнцийн замаас ердөө 4 метрийн зайд байдаг бол Ерөнхийлөгчийн Ордонд 1 том тамын гарц байна. Түүнд нөлөөлөх сөрөг нөлөө 340%. Пакистаны цэргийн төв албаны дотор 1 том доод гарц

байдаг ба нөлөө нь 300%, мөн 1 доод зам дотор нь байна. Нийтдээ 300% нөлөөтэй. Пакистан дахь Ал Каидагийн төвд 1 том доод ертөнцийн гарц 1 доод ертөнцийн зам бий. Нөлөө нь 300%. Цэргийн хүч болоод Ал Каида бүгд сөрөг нөлөөнд байдаг ба ерөнхийлөгч, ерөнхий сайд нь ялгаагүй байна. Ерөнхий сайд нь хамгийн бага сөрөг хүчний нөлөөнд байдаг, гэхдээ ерөнхийлөгч, цэргийн хүч, Ал Каидагийн удирдагчид бүгд маш хүчтэй сөрөг хүчний нөлөөнд байдаг.




Хойд Солонгос: дээд удирдагчийн Гэрт нь, 1 том тамын гарц бий, 1 том гарц дотор нь мөн 1 тамын зам бас бий, нийт сөрөг нөлөө 400%. Ийм ч учраас ийм тийм зүйл болж, энх тайван угүй байдаг байх нь.



Монгол: Ерөнхийлөгчийн ордоос метрийн зайд 4 метрийн зайд 1 доод зам, 8 метрийн зайд 3 доод ертөнцийн замууд бий. Нийт нөлөө нь 30% учир нь хол зайд оршдог, бас магадгүй зам болон гарцуудын хүч сул байж болох юм.

Орос: Одоо засгийн газарт нь асуудал алга, гэвч ягаад урьд нь тэдэнд асуудал гарч, ягаад тэд өөр бусад Европын улсуудад муугаар нөлөөлснийг би асууж судалсан, би өмнөх удирдагчийн талаар судалсан. Сталин гэх мэт өмнөх төрийн удирдагчийн төв байр, гэрийг судалсан. Тэнд 1 дэд тамын гарц, ойрхон 2 тамын зам, дотор нь 2 тамын зам байсан. Ойр байсан хоёр тамын зам нь 1, 2 метрийн зайд байсан, дотор нь хоёр тамын зам, тэгэхээр дотроо нийт 1 тамын гарц, 2 тамын замтай байсан. Нөлөө нь 560% байжээ.



АНУ: Цагаан Ордон, 1 дэд доод гарц 3 метрийн зайд байна, мөн 1 доод зам Цагаан Ордон дотор байна. Тэнд байгаа ерөнхийлөгч, ажилчдад үзүүлэх сөрөг нөлөө 120%.

Сүнслэг Адислалт Шулцуунууд болон диваажинийн үүд

Шавь: Хэрэв Бермудын гурвалжин шиг газар болон тамд хөтөлдөг гарцууд байдаг бол дэлхий дээр мөн Диваажиннд хөтөлдөг гарцууд гэж бий ю? Диваажин шиг эерэг газар дэлхий дээр бий ю?

Багш: Тийм, мэдээж бий байгаа, мэдээж.

Шавь: Хөөх, Багши аа. Багши бидэнд тэдгээр нь хаана байгааг хэлж болох уу?

Багш: Тийм, тэгье. Азаар бид бүхий л сансар огторгуйтай холбоотой. Хэрэв доогур ертөнцтэй холбодог зүйл байгаа бол дээд ертөнцтэй холбогч холбоос мөн байгаа, билэг оюунлаг, сайн хүмүүст зориулагдсан холбоосууд. Гэгээнтнүүд мөн тэдгээр холбоосыг ашиглан сүнслэг орчлоос энэ физик ертөнцөд ирж явахдаа, төрөл олохдоо эсвэл ирж тусламж хэрэгтэй хүмүүст туслах үедээ тэдгээрийг ашигладаг. Өөр өөр түвшинтэй холбосон гарцууд, замууд байдаг ба бид өөрсдийн ач буянаасаа шалтгаалж доод, эсвэл дээд түвшинтэй холбогддог.

**Шавь: Та хаана байдгийг нь хэлж өгөхгүй юу
Багши аа.**

Б: Энэ их том, бурхны аврал. том жагсаалт байна. (алга ташилт) Энд надад том жагсаалт байна. Бидний аз болж Диваажингийн гарцууд, замууд нь там болон доод ертөнцийнхтэй харьцуулах юм бол хамаагүй их, маш их байдаг. Энэ сайн мэдээ шүү. За. Тэгэхээр Диваажин хэзээд там болон доогур ертөнц, сөрөг хүчинээс илүү хүчтэй байдаг нь мэдрэгддэг. Яагаад гэвэл хүмүүс төрөлхийн сайн, тийм биз? Тиймээс там уг нь огт байх ёсгүй юм. Гагцхүү сөрөг хүчиний хаан энэ дэлхий дээр хүмүүсийг уруу татах муу зүйлс бий болгодог ба түүнээс тэгээд бүх зүйл доош урууддаг. Одоо би та нарт Диваажингийн гарцууд хаана байдгийг хэлж өгье, та нар очиж үзэхийг хүсч магадгүй. Тэдгээрийн тодорхой байршлыг хэлнэ гэвэл надад маш их асуудал гарна. Би тухайн газар байх ёстой, тэгээд мөн зөвшөөрөл авах хэрэгтэй ойлгож байна уу? Тэгэхээр байршлыг нь оллоо ч хэлж болох эсэх чухал. Ойлгов уу? Гэхдээ одоо зүгээр ерөнхийлсөн байдлаар, ямар улсуудад тэдгээр нь байгааг хэлж өгч болно. За тэгэхээр Европт хамгийн их Диваажингийн гарц байна. Испанид 13 диваажингийн гарц байна, арван гурав. Италид 4, Францад 2, Германд 3, Англид 2, Финландад 2, Голландад 2, Австраид 2, Словенид 1, Польшд 3, Данид 2, Бельгид 4, АНУ-д 2, Канадад 4, Бразилд 4, Мексикт 4, Энэтхэгт 9, Узбекистанд 2, Сиерра Леонед 2, Замбиад 3, Лаост 2, Шри Ланкад 3. Зарим нь та нарын урьд нь сонсож байгаагүй орнууд. Газрын зураг дээр хаана байдгийг нь ч мэдэхгүй. Өмнөд Тайл ба Антарктидад 300 байна. Мэдээж тэнд тэдгээр нь үл хөндөгдсөн байдалд байдаг. Диваажингийн гарцуудыг аль нэг хүний хөндсөн хотод барьснаас тэнд барих нь хялбар, тийм

биз? За. Өмнөд болон Хойд Тайл нь амар тайван газар гэдгийг Диваажин мэддэг байж таараа.. Хойд Тайлд бүр ч их байдаг байна тэнд 500 байдаг. Номхон Далайд 8, Энэтхэгийн Далайд 3, Атлантын Далайд 6, Газрын Дундын Тэнгист 3, Гималайн ууланд 21. Эдгээр нь тэгэхээр энэ дэлхий дээр байгаа Диваажингийн гарцууд. Диваажин нь маш олон түвшин, ангилалтай байдаг тул мөн Диваажинг өөр өөр хэсэгт эсвэл өөр өөр Диваажинд өөр өөр төрлийн хүмүүс очдог учраас нийтдээ 916 ийм гарц байдаг байна. Тийм, аль нэгтэй нь таарахыг хичээгээрэй. Хaa сайгүй байдаг тул зүгээр л Хойд болон Өмнөд Тайлд очвол ядаж нэгтэй таарах магадлал өндөр, учир нь тэнд маш олон гарцууд байдаг. Эсвэл Гималай явах юм уу, эсвэл Испани орж болно.

Шавь: Багши аа, Диваажингийн үүд адислалтай байдаг уу?

Багш: Тийм, мэдээж, мэдээж. Тэдгээр нь адислалтай. Би жагсаалтаа шалгаадахья, байгаа эсэхийг нь шалгая? Диваажинтай хуудсууд хаашаа орчихов оо? Аль ч гарц нь 8000% сүнслэг адислалтай байдаг, их бага хэмжээгээр. Энэ нь хамгийн бага хувь, билэг оюунлаг бясалгагч доод тал нь 8000% хүртэнэ. Жишээ нь Диваажингийн хаалганы үүдэнд суувал, тэгээд их чин сэтгэлтэй, билэг оюунлаг бол 8000%-ийн адислал хүртэнэ. Зарим Диваажингийн үүд илүү адисладаг, шалтгаан нь тэр нь илүү дээд Диваажинтай холбоотой байдаг, Тэрчлэн Диваажингийн замууд нь Диваажингийн гарцтай холбогддог тул хэрвээ тийм замд байвал доод тал нь 5000% адислал хүртэнэ, тийм холбоо замын голд байвал шүүдээ, ингэхдээ билэг оюунлаг, чин сэтгэлтэй байвал доод тал нь 5000% адислал хүртэнэ. Хэрэв билэг оюунгүй, ямар нэг сүнслэгт суралцдаггүй хүн бол юу ч хүртэхгүй. Онцгой билэг оюунтай, гэгээнтэн мэт, чин сэтгэлтэй байх ёстой. Тийм. Диваажингийн үүдийг олох хэцүү, тэр нь тэгээд зөвхөн нэг хагас кв.метрийн өргөнтэй, тиймээс тарган хүн багтахгүй байж мэднэ. Диваажингийн замууд нь 1 метрийн өргөнтэй. Там руу хөтөлдег замууд нь мөн ижил. Тамын үүдүүд бага зэрэг том, доогур ертөнцийн гарцууд илүү өргөн. Тамын замууд ер нь төстэй,

Шавь: Диваажингийн тэдгээр үүд нь – аль Диваажинд хөтөлдөг вэ?

Багш: Доод түвшингийх нь Хоёрдугаар Түвшинд, эсвэл дээд астрал түвшинд. Хамгийн дээд нь Тавдугаар Түвшинд, тийм. Гэхдээ тэр нь холбоотой, холбосон зам байдаг юм. Мөн Тавдугаар түвшнээс дээгүүрх Диваажинтай холбодог онцгой “холбогч нислэг” байдаг, тэр нь онцгой цөөн хэдэд зориулагдсан, зөвхөн онцгой цөөн хэд ашиглагддаг. Хэрэв тэд Таваас дээш түвшнээс ирсэн бол эргээд Таваас дээш түвшин рүү буцдаг, гэхдээ тэдгээр нь өөр төрлийн холбоос ашигладаг.

ОНЧ МЭРГЭН ЧГСЭЭС

Та энэ дэлхийг амьдарч байгаа хэдий ч сэтгэл хүлэгдэх хэрэггүй. Энэ дэлхий дээрх бүх юм зовлон гэдгийг мэдэж, яг л намагт нууранд бохирдохгүйсээр орших лянхуа нэнэг шиг хамгийн төгс сургаалд сэтгэлээ дадуулах хэрэгтэй.



Оюун санааны дадлын хамгийн дэвшилтээт дээд арга дандаа энгийн байдаг. Хүмүүс будлантай ярвигтай байдалд дасчихсан байдаг учраас энгийн, ердийн болохоор нь ойлгодоггүй юм.



Бидний оюун санааны бясалгал дадлын зорилго бол билэг ухааннаа нээх, эх болсон зургаан зүйлд туслах, энэ дэлхийн хүч чадал, соёл иргэншилийг дээмлүүлэх явдал юм.



Гэгээрсэн Багшийг хайрлах үед түүний сайн сайхан чанарууд өөрийнх тань болж, хайр адислал нь таныг ивзэнэ. Та улам ухаалаг, амар алгалан, билэг ухаантай болно.



Энэ бие махбодыг эрүүл байлгахын тулд танд хоол хүнс хэрэгтэй байдагийн нэгэн агуул сүнсэнд тань өсөж бойжихын тулд хайр хэрэгтэй.



Үяраан хайрлах нь дайснаасаа салах хамгийн сайн арга, та ингэж тэднийг хайраар ялах болно.



Шүүмжлэл сайн ч, хайр хамгийн сайн нь...



Хэн нэгнийг хайрлахдаа, түүнд аз жаргал өгч, халамжилж хамгаал. Энэ бол жинхэнэ аугаа хайр. Хэрэв түүнээс өөртөө хайр халамж хүсэж, оюун санааг нь самууруулан зовоож байвал хайр биш харин үзэн ядалт юм.



Бусдыг хайрлана гэдэг өөрийгөө хайрлахын нэр, бусдыг үзэн ядна гэдэг өөрийгөө үзэн ядахын нэр.



Бусдад хүндлүүлэхээсээ өмнө та өөрийгөө хүндлэх ёстой. Та өөртөө итгэхгүй бол хэн ч танд итгэхгүй. Аугаа байдлаа таньж мэдэхгүй бол өөр хэн ч таны аугааг таньж мэдэхгүй.



Бусдад зэмлүүлнэ гэдэг тэднээр магтуулж байгаа хэрэг.



Хүчтэй хүсэл тэмүүлэл, сайн дадал зуршил, сайн хүмүүстэй холбогдож харьснаараа та маш олон муу зуршилаасаа сална.



Өөрийгөө өөрчилж сайжруулна гэдэг нь энэ дэлхийг өөрчилж засаж буйтай агуул юм.



Өөртөө хэдий ихийг хураана, төдий чинээ алдана, хэдий ихийг өгнө, төдий ихийг олно гэдэг нь өртөнцийн хууль юм.

Заримдаа та зөвж, өвөрж, асуудалд ордог, энэ ч миний үйл үр дээ гэж боддог. Гэвч үүнийг бас зүсээ хувилгасан хайр адислал гэж таних хэрэгтэй.



Тамыг ч, диваажинг ч, бүгдийг нь та бий болгогог.



Үнэн мөн болоод шударга ёсонд итгэдэг, өндөр ёс суртахуунтай, эмзэг бус хүмүүсийг Бурхан хайрлан халамжлах болно.



Оюун ухаан тань тогтуун, алгалан үед асуудал бэрхшээлийн тань хариулт гаралд ирнэ.



Бидэнд өөрт, зохион байгуулалтад маань хамгийн хүчитэй дайсан гэж юу ч байдалгүй. Харин бидний би үзэл, бардамнал л хамгийн айхтар дайсан.



Хотол олонд үйлчилэх үед Бурхан мөн танг үйлчилдэг. Энэ бол орилон өртөнциөг үйлчилдэг хууль юм.



Хүнд юм өгч байхдаа, зөв хүнд нь хүргэг гэж Бурхны итгэж өгсөн үүрэг хариуцлагыг л бид гүйнэлдүүлж байдал.



Даруу төлөөв хүмүүс Бурхан болоод гэгээнтнүүдэд ойр, нэвэр ариун сэтгэлтийн үнэн ёсонд илүү ойр. Бардам байхын хэрээр бид үнэн ёсноос холдог.



Бид олон түмэнд үйлчилж байхад Эзэн Бурхан бас бидэнд үйлчилж байдал. Орилон өртөнци ийм хууль дор оршин тогтнодог.



Энэ дэлхийн байр суурь бол эд, баялаг, гол сайхан биш ээ. Зөвхөн жинхэнэ билэг ухаан л таны хамгийн их итгэж наидаж болох зүйл юм.



Үнэнийг хайж байх үед хамгийн чухал зүйл бол бусдыг шүүмжлэхгүй мөн зурх сэтгэл нээлттэй байх явдал юм. Энэ бол үнэхээр чухал



Үнэн бол засаж янзласан Нярваан эсвэл Бурхны орон биш, гагихуу мөнхийн өсөж хөгжих үйл яви



Өөрийгөө зовоолоо ч бусдыг хэзээ ч битгий зовоо! Энэ амьдралд ч цанггуух өртөнциөг ч мартах ёсгүй үнэн юм. Энэ бол бүхнээс хамгийн чухал шаардлага.



Шийтгэхээс уучлах нь илүү амар. Та ч энэ тухай нэг их бодохгүй, тэр хүн ч жаргалтай. Танд ямар нэг дарамт учруулахгүй болохоор энэ нь илүү хялбар


СЭРЖ СЭХЭЭРЭГТҮЧН

Их багин Чин Хайн шүлэг

Унаган дэлхий минь, сэргж сэхээрэгтүн!
 Уул ус чийдэн хямарч, ой мөд энэлэн шатаж,
 Хавийн толгод элэгдэн үзүүрч, гол горхи ширгэжээ.
 Хөөрхий сүнснүүд энэстээ хааш одохсон билээ?
 Аяа, асар дэлхий мину, шөнөжин асгарах нүүлийн
 Шаналан юу тань ашиглаасай.

Аяа, тэнгис далай мину, аялгуу дуугаа бүү аниглаасай,
 Шантрал үзүй маргаанийн итгэлийг хүмүүст цэдэгээсэй...
 Хамаг амьтан Тса мину, чг очиггүй онгөрөн одсон ч гээ
 Холын чанад өртөнцөд амарлин амсхий дээ.
 Халуун зүрхний минь цохилж намжаархан зөвлөг..

Харин би тэр зуур дэлхийн хүмүүсийн гэмшилийг хүлээж сүүя.
 Түнэр өтгөн ой минь, унаган төрхөө хадгалж,
 Түүнэн олон хүмүүнийг төөрөлдөж явахад нь хамгаална уу.
 Чин зүрхнээс минь ундаарсан нүүлийн мянган дуслаа
 Члэмж сүрлэг мөдөг, чндэс мөчирөө усална уу.
 Өр зүрх минь, өрөвдөн уйлахаа аядуул даа,
 Өнийн үрт шөнүүдэд сүнсээ амарлиулья.
 Үйт зөвлөнд шаналагсын төлөө мэгиссээр
 Үрсах нүүлийн эгшиг, үрсгах чг цөөрч дээ.
 Аяа түнээр шөнө минь, аян замыг нь гийцүүрэн,
 Алаг харанхуйд бүдчих хүмүүн сүнснүүдэд гэрэл өгөгтүн.
 Аялгуу төгөлдөр хоосон чанафт нэвчин
 Амаржин тогтнож хайрла, амгалан байг сэтгэл минь.
 Аяа өдөр минь, амар амгаланг зүрх бүхэнд оршиохын тул,
 Ард оны тэмиэл зөрчлийг ашиг намжаахын төлөө,
 Аяа гайхамшигт мөн чанаараа баходтайяа гэрэлтүүлэхийн төлөө
 Аюул дамлах гэнэтгийн чиймээнийг бүү өдөө.
 Аяа, сэтгэл зүрх минь, тэсгим өвлийн жаварти
 Аюун тарчлагч шавж мэт ахин бүү шаналааг.
 Тэнгэрийн суу дэлхийг чимэглэх
 Төгс маргаанийн тэр л өдрийг хүлээг.
 Аяа, бүрхад хийгээд Тэнгэр Элч нар мину,
 Аврал эрэн би уйлнам, залбирнам, гүйнам.
 Чинэй Замаас төөрөн, тамын тойрогт хэрсэн
 Чийлж хөөрхий сүнснүүдийг энэрэн чөлөөлж хайрла!
 Аяа, ах минь, сэргж сэхээрэгтүн!
 Агуу их тэнгисийн дээгүүр барагчан алхагтун,
 Асан дүрэлзэх наран өөд эгцэн харж,
 Амьтан бүхнийг аврахын төлөөсөнд өөрийгөө зориулагтун!
 Аяа, эгч минь, сэргж сэхээрэгтүн!
 Аладарч сүйрсэн суурин аасаа өндийн босогтун!
 Эх дэлхийгээ бүгдээр нийлэн сэргээн мандуулдя,
 Эвийн дуугаа цэнгэлтэйеэ дуулигдая!



**Төгс Гэгээрсэн Их Багш ЧИН ХАЙН авшигтан шавь нарын үүсгэн байгуулж,
НИЙГЭМД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ байгаа төрийн бус байгууллагууд,**

| № | Байгууллага | Тэргүүн | Үйл ажиллагааны чиглэл |
|----|--|-------------|--|
| 1 | Сонгодог хүнс судлан дэлгэрүүлэх академи | О.Ганболд | Цагаан хоолны судалгаа, шинжилгээ |
| 2 | Энэрэнгүй хоолны холбоо ТББ | Б.Мөнхтуяа | Веган хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, сурталчлах |
| 3 | Мацаг хоол энх амгалан ТББ | С.Одхуяг | Нүгэл хилэнцгүй хоол хүнсний хэрэглээг сурталчлах дэмжих |
| 4 | Цагаан хоол-ногоон гараг ТББ | Н.Оюундарь | Цагаан хоолны үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих |
| 5 | Судлалт ертөнц ТББ | Р.Баярбат | Судлалт ертөнцүүдийн тайллыг толилуулан тольт хөтөч болох |
| 6 | Их хотол мандал ТББ | Ү.Чинсүх | Гэгээрээл, ариуслын ном сургаалыг дэлгэрүүлэх |
| 7 | Эх дэлхийгээ аварцгаая сан ТББ | Л.Алтанхуяг | Байгаль орчныг хамгаалах, цаг уурын өөрчлөлтийг сааруулах |
| 8 | Ургамал хүнс судлан дэлгэрүүлэх академи | Р.Баярбат | Ногоон оршихуйн тайлал болсон судлалыг түмэнд хүргэх |
| 9 | "Веган гэгээнтнүүд" клуб | Ч.Даахүү | Эх дэлхийгээ аврахын тулд ногоон хоолтон болох үйл ажиллагаа явуулах |
| 10 | Веган залуучуудын байгууллага | Ч.Даахүү | Эрүүл зөв амьдралын хэв маяг, чөлөөт цагаа хөгжилтэй өнгөрүүлэх |
| 11 | Ногоон клуб | Н.Энхжаргал | Архи, тамхигүй амьдралын хэв маягийг хэвшүүлэх, уриалах |

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮД


| | Байгууллага | Эрхлэгч | Үйл ажиллагааны чиглэл |
|---|-----------------------------------|----------------|---|
| 1 | Билгүүн толь сонин | Н.Төмөрбаатар | Гэгээрэл, бясалгалын сонин |
| 2 | Мацаг хоол эрүүл мэнд сэтгүүл | С.Содномбалжир | Цагаан хоолны эрүүл мэндийн ач холбогдол, зөв амьдрал |
| 3 | Алтан эриний нууц сэтгүүл | С.Содномбалжир | Бурханлаг мэдлэгийг түгээх |
| 4 | Их оюунлаг хүн сэтгүүл | Л.Алтанхуяг | Иргэдийг эерэг, оюунлаг мэдээ мэдээллээр хангах |
| 5 | Судлалт ертөнц сэтгүүл | Ч.Даахүү | Амьдралын хэв маягийг ёс суртахууны өндөр хэлбэрт хүргэх |
| 6 | Шинэ эриний эрүүл амьдрал сэтгүүл | Ө.Цэндхүү | Ургамал хоолны ач тус, эрүүл мэндийн ач холбогдлыг сурталчлах |
| 7 | Веже телевиз | Л.Энхтайван | Байгаль орчин, ногоон оршихуйг сурталчлах |
| 8 | Оюунлаг телевиз | С.Одхуяг | Эрүүл, зөв амьдралын хэвшилд дадах |



Ma:
☆ Chi
Practi

АМЬДРАЛЫН МААНЬ ҮҮРЭГ ЗОРИЛГО ЯМАР БАЙХААС ХАМААРАХГҮЙ, БИЕ БИЕЭ ЭНЭРЭН ХАЙРЛАХ НЬ ЭНЭ ДЭЛХИЙН ХАМГИЙН ЧУХАЛ ЗҮЙЛ ЮМ


Төгс Гэгээрсэн Их багш Чин Хай



Төгс гэгээрсэн их багш Чин Хай хүн төрөлхтнийг зовлонгоос гэтэлгэхийн төлөө гэгээрлийн зам мөрийг сонгосон билээ. Тэгвэл өнөөдөр гараг дэлхий хүн төрөлхтнийг аврах нь Түүний хувьд урьд урьдаас илүү тулгамдсан асуудал болоод байна. Өнгөрсөн бүх он жилүүдийн туршид тэрбээр эцэж цуцахыг үл хайхран дэлхий даяар аялж, түмний тусыг бүтээж ирсэн билээ. Түүний хүмүүнлэг энэрэнгүй тусlamж нь аливаа саад хоригийг даван туулж, засан хүмүүжүүлэх газар хоригдогсод, өндөр настнууд, оюуны хомсдол, хөгжлийн бэрхшээл, өвчин эмгэгтэй, ядуу зүдүү, орон гэргүй хүмүүс, ахмад дайчид ба байгалийн гамшигт өртөгсдийг ивээж байдаг. Их Багшийн хайр энэрэл нь дэлхийн сая сая хүний сэтгэл зүрхэнд хүрч, Түүний үлгэр дуурайллаар Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг үүсэн байгуулагдсан юм.

Бясалгалын үрээр Их Багш дотоодод нууцлагдаж байсан олон авьяас чадвараа нээсэн бөгөөд эдгээр нь түүний уран бүтээл болох зураг, дуу хөгжим, яруу найраг, хувцас, гоёл чимэглэлийн дизайн зэрэгт тусгалаа олж байдаг юм. Уран бүтээлийн орлого, хөрөнгө сангаасаа Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай яарч зүдэрсэн олонд тусlamж хандив өргөдөг. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн хүмүүнлэгийн болон гамшигийн үед үзүүлсэн тусlamжийн заримаас дурдвал:


| | |
|--|------------------------|
| Дэлхий даяарх үер, газар хөдлөлт, гол түймрийн гамшиг зэрэгт. (2008 оны 2-р хагаст) | US\$1,000,000 гаруй |
| Хятадын Сичуань Юннань дахь газар хөдлөлтийн үеэр үзүүлсэн (2008 оны 5-9 сар) | \$328,600 |
| Мианмарын Наргиз циклоны үеэр тусlamж (2008 оны 5 сар) | \$126,000 |
| Гаити, Доминикан Улс, Куба, Мексикийн хамарсан Ноел хар шуурга (2007 оны 11-12 сар) | \$73,800 |
| Умард Солонгосын үерийн үеэр тусlamж (2007 оны 8-11 сар) | \$76,700 |
| Перугийн газар хөдлөлт (2007 оны 8 сар) | \$70,100 |
| Дарфурт хүмүүнлэгийн тусlamж (2007 оны 6 сар) | \$200,000 |
| АНУ-ын ядуусыг хямд орон сууцаар хангах төсөлд (2007 оны 2 сар) | \$20,000 |
| Филиппиний Дуриан хар шуурганы үеэр тусlamж, хүмүүнлэгийн айлчлал (2006 оны 11-12 сар) | \$430,000 |
| Азербайжан дахь дүрвэгсдэд хандив (2006 оны 11 сар) | \$22,000 |
| Азербайжан дахь дүрвэгсдэд хандив (2006 оны 11 сар) | \$22,000 |
| Бурундиин Каменге Өсвөр Үеийн Төв (2006 оны 9 сар) | \$30,000 |
| Мараккогийн амьтан авран хамгаалах байгууллага-Hanane Abdelmoultalib (2006 оны 9 сар) | \$10,000 |
| Ау Лак (Вьетнам) улсад оруулсан хандив (2006 оны 7 сар) | \$65,000 |
| Кени улс, гангийн эсрэг худаг ухаад (2006 оны 4-10 сар) | \$96,100 |
| Кашмир ба Пакистаны газар хөдлөлт (2005 оны 10 сар) | \$202,400 |
| Катрина далайн шуурга – АНУ (2005 оны 8-9 сар) | \$92,700 |
| Болгарын үер (2005 оны 8 сар) | \$20,000 |
| Банд Эйд Буяны Сан- Их Британи (2005 оны 3 сар) | \$100,000 |
| Коста Рикагийн үер (2005 оны 1 сар) | \$41,000 |
| Индонез ба Шри Ланка-Өмнөд Азийн цунами (2004 оны 12 сараас 2005 оны 2 сар) | \$135,500 |
| Ираны газар хөдлөлт (2003 оны 12 сар) | \$70,000 |
| Умард Тайландын уугуул иргэд (2003 оны 11 сар) | \$2000 |
| Өмнөд Солонгосын Маэми хар салхи (2003 оны 9-11 сар) | \$49,900 |
| Баруун Хойд Энэтхэгийн тариачдад үр худалдаж авахад (2003 оны 7 сар) | \$29,900 |
| Алжирын газар хөдлөлт (2003 оны 5 сар) | \$153,400 |
| Аргентины үер (2003 оны 4 ба 11 сар) | \$29,000 |
| Афганы дүрвэгсдэд (2001 оны 10 сар) | \$100,000 |
| АНУ-ын 9 сарын 11-ний халдлагад өртөгсдөд (2001 оны 9 сар) | \$361,000 |
| Эль Сальвадорын шар чичрэг өвчин, өнчин, ядууст (2000 оны 10-11 сар) | \$75,700 |
| Өмнөд Африкт хийсэн хүмүүнлэгийн айлчлал (1999 оны 12 сар) | \$161,800 |



| | |
|---|-------------|
| Формоса (Тайвань) газар хөдлөлт (1999 оны 9 сар) | \$439,000 |
| Туркийн газар хөдлөлт (1999 оны 8 сар) | \$135,000 |
| Козовогийн дайнд нэрвэгдэгсдэд ОУУЗН (1999 оны 6-8 сар) | \$100,000 |
| Арменид хийсэн хүмүүнлэгийн айлчлал (1999 оны 5 сар) | \$250,000 |
| Филиппиний ой нөхөн сэргээх, хөрс хамгаалах (1999 оны 2 сар) | \$100,000 |
| АНУ-ын Лос Анжелес хотын Шрайн концертын их танхимд хийсэн буяны тогтолт (1998 оны 12 сар) | \$250,000 |
| Гондурасын Митч далайн шуурга (1998 оны 11-12 сар) | \$28,800 |
| Суданы өлсгөлөн, дайнд нэрвэгдэгсдэд ОУУЗН (1998 оны 9 сар) | \$99,900 |
| АНУ-ын АмериКерс (1998 оны 4 сар) | \$100,000 |
| Канадын Мөсөн Аадар (1998 оны 1 сар) | \$42,300 |
| АНУ-ын Вашингтон ДС, ДАР Үндсэн Хуулийн Танхимд хийсэн "Гоо Сайхны Ертөнцөөр Аялахуй" буяны концерт (1997 оны 12 сар) | \$200,000 |
| Чилийн үер (1997 оны 7 сар) | \$30,000 |
| Руандагийн дайнд нэрвэгдэгсдэд (1997 оны 4 сар) | \$100,000 |
| Формоса (Тайвань) Өвөлжилтийн тусlamж (1996 оны 11-12 сар) | \$767,700 |
| Венесуэлийн үер (1996 оны 7-8 сар) | \$33,400 |
| Бангладешийн хар салхи (1996 оны 6 сар) | \$10,000 |
| Умард Солонгосын өлсгөлөнгийн үеэр 2000 тонн будаа (1996 оны 6 сар) | \$526,300 |
| Доминикийн төр засгийн болоод буяны байгууллагууд (1996 оны 3 сар) | \$55,000 |
| Их Британид үзүүлсэн тусlamж (1995 оны 8 сар) | \$15,000 |
| Чечень, Боснийн дайнаас дүрвэгсдэд (1995 оны 2 сар) | \$100,000 |
| Японы Кобе, Осакагийн газар хөдлөлт (1995 оны 1 сар) | \$124,700 |
| Камбожийн гангийн үеэр 6000 тонн будаа (1994 оны 12 сараас 1995 оны 2 сар) | \$1,632,800 |
| АНУ-ын Мид-Уэст Умард хэсгийн төв (1994 оны 2-3 сар) | \$450,000 |
| АНУ-ын ДОХ ба хорт хавdryн судалгаанд зориулж (1994 оны 1 сар) | \$100,000 |
| АНУ-ын Өмнөд Калифорни мужийн гал түймэр (1993 оны 11 сар) | \$64,100 |
| Угандаагийн Оюун санааны бясалгалтнуудад (1993 оны 5 сар) | \$55,000 |
| Ау Лак (Вьетнам) Лонг Ангийн үер (1991 оны 12 сар) | \$220,500 |
| Хятадын үер (1991 оны 7 сар) | \$331,200 |
| Филиппиний Пинатобу галт уул дэлбэрэлт, үер (1991 оны 7-10 сар) | \$734,400 |
| Герман дахь Ау Лак (Вьетнам) сүмүүд (1990 оны 7 сар) | \$320,000 |
| Хонг Конг дахь Ау Лак (Вьетнам) дүрвэгсдэд (1990-1993) | \$288,195 |
| Формоса Тайваний ядуу буурай өрхүүд, сүм хийд, орон нутгийн захиргаа, олон нийтийн байгууллагуудад (1989-1993) | \$366,282 |

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Монголд үзүүлсэн хүмүүнлэгийн тусlamж

| | |
|--|-----------|
| Улаанбаатарт тусlamж хэрэгтэй байгаа хүмүүст өвлийн хувцас, хоол, гэр орон худалдан авахад (1998 оны 1 сар) | \$1.000 |
| Монголын байгалийн экосистемийг хадгалж шинээр мод тарихад (2006 оны 1 сар) | \$2.200 |
| Монголын байгалийн экосистемийг хадгалж шинээр мод тарихад (2007 оны 4-5 сар) | \$7.898 |
| "Нэг хүн нэг мод тарих" хөтөлбөр хэрэгжүүлэхэд (2008 оны 4 сар) | \$10.000 |
| Үерийн гамшигт нэрвэгсдэд гэр орон, дулаан хувцас авахад (2009 оны 7 сар) | \$20.000 |
| Амьжиргааны хүнд хэцүү нөхцөлд амьдарч байгаа хүмүүст зориулж (2010 оны 5 сар) | \$9.667 |
| Монголын уран бүтээлчдийг дэмжихэд (2010 оны 4 сар) | \$350.000 |



НҮБ-ЫН ХУРЛЫН ИНДЭР ДЭЭР МОНГОЛ ХҮН НЭР ХҮНДТЭЙ ШАГНАЛ ХҮРТЖЭЭ.

Өмнөд Африкийн бүгд Найрамдах Улсын Дурбан хотноо өнгөрөгч 11 дүгээр сарын 28-наас 12 сарын 09-ны хооронд зохион байгуулагдсан НҮБ-ын Ур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх оролцогч талуудын олон улсын бага хурлын үеэр нэгэн монгол хүн шагнал авч, төлөөлөгчийн анхаарлыг ихэд татжээ.

Тус шагналын тухай тодруулбал: АНУ-ын тэргүүн хатагтай Мишель Обама, "Битлз" хамтлагийн гишүүн ноён Пол Маккартни, Дэлхийн оюун санааны их удирдагч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, 2009-2011 онд Этиоп улсад 8.06 тэрбум мод суулгасан Др.Тевольд Иоханнес зэрэг олны танил хүмүүсийн хамт НҮБ-ын хурлын хүндэт индэр дээр ноён Р.Баярбат гэх монгол эр "Дэлхийн тогтвортой хөгжлийн баатарлаг удирдагч шагнал"-ыг хүртсэн байна.

Уг шагналын зорилго нь энэхүү гараг дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нэн даруй, дорвитой шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлж буй үйл хөргээрээ үлгэр дуурайл болж яваа хувь хүмүүс, албан байгууллага, аж ахуй нэгжийг урамшуулан дэмжихэд чиглэсэн бөгөөд энэ удаагийн шагналнуудыг юуны түрүүнд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үйл хэргийнх нь ач холбогдол, цар хүрээг харгалzan үзэж сонгон шалгаруулсан байна.

Ноён Р.Баярбат нь дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох, байгаль орчныг хамгаалах тухай асуудлыг хоёр хүнсний сонголт өдөр тутмын хэрэглээгээ хянах энгийн арга замаар хамгийн үр дүнтэй шийдвэрлэж болох тухай ойлголт, мэдээллийг ард түмэндээ хүргэж, цэвэр ургамлын гаралтай /веган/ хүнс хэрэглэх явдал нь уур амьсгалын өөрчлөлтийг зогсооход цаг хугацаа эдийн засгийг хэмнэсэн хамгийн үр дүнтэй арга гэдгийг таниулсан олон талт үйл ажиллагааг зохион байгуулж Монголд "Ургамал

хоол" буюу "веган" гэх ойлголтыг дэлгэрүүлэхэд өөрийн биеэр үлгэрлэсэн анхдагчдын нэг юм. Тэрээр Монгол Улсын байгаль орчныг хамгаалах, цөлжилтийг зогсоох, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, ирээдүй хойч үе болох залуучуудад архи, тамхинаас татгалзан зөв амьдрах арга ухааныг сурталчлах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан тул ийнхүү дэлхийн хэмжээний нэр хүндтэй шагналыг хүртэн Дэлхий дахинаа Монгол улсынхаа нэрийг дурсгажээ.

Р.Баярбат: "Намайг тэр хүндтэй индэр дээр Монголчуудаа төлөөлөн гараад, ийм том шагнал авахад гайхсан хүн олон байсан. АНУ-ын тэргүүн хатагтай болоод дэлхийн хэмжээнд өөрсдийн хийсэн сайн үйлсээрээ танигдсан хүмүүстэй мөр зэрэгцэж ийм шагнал авна гэдэг миний амьдралд тохиосон хамгийн гайхалтай үйл явдал байлаа. Мөн монгол хүмүүс мах л иддэг гэж боддог болохоос биш, эрүүл хооллолтонд ингэж анхаарал хандуулдаг гэж санасангүй гэх нэгэнтэй ч таарч байсан. Тэр үед гараг дэлхийгээ хамгаалахын төлөө "ургамал" хоолыг сонгосон олон мянган Монголчууд, 10 жил энэ бүхний төлөө хамтран зүтгэсэн баг хамт олноороо бахархан хүндэтгэж байлаа." ГЭВ.

Тэрбээр шар буурцгийн уурагт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны "Адистай" ХХК, "Хайрын Өргөө" олон улсын сүлжээ веган ресторан, "Ургамлан хүнс судлан дэлгэрүүлэх академи" Төрийн бус байгууллага, "Судлалт ертөнц" Төрийн бус байгууллага, "Веган супермаркет" гээд олон төрлийн байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг удирддаг аж. Мөн Р.Баярбат нь "Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэг"-ийн төлөөлөгч, Монгол дахь төвийн ерөнхий зохицуулагчаар ажиллаж байна.

БОГД ОЧИРВААНЫ ТАХИЛГА БУЮУ ИХ БАГШИЙН ХАЙР АДИСПАЛ

Монгол зоны эрхэм дээд ариун шүтээн болсон БОГД ОЧИРВААНЬ хайрхны ээлжит төрийн тахилгын ёслолыг улайг цээрлэж, цагаан идээг эрхэмлэж, мах, архигүйгээр хийх гэгээлгээ шийдвэр гаргасан Завхан аймгийн засаг дарга Я.Санжмятавын шийдвэрийг Тэнсэлгүй Дээд Багш ЧИН ХАЙН авшигтан бясалгагч номын ахан дүүс гүн хүндэтгэлтэйгээр хүлээн авч хамтран ажиллахаар болсон билээ.

Улаанбаатар, Орхон, Дархан-Уул зэрэг аймгуудаас 40 гаруй бясалгагч гэгээнтүүд хүрэлцэн ирж тахилгын үйл ажиллагаанд оролцсон олон мянган хүмүүст ургамлын гаралтай хоол хүнсээр үйлчилж, олон амьтан алагдах шалтгааныг арилгасан юм. Тахилгын үед энэ цагийн амьд бурхан хувилгаан дүрээрээ запран хайрхны оройгоос нутаг ус, ард олныг адислан шидийг үзүүлсэн. Энэ нь Монгол улсыг авралдаа багтаасан хэрэг бөгөөд, тухайн орон нутаг ган зуд, гай гамшгаас гэтэлгэгддэг нигууртай. Өнгөрсөн жил Монгол улс даяар зүн зуншлага, өвөл хэрхэн өнгөрснийг тунгаах буй за. Цаашдаа ч ийм байх болно. Бурхны хайр ивээл цаглашгүй билээ.



Тахилгын үеэр МУ-ын ерөнхийлэгч Ц.Элбэгдорж, Завхан аймгийн засаг дарга Я.Санжмятав нар.



Тахилгын үеэр ургамал хоолоор үйлчилсэн авшигтан бясалгагч нар.



Завхан аймгийн Улиастай суманд "LOVING HUT" олон улсын сүлжээ ресторан байгуулсан авшигтнууд.



Шээ нар Даян хайрханд гарч түмэн бодисыг Их Багшийн хайраар адислаж бясалгаж байгаа нь.



Бясалгалын дараа...



Даян хайрхнаас буухын өмнө...



Завхан аймгийн Улиастай суманд байгуулсан "LOVING HUT" хоолны газар.



Бясалгагч нар үдийн өдрийн хоолоо идэж байгаа нь.



Улиастай сумын иргэдэд ургамал хоолны сургалт явуулж байгаа нь.

ТӨГС ГЭГЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН санаачилсан шагналын эзэд



Дэлхийн Гарамгай Удирдагчийн шагналыг Төгс Гэгээрсэн Их Багш 2006 оны 3-р сард санаачлан олгож эхэлсэн байна. Өнөө үеийн нийгэмд өөрсдийн эрхэм ариун үйл хэрээрээ гараг дэлхийд эерэг дэвшил болон өөрчлөлтүүдийг авчирч байгаа нэр хүндтэй, алдар цуутай хүмүүс, улс орон, болон байгууллагуудад өгдөг хүндэтгэлийн шагнал юм.

Бурхны ариун хайрын илрэл, уярам сайхан уян зөвлөн үйл хэрэг эх дэлхий дээр маань хaa сайгүй болж байгааг та харж болно. Ийм сайхан учрал тохиолууд болон хүмүүнлэг үйл хэргүүд нь бидний нийгэмд эерэг сайн зүйлийг бий болгож гараг дэлхийг маань дээш татах хөдөлгөх хүч нь болж байгаа юм. Эдгээр сайшаалтай явдуудыг баатан үнэлж, илүү олон хүн тэдгээр үлгэр дуурайллыг дагасай хэмээн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Гэрэлтэн буй Дэлхийн Агуу Их Удирдагчийн шагналыг тэдгээр үлгэр жишиээч хүмүүст, ухаалаг шийдвэр гаргадаг засгийн газрууд, болон байгууллагуудад гардуулдаг юм.

"ДЭЛХИЙН ГАРАМГАЙ УДИРДАГЧ"-ийн шагнал



Монгол Улсын Парламентын чуулганаар Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж шүүх эрх мэдлийн байгууллагуудын гишүүд ажилчдад хандаж, цаазаар алах ялыг хэрэглэхгүй, үүнд хориг зарласнаа хэлжээ. Цаазаар алах ялыг 30 жилийн хорих ялаар солих тухай мэдэгдсэн байна. Ерөнхийлөгч хэлэхдээ "Дэлхийн улс орнуудын дийлэнх нь цаазаар алах ялыг татгалзах замыг сонгосон байна. Бид ч энэ замд нэгдэх ёстой" гэсэн байна. Хүний амийг училж, өршөөл нигүүсэл үзүүлэхийг дэмжиж байгаа Монгол улсын ерөнхийлөгч нь. Монгол улсын төдийгүй цаашлаад дэлхий нийтийн эрх ашиг, ач тусын төлөө бүхий л шийдвэр гаргагч нарын дунд өөрийн үлгэр жишиээч байдлыг үзүүлж буйг нь Их Багш Чин Хай үнэлэн өөрийн Дэлхийн Гарамгай Удирдагчийн шагналыг 2010 оны 4 дүгээр сар 23нд нийгэмлэгийн гишүүдээрээ дамжуулан гардуулсан байна.

"ДЭЛХИЙН БААТАРЛАГ ҮЙЛС"-ийн шагнал


Эмгэнэлт явдал тохиоход тун ойр байсан тэр л нэгэн өдөр гүн гүнзгий Ерөө голын усанд гутлаа алдаж, түүнийгээ авах гэж оролдож байгаад Баатархүү гуайн хүү усанд унажээ. Ихээр түгшиж балмагдсан Баатархүү гуай хэрхэн сэлэхийг ч мэдэхгүй байж ус руу үсэрч орсон байх юм. Гэнэт аиж сандарсан түүний охидууд мөн аавыгаа даган ус руу үсэрцгээсэн байна.. Хүчтэй урсгалаас үүссэн эргүүлэгт орсон гэр бүлийн дөрөв амиа аврах гэж тэмцэн ядан байсан яг тэр үед,. Усан Спорт Сургалтын Төвийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа ,Улсын Их Хурлын гишүүн Улаан гуай аз тохиож тун ойр байж , тэдэнд туслахаар амь биеэ хайхралгүй, аймшиггүй чин зоригтойгоор гүйж очжээ. Тэрээр догшин, ширүүн урсгал уснаас хүүхдүүдийг бүгдийг нэг нэгээр нь аварч гаргасны дараа дахин ус руу орж ухаан балартсан Баатархүү гуайг эргүүлэгнээс татаж гаргасан байна Юутай гайхалтай вэ, Эрхэм Дээдэс танд баяр хүргэе. Чухам үнэндээ Та Бүх Монголчуудын урам зоригийг тэтгэгч төдийгүй үлгэр дуурайлал болсон Улсын Их Хурлын Гишүүн туулиас мөн билээ!



Өөрийгөө үл огоорсон жинхэнэ хүний мөс чанар гаргаж, хүнд хэцүү нөхцөлд байдалд үзүүлж буй шаламгай, авхаалж самбаатай байдал болон эрхэм ариун байдлыг үнэлэн хүндэтгэж Доктор Профессор Эрхэмсэг Ноён Чүлтэмийн Улаан Таны агуу их баатарлаг үйлсийг тань үнэлэн Их багш Чин Хайн нэрэмжит"Дэлхийн нигүүлсэнгүй үйлс"-ийн шагналыг гардуулсан байна.



"ДЭЛХИЙН НИЙГҮҮЛСЭНГҮЙ ҮЙЛС"-ийн шагнал



Монголын ядуу, хаягдсан, буруу замаар орсон, уруу татагдсан хүүхдүүдэд сайн сайхан амьдралыг бэлэглэгч "Бадамлянхуа" Хүүхдийн Төвийг Диidi Ананда Калика 1995 онд үүсгэн байгуулжээ.

Австралийн Иогийн багш Диidi Ананда Калика нь Улаанбаатарт амьдарч байхдаа хүнд хэцүү байдалд байгаа гудамжны олон хүүхдүүдийг хараад тэдэнд хайр энэрэлээ түгээж, сайн санааны үүднээс туслах санаа төрсөн байна. Анхандаа тэдэнд хоол өгч, гэртээ хонуулдаг байсан боловч яваандаа тэдэнд илүү их анхаарал хalamж дутагдаж байгааг ойлгож, ядуурал болон бусдад дээрэлхүүлж, бусдын эрхэнд байж, хүчирхийлэлд өртөж байгаа тэдгээр бяцхан хүүхдүүдийг энэ хүнд нөхцөл байдлаас нь салгахыг хүсчээ. Тэрээр Яармагт нэгэн хуучин байшин худалдан авч Монгол найзуудынхаа тусламтайгаар хүүхдийн төв байгуулж чадсан байна. Өлсөж, цангасан, тэжээлийн дутагдал доройтолд орсон ядуу, хаягдсан, гэр орноосоо дайжсан буруу замаар

орсон, уруу татагдсан хүүхдүүдэд асрамж хalamжийн төв байгуулснаар тэдний ирээдүй баталгаатай болсон байна. Одоо дээрх төвд 0-8 насны 150 гаруй хүүхэд хүмүүждгээс гадна байрандаа өргөтгөл хийж талбайгаа тохижуулж, орой хичээл хийх танхим болон тоглоомын талбай байгуулжээ.

Эдгээр ажлыг нь өндөөр үнэлэн, Төгс Гэгээрсэн Их Багш Чинхайн нэрийн өмнөөс Бадамлянхуа Хүүхдийн Төвийн захирал, үүсгэн байгуулагч Диidi Ананда Калика-д, түүний манай гараг дэлхийг сайн сайхан болгох гээн энэрэнгүй, гэгээлэг болоод эрхэмсэг нигүүлсэнгүй үйлсэд зориулж, "Дэлхийн Нигүүлсэнгүй Үйлс"-ийн шагнал, 10.000 долларын хамт гардуулсан байна.



Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт орших "Бамбар" хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Цогзолмаа нь өөрийн энэрэнгүй хайраараа амьдралын бололцоо тааруухан өрх айлуудын бяцхан хүүхдүүдэд гэрэл гэгээг бэлэглэн, тэдэнд өгөөмөр уужим хандсаных нь төлөө дэлхийн нэрт хүмүүnlэг үйлстэн Их Багш Чин Хайн хүндэтгэж "Гэрэлт дэлхийн нигүүлсэнгүй үйлс" -ийн шагналыг илгээснийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн олон улсын нийгэмлэгийн Монгол дахь төвийн гишүүд баяртайгаар уламжилсан юм. Уг шагналыг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн багшийн туурвисан дэлхийн шилдэг ном, сэтгүүл, видео бичлэг, 10 000 доллар дагалдсан юм. "Бамбар" цэцэрлэгийн хамт олон тэрхүү цэцэрлэгт суралцагч бяцхан хүүхдүүдэд ургамлын гаралтай хоол өгдөг нь үнэхээр бахархам байлаа. "Бамбар" хүүхдийн цэцэрлэгийн захирал хатагтай Цогзолмаа болон "Бамбар" цэцэрлэгийн хамт олон болон өхөөрдөм бяцхан хүүхдүүдийг хамгийн дээд төгс бурхан адислан ивээх болтугай.



Энэ удаа бид тэнгэрлэг гал тогоо буландаа Химиин ухааны доктор, профессор "Лавин Хат" олон улсын веган хоолны сүлжээний Хан-Уул дүүргийн "Цагаан хаалга" салбарын эзэн Э.Уранчимэгийг урин та бүхэнтэй уулзуулж байна.

Бидний урилгыг хүлээн авсан танд баярлалаа. Танай "Лавин Хат" веган хоолны газар Энэрэнгүй Хоолны Холбооны 2011 оны шилдэг зоогийн газар гэсэн өргөмжлөл хүртсэнийг дуулсан. Танд баяр хүргэе.

Бярлалаа.

Танай зоогийн газрын анх байгуулагдаж байсан түүхээс яриагаа эхэлье?

За тэгье. Анх 2008 оны 9 сарын 1-нээс "Вижи" цагаан хоолны кафе нэртэйгээр байгуулагдаж байсан. Яг нэг жилийн дараа буюу 2009 оны 9 сарын 1-нд "Лавин Хат" олон улсын Веган хоолны сүлжээнд хамрагдан ажиллаж байна даа.

Цагаан хоолны газар Веган хоолны газар болсон гэж та ярилаа. Ингэснээрээ ямар өөрчлөлт оров?

Цагаан хоолны үйлчилгээнд ямар ч мал амьтны мах, өндөг ороогүй хоолны жороор үйлчлэх ёстой байдаг. Гэхэдээ малын гаралтай сүү цагаан идээг өргөн хэрэглэж болдог байлаа. Веган хоолны үйлчилгээнд шилжсэнээр аливаа мал, амьтны мах, өндөг ороогүйгээс гадна малын гаралтай сүү цагаан идээг хоолны жорондоо оруулахгүй байх ийм өөрчлөлт орсон. Ийм хүнс нь цэвэр ургамлын гаралтай, жинхэнэ эко буюу ариун хүнсэнд тооцогддог. Мөн архи, тамхигүй эрүүл цэвэр орчныг бүрдүүлж хэргэлэгчдээ үйлчлэх үүрэгтэй.

"Лавин Хат" олон улсын веган хоолны сүлжээний талаар тодруулж ярихгүй юу? Зорилго нь юу вэ?

Төгс гэгээрсэн Их Багш Чин Хай-н санаачлагаар 2007 онд анх байгуулагдсан. Төв нь Тайваньд байрладаг. Одоогийн байдлаар дэлхийн 40 гаруй оронд "Лавин Хат"-

ГЭГЭЭЛЭГ ХҮН УЛАМ ОЛОН БОЛХ БОЛТУГАЙ

ын салбар үүд хаалгаа нээгээд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа. Ер нь манай "Лавин Хат"-ын сүлжээ дэлхий даяар өдрөөс өдөрт тэлсээр байгаа. Монголд гэхэд л 2008 оноос хойш 30 гаруй салбар шинээр нээгдээд ажиллаж байна. Үүнээс 20 орчим нь Улаанбаатар хотод, 10 гаруй нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа. Дэлхийн дулаарлыг бууруулахад хувь нэмрээ оруулах гол зорилготой. Дэлхийн цаг уурын дулаарал нь хүн төрөлхтөнд маш их аюултай үзэгдэл болоод байгааг бид бүгд мэдэж байгаа шүү дээ. Цаг уурыг дулааруулах хамгийн том хүчин зүйл нь хүний хүнсэн дэх махны хэрэглээг хангах зорилгоор явуулж байгаа цогц үйл ажиллагаанаас үүдэлтэй гэдгийг НҮБ-аас зарласан байдаг. Тиймээс бид махны хэрэглээг багасгахад бага ч болов хувь нэмрээ оруулах ёстой гэж ойлгодог. "Лавин Хат" веган хоолны сүлжээ байгуулагдах болсон гол шалтгаан энэ юм даа.

Цаг уурын дулааралд махны хэрэглээ нөлөөлж байгаа гэдгээ тодруулахгүй юу?

Дэлхийн цаг уурын дулаарлыг ихэсгэж байгаа хамгийн томоохон хүчин зүйл болох хүлэмжийн хийн 50 гаруй хувийг мал аж ахуй дангаараа ялгаруулж байгаа нь нотлогдсон байгаа. Үүнээс үзэхэд мал аж ахуй нь дэлхийн дулаарлын гол буруутан бөгөөд голлох хүчин зүйл гэж тооцогдож байна. Төгс гэгээрсэн Их Багш Чин Хай хэлэхдээ "Дэлхийн дулаарлын 80%-ийг зогсоож чадах хамгийн дөт зам бол амьтны амь хөнөөгөөгүй хүнс хэрэглэх явдал юм. Эрүүл хүнс таны өөртөө барьж буй энэ насны бэлэг" гэж хэлсэн байдаг.

Маши чухал сэдэв гэдэг нь тодорхой байна. Энэ талаар тусгайлан ярих ёстой юм шиг санагдаж байна. Веган хоолыг Монголчууд маань хэрхэн хүлээж авч байна даа?

Дэлхий нийтийн хоол хүнсний асуудал веган хоолны дэглэм рүү шилжих байна. Манай монголчууд ч гэсэн эрүүл мэндэд тустайгаас гадна бусад олон ашигтай талуудыг мэдэрсэн учраас сүүлийн үед Веган хүнсийг сонгох нь маш ихээр нэмэгдэж байгаа. Бид бүр ачааллаа дийлэхгүйд хүрээд байгаа шүү.

Та өөрөө мэдээж Веган биз дээ?

Би өөрөө 2004 оноос цагаан хоолтон явж байгаад 2008 оноос Веган хоолтон болсон. Өөрийн туршлагаас хэлэхэд эрүүл мэнд мэдэгдэхүйц сайжирч, өвдөх өвчингүй, зовох зовлонгүй, дотрооскоо амгалан тайван аз жаргалтай болсон доо.

Веган хоолтон байх нь эрүүл мэндэд яаж сайнаар нөлөөлж байгаа талаар?

Сайн нөлөөтэй гэдэг нь шинжлэх ухаанаар хэдийнээ батлагдсан зүйл. Үзүүлэлтээс нь дурьдаж болно. Жишээ нь: Та веган /ногоон / хоолтон болсноор



- Чихрийн шижин болон зүрх судасны өвчнөөр өвчлөхгүй.
- Үе мөчний өвчнийг эдгээнэ.
- Мал амьтнаас дамждаг олон төрлийн халдварт, өвчлөлөөс сэргийлнэ.
- Хорт хавдрын эрсдэлийг 50% хүртэл бууруулна.
- Хэт таргалалтаас сэргийлнэ.
- Наслалт 15 жилээр уртсана.
- Оюуны өндөр чадамж тань сэргэнэ гэх зэргээр маш их сайн, эерэг үр дүн гардаг.

Малын махнаас өөр уургийг нөхөх ямар нэгэн бутээгдэхүүн байдаггүй гэсэн нийтлэг ойлголт хүмүүсийн дунд байдал даа. Үнд та юу гэж хариулах вэ?

Энэ ойлголт одоо өөрчлөгдөж байна. Би түрүүнд хэллээ. Дэлхий нийтээрээ веган хүнсийг сонгож байна гэж. Монголчуудын сэтгэл санаанд махнаас өөр уураглаг зүйл үгүй гэсэн ойлголт хүчтэй байр суурь эзэлсэн байдгийг бид мэнднэ. Гэхэдээ энэ ойлголт өрөөсгөл болохыг манай "Лавин Хат"-ын сүлжээгээр үйлчлүүлдэг монголчууд маань мэддэг болсон байгаа. Өдөр ирэх тусам үйлчлүүлэгч олширч байгаа гэж би түрүүн хэлсэн дээ. Тэгэхээр ургамлаас гаралтай уураг хүний уургийн хэрэгцээг хангаад байна гэдэг нь батлагдаж байгаа биз. Ургамал хоолны талаарх бас нэг ташаа ойлголт бол хүнийг сульдаа, ядрнуу, хүч тамиргүй болгодог гэсэн ойлголт юм. Харин ч эсрэгээрээ. Манайхаар байнга үйлчлүүлдэг бодибилдингийн залуус үүнийг батална. Тэдний хоёр нь багш нь бусад нь суралцагч нар нь гэсэн. Маш сайхан эрүүл чийрэг, зүс царай сайхантай, бадируун залуучууд байдаг. Энэ бодит жишээ ургамал хоол уурагийн дутагдалд оруулна гэсэн ойлголт худал болохыг харуулж байна.

Ямар ургамал хамгийн их уураг агуулдаг вэ? Махнаас их байж чадах уу?

Мах үнэндээ маш бага уураг агуулдаг юм шүү дээ. Монголчууд энэ талаар саяхныг хүртэл тун бага мэдээлэлтэй байсан юм. Одоо байдал өөр болсон гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Ургамлаас хүн бүх шим тэжээлээ авч болно. Жишээ нь: Шар буурцгийн мах 40-55%-ийн уураг агуулдаг, шошны суу /хуурай/ 41,8%, буурцагт шош /хатаасан/ 31,4%, газрын самар 26%, вандуй 24,7%-ийн уураг агуулдаг байхад үхрийн мах 20,2%, тахианы мах 18,6%, хонины мах 16,8%-ийн уураг агуулж байх жишээтэй. 100гр шар буурцгийн үр дунджаар уураг 36,8%, тос 23,5%, нүүрс ус 24,5%, кали, натри, кальци, фосфор, магни, төмөр, фтор зэс, иод, цайр, селен зэрэг эрдэс бодис, А, Е, В1, В2, фолийн хүчил зэрэг амин дэм агуулдаг. Дашрамд хэлэхэд маш олон судалгаа шинжилгээний үр дүн болон бодит амьдралаас

дүгнэвэл ногоон хоолтон /веган/ хүн махан хоолтоос илүү хүч чадалтай, тэсвэр тэвчээртэй, шаламгай, маш ухаалаг болохыг харуулдаг.

Уншигчдад хандаж хэлэх таны уг?

Бид энэ ажлаа хийж байхдаа маш их баяртай байдаг. Монголчууд маань ямар гайхалтай гэгээлэг хүмүүс юм бэ? гэсэн бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрдөг шүү. Чин Хай багшийнхаа үүсгэн байгуулсан энэ буянлаг үйлсэд гар бие оролцож байгаадаа манай хамт өлон туйлаас баяртай байдаг. Амьд сэруүн гэгээрсэн багшийн маань буянд даган баясаж бидний үйл хэрэгт дэмжлэг үзүүлж мөн өөрсдийнхөө эрүүл мэндэд хөрөнгө оруулж байгаа үйлчлүүлэгчдэдээ маш их баярлалаа гэж хэлье. Та бүхэн өөрсдийн эрүүл мэндийг хамгаалаад зогсоогүй дэлхий гарагийнхаа эрүүл мэндэд маш их тус хүргэж байгаа гэдгээрээ бахархах эрхтэй гэж нэмж хэлье.

Танай сэтгүүлийн уншигчдад хандаад хоолны дэглэмээ нэг ахнаарч хараад веган хоолны дэглэмд шилжээрэй гэж чин сэтгэлээсээ хүсье. Гэгээлэг хүн улам олон болох болтугай. Та бүхэнд баярлалаа.

Солянка

Орц: Лууван 30гр
 Манжин 30гр
 Хулуу 30гр
 Дүпү 30гр
 Дарсан өргөст хэмх 30гр
 Майонез 15гр
 Ногоон өргөст хэмх 50гр
 Төмс 60гр
 Уураг 40гр
 Томат паста 15гр
 Дарсан өргөст хэмхийн шүүс 30гр
 Ургамлын тос 20гр

Амтлагч: Давс 50гр
 Мөөг, цэцэгт байцааны амтлагч 10гр
 Яншуй 1навч

Орцыг бэлтгэх: Бүх ногоогоо шоо дөрвөлжин хэрчинэ. Дүпүгээ мөн шоо дөрвөлжин хэрчинэ. Уураг, жижиг уургийг дэвтээж, зайлаад амтлаж бэлтгэнэ.

Хийх дараалал: Ургамлын тосоо халаагаад томат пастагаа хийж хуурна. Дараа нь лууван, манжин, ногоон өргөст хэмх, төмсөө нэмэн хамтад нь хуурна. Дээр нь дарсан өргөст хэмх, хулуу, өргөст хэмхийн шүүс, усаа нэмж хийж буцалгана. Дээр нь дүпүгээ хийж амтлагч, давсаа нэмэн болтол нь буцалгана. Таваглахдаа майонезаа хийж яншуйгаар чимэглэнэ.



БҮТЭЭЛ



ТӨГС ГЭГЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ГЭРЭЛТ БАРИМАЛ СҮНДЭРЛЭЛЭЭ



2011 оны 10 сарын 22-ны өдөр Төгс Гэгээрсэн Их багш Чин Хайн гэрэлт баримал Хөтөл хотод сүндэрлэлээ.

Хүн төрөлхтний амьдралын буруу хэвшил, дүйвээн зэрэг нь гараг дэлхийн эмзэг нарийн тогтолцоог хөндөж, өдөр ирэх тутам биднийг хүрээлэн буй байгалийн зүй тогтол аюул учруулж байгаа энэ цаг үед Их багш Чин Хайн сурлэг баримал манай Хөтөл хотод амилан босч, улмаар түүний нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн бий болж байгаад туйлын их баяртай байна. Энэ нь манай хотын хөгжил дэвшилт болон хүн ардын маань аз жаргал, эрүүл саруул, амьдралд ач тусаа өгч, оюун санааны хөгжил дэвшилд аз хийморь авчирна гэдэгт итгэж байна гэж тус ажлыг санаачлагч Сайхан сумын засаг дарга С.Энхтайван тус арга хэмжээний нээлтэн дээр хэлсэн юм.


Уг баримал нь Монгол улсад дахь хамгийн өндөр баримал бөгөөд 7 метр өндөр, цэвэр металлаар цутгаж хийсэн байна. Зөвхөн их багшийн чин сэтгэлт авшигтан бясалгагчдын 50 гаруй сая төгрөгийн хандиваар бүтээжээ.

Төгс Гэгээрсэн Их багш Чин Хайн олон улсын нийгэмлэгийн Хөтөл төвийн холбогч У. Чинсүх хэлэхдээ:

Монголчууд бид Мөнх тэнгэрийн дээд хүчинээс мэдээлэл авч энэ дэлхийг төвхнүүлэхэд Монголын их хаадаар дамжуулан үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн туршлагатай ард түмний үр сад билээ. Бид жилийн есөн сард нь цэвэр цагаан хоолтой байж, оюун санааны ухамсраа хамгаалж чаддаг байсан агуу туршлагатай бөгөөд одоо энэ цаг үед ч гэсэн энэ дэлхий түүний төрөлтнүүдийг авран хамгаалахад үлгэрлэн дагуулж манлайлах боломжтой ард түмэн. Их эзэн Чингис хаан тухайн үеийн амьд гэгээнтэн Чанчунбумбаас авшиг хүртэн бурхны дамжуулалтыг авч гэгээрэн энэ ертөнцөд ирсэн зорилгоо бурхны тааллын дагуу гүйцэтгэсэн билээ. Одоо бид энэ цагийн амьд Их Багш Чин Хайг даган энэ дэлхийд ирсэн зорилгоо ухаарч, буянаа арвижуулж, эх болсон гараг дэлхийдээ ээлтэй сайхан амьдарцгаая, хүмүүсээ гэлээ.




ХҮН БАЙХЫИН УТГА УЧИР



Холбооны инженер, орчуулагч, орос болон япон хэлээр чөлөөтэй ярьчихдаг, төгс гэгээрсэн Их багши Чин Хайн шавь, бясалгагч, эгэл даруухан Θ. Батболд гэгч залуутай уулзаж өөрийн хичээл зүтгэлээрээ хийж байгаа ажлынх нь талаар тодруулахыг хүссэн билээ. Тэрээр 2006 онд Баянгол дүүрэгт хувиараа Арьяабалын бясалгальн төв байгуулан үнэ төлбөргүй сургалт явуулж, номын сан ажиллуулж эхэлжээ. Мөн Сүхбаатар дүүрэгт ВЕЖИ цагаан хоолны ресторан нээн ажиллуулсан нь хотын анхны архи, тамхигүй ресторанаар шалгарч байсан байна. Тэрээр 2011 онд Хөтөлхөтөд Их багшийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, баримлыг бутээн босгох ажилд 5 сая төгрөгний хандив өргөжээ. Их багшийн монгол шавь наар бясалгал, цагаан хоол дэлгэрүүлэх, дэлхийн дулаарлын эсрэг ногоон байгалийг сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох, байгалийн гамишиг, өвчин зовлонд нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэрэг чиглэлээр “Мацаг хоол Энх амгалан” Төрийн Бус Байгууллага байгуулж, хүмүүнлэгийн байгууллагууд, ШШГЕГ-тай хамтран түүний анги байгууллага, чанга болон ердийн дэглэмтэй хорих ангиудад цагаан хоол, бясалгальн чиглэлээр лекц, сургалт сурталчилгааг үнэ төлбөргүй явуулж байна.

Энэхүү үйл ажиллагаанд чанга, онцгой, ердийн дэглэмтэй болон, эмэгтэйчүүдийн нийт 12 хорих анги, салбар 82 байгууллагын 900 гаруй албан хаагч, нийгмийн ажилтнууд, 4000 гаруй ялтан, хоригдлууд хамрагдсан байна

Эдгээр анги байгууллагын дотроос 421-р хорих ангид бясалгальн танхим, цагаан хоолны гал тогоог засаж, тохижуулан хүлээлгэн өгсөн бөгөөд тэнд одоо 100 орчим хоригдлууд цагаан хоол идэж, 20 гаруй хүн бясалгал хийдэг аж.. Сар тутам 2 удаа нийт 300 гаруй хоригдлуудад лекц, сургалтыг тогтмол явуулж, цагаан хоолны гарын авлага, бясалгал гүн ухааны сэдвээр гэгээнтэн мэргэдийн сургаал, ээрэг мэдээлэл бүхий ном сэтгүүл болон цагаан хоолны шаардлагатай хүнсний материалыар байнга хангаж ажилладаг юм байна. Ийнхүү Мацаг хоол энх амгалан ТББ нь ШШГЕГазартай хамтран хоригдлуудыг нийгэмшүүлж хүмүүжүүлэх талаар байнга хамтран ажилладаг ажээ.. Бясалгагч Батболд: Хойшдоо дээрх байгууллагын холбогдох мэргэжлийн хүмүүстэй хамтран цагаан хоолны стандарт нормыг тогтоох, хоолны цэс, технологийг боловсруулж улмаар ШШГЕГ-ын бүх анги байгууллагын хэмжээнд албан хаагч, хоригдлуудад долоо хоногт 1-2 удаа цагаан хоол хэрэглүүлэх, улам өргөжүүлэх бодолтой байна гэлээ. Эдгээр ажлын үр дүнд хоригдол байсан П. Сүхбат суплагдсаныхаа маргааш өдөр буюу 2012 оны 3 сарын 15-нд авшиг хүртэж, Арьяавалын бясалгальн авшигтан болсон баяртай үйл явдал болжээ. Авшигтан П. Сүхбат дараах талархал, ерөөлийг сэтгүүлээр дамжуулан хүргэж байна..



П.Сүхбат: Юуны өмнө намайг хоригдож байхад амьдралдаа алдаж эндсэн бидэнд байнга анхаарал халамж тавьж өөрийгөө болон бусдыг өршөөж уучлах, хайр нигүүлсэл, хүн болсны утга учир, гэгээрэлд хүрэх хамгийн дөт зам мөрийг ухааруулсан лекц яриа хийж, бие сэтгэлээ амирлуулах “Бясалгалын өргөө” байгуулан өгч, амьтны амь таслаагүй мацааг хоол идэх боломжоор хангаж байсан ном, буян дэлгэрүүлэгч Батболд, Шижирмаа, Даваасүрэн болон бусад ах эгч нартаа маш их талархаж явдгаа өөрийнхөө өмнөөс болон тэнд байгаа цагаан хоол идэж, бясалгал хийдэг нөхдүүдийнхээ өмнөөс илэрхийлэхийг хүсч байна. Тэнд байхдаа сонссон ухаарлынхаа ачаар би суллагдсаныхаа яг маргааш өдөр нь Төгс гэгээрсэн Чин Хай багшийнхаа ач буянаар авшиг хүртэх завшаан тохиолдсондоо бүр ч их баяртай байгаа. Хэрэв нэг өдрөөр зөрсөн бол яах ч байсан юм гэж бодсон шуу. Ингээд хамаг амьтныг энэрэх Их багшийн хайр адислал орчлон даяар дэлгэрэх өлзий хутаг орших болтугай гэж ерөө дөө гэжээ.

“Хүн” байна гэдэг ядаж л адгууснаас ялгаатай байна гэсэн үг. Адгууснаас ялгарахын тулд хүний мен чанарын тухай, хүний тухай наад захын зүйлүүдийг ухаарч эргэцүүлцгээ. Энэ талаар хэдэн үг...

- **Хүн бид идэж, эдлэхийн тулд амьдарч байна уу
Харин амьд байхын тулд идэж, хэрэглэж байна
уу.**
- **Хурмастын энтэй баялаг байлаа гээд
Хумсын чинээг аваад үхэх билүү
Улгэрийн дайтай нэр алдар байлаа гээд
Үхсэн хойноо сонсоод хэвтэх билүү...**
- **Хурааж цуглуулахын нэг зовлон
Хумъж хамгаалахын негөө зовлон
Алдаж харуусахын адгийн зовлон
Ахуйд хүлэгдэхийн үүрдийн зовлон .**
- **Өвдөхгүй юм шиг чадалдаа бүү сагсуур
Өтлөхгүй юм шиг залуудаа бүү эрд
Үхэхгүй юм шиг амьддээ бүү ташаар
Эдгээрийг ухаарч үйлд.**
- **Жаал багад чадалгүйн гачлан
Залуу идэрт завгүйн гачлан
Өтөл буурайд тамиргүйн гачлан
Үргэлж хойно нь ухаарахуйн гачлан**
- **Өөрийн төлөө бусдыг хорловол
Нүглийн зовлон амсах лайтай
Бусдын төлөө өөрийгөө зориулбал
Бурхны амгаланг эдлэх ерөөлтэй.**
- **Авах гэдэг өрийн шалтгаан
Өр гэдэг зовлонгийн шалтгаан
Өгнө гэдэг буяны шалтгаан**
- **Буян гэдэг жаргалын шалтгаан
Өөрийгөө дөвийлгэх нь гэмийн уг
Өрөөлийг хайрлах нь гэгээрлийн эх
Өөрийгөө чухалчлах нь албины ёс
Өрөөлийг чухалчлах нь бурхны сэтгэл.**
- **Хайр өгөхийн нэр
Өгнө гэдэг авахын нэр бус
Өглөг гэдэг хэмжээ, хэлбэр бус
Харин харамгүй сэтгэл гэж хайрыг ухаар.**
- **Асрахуй энэрэхүй нь өглөгийн сэтгэл
Ашиг хонжоо нь наймаачны төрх**
- **Хайр бол итгэл
Итгэл бол хар биш
Хар сэтгэлийн муу чанар
Хайр бол итгэлийн төгс чанар.**
- **Хар бол өнгө биш авах өмчлөх сэтгэл
Хайр бол мөнгө биш өгөх хуваах сэтгэл
Хар бол өөртөө итгэлгүйн мэдрэмж
Хайр бол өөртөө итгэлтэйн илрэл.**
- **Гадаад гоо сайхан буяны шалтгаан
Дотоод гоо сайхан гэгээрлийн шалтгаан
Хүн гаднаа ч сайхан, дотроо ч сайхан байх нь
чухал.**
- **Хорсол, тачаал ассан бол
Хоромхон зуурын сэхээрч
Юу ч бүү ярь, юу ч бүү хий
Мод мэт орштугай гэдгийг санаж үйлд.**

Ө.Батболдын лекцээс..





Ургамал хоолны зоогийн газрууд

Улаанбаатар хот


| № | Нэрс | Хаяг байршил | Холбогдох утас |
|----|--|---|----------------------|
| 1 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | ХУД 2-р хороо Монгол нэхмэл ХК-ны байр | 341548 98719844 |
| 2 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | ХУД 2-р хороо Хүнсний коллежийн байр | 99114373 99237898 |
| 3 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | БГД Бичил хороолол 18-р байр 1 давхар | 99628199 96424989 |
| 4 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | БЗД 15-р хороолол Жоби 72 байр 2 давхарт | 460038 99119710 |
| 5 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Сүхбаатар дүүрэг 1-р хороо Санкт Петербург төв 3 давхар | 98161919 |
| 6 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Чингэлтэй дүүрэг 2-р 40 мянгат 40- байрны 1 тоот | 321396 9990310 |
| 7 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Хүнсний 4-р дэлгүүрийн зүүн урд 29 байр | 91912063 88097510 |
| 8 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | СХД Хархорин зах Шинэ байр 3 давхар | 91917494 |
| 9 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | БЗД 7-р хороо Хуучнаар Туулжинпангийн 2 давхарт | 96683249 |
| 10 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | БЗД, 12-р хороолол, 3-р хороо 45-р байрны өргөтгөл | 99876218 99896636 |
| 11 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Баянгол дүүрэг 1-р хороо Ган зам рестораны 1 давхар | 99233008 |
| 12 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Баянгол дүүрэг Этугэн зочид буудлын Баруун талд | 99861096 96340222 |
| 13 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | ЧД, 4-р хороо 5-р сургуулийн урагш төв зам дагуу | 99197074 |
| 14 | "Луна Вланка" веган хоолны зоогийн газар | Сүхбаатар дүүрэг 1-р хороо Голомт банкны зүүн талд | 99251131 |
| 15 | "Гэрэл аялгуу" веган хоолны зоогийн газар | ЧД, 2-р хороо 12-р байрны В корпус | 88820459 |
| 16 | "Веган лоунж" веган хоолны зоогийн газар | БГД Баруун дөрвөн замын урд /Хуучин тээврийн товчооны замын эсрэг тал/ | 99070969 |
| 17 | "Ариусал" веган хоолны зоогийн газар | Баянзүрх дүүрэг 18-р хороо 13-р Хороолол 10-байр 218 тоот | 99171534 96673475 |



Хөдөө орон нутагт

| № | Нэрс | Хаяг байршил | Холбогдох утас |
|----|--|---|----------------------|
| 1 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Орхон аймаг Эрдэнэт хот 6-р хороолол Бурам төв | 99067988 |
| 2 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Булган аймаг Булган сум Маркет худалдааны төвийн байр | 95154982 |
| 3 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Өвөрхангай аймаг Арвайхээр сум 8-р баг Элит төвийн байр | 99738887 99730373 |
| 4 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Дархан-Уул аймаг Дархан сум 8-р баг Хариг төв 2 давхар | 99608171 |
| 5 | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Сэлэнгэ аймаг Хөтөл хот 18-р байр 2 тоот | 94000446 |
| | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Завхан аймаг Улиастай сум Төв эмийн сангийн эсрэг талд | 99466668 |
| | "Loving Hut" олон улсын веган хоолны сүлжээ ресторан | Сэлэнгэ аймаг Зүүнхараа хот Мөнгөн хараа чуулга зүүн талд | 99391505 99275205 |
| 6 | "Хайрын зоог" веган хоолны газар | Орхон аймаг Эрдэнэт хот Оюут баг 2 -6-2 | 91916633 99135593 |
| 7 | "Ариусал" веган хоолны газар | Ховд аймгийн Жаргалант сум Тамгийн газрын ард | 95484052 |
| 8 | Адислал веган хоолны газар | Дархан –Уул аймаг Дархан сум 7-баг Цагаан сүлд ХХК байр | 88368394 |
| 9 | Тэмүүлэн веган хоолны газар | Дархан –Уул аймаг Дархан сум 12-р баг Олон улсын худалдааны төв | 95397337 |
| 10 | "Ариусалт" веган хоолны газар | Баянхонгор аймаг Дунд захын ард | 99448039 |
| 11 | "Аялгуу" ногоон хоолны газар | Баянхонгор аймаг II 10 жилийн ард | 93042964 |

Ургамал хоолны үйлдвэрийн газрууд

| № | Нэрс | Хаяг байршил | Холбогдох утас |
|---|---------------------------|--|----------------------|
| 1 | "Адистай" ХХК | ХУД 2-р хороо Монгол нэхмэл ХК-ны байр | 99088819 96660512 |
| 2 | "Бурхадын зоог" ХХК | СХД 15-р хороо Драгон төвийн баруун хойд талд | 99891078 |
| 3 | "Бразас" ХХК | СБД 4-р хороо Партизаны гудамж, Транскапитал байр 4 тоот | 50025599 50035599 |
| 4 | "Go green" ХХК | Чингэлтэй дүүрэг 1-р хороо 8т-50 айл 102 тоот | 319809 98083198 |
| 5 | "Мөнх гэгээн оршихуй" ХХК | Дархан-Уул аймаг Дархан сум 8-р баг Дэвшил 1-5 тоот | 99689646 88068960 |
| 6 | "Алтан эрин" ХХК | Орхон аймаг, Эрдэнэт хот 5-5-1 | 99353135 |






Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр

"Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр" товхимол ном нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургаалын товч тайлбар юм. Энэхүү товхимол цахим хэлбэрээр бэлэн байдаг учраас интернет хаягаар орж үнэ төлбөргүй татан авч, унших боломж дэлхий дахини уншигчдад олгогддог. Африкийн Зулу хэлнээс авахулаад Бенгали, Урду, Македони, Малай болон бусад олон хэлнээ буюу нийт 74 хэлэнд орчуулагджээ.

Энэ товхимолд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өдөр тутмын амьдралд бясалгал чухал болохыг онцлон тайлбарладаг. Түүнчлэн оюун санааны дээд ертөнцүүд, ургамалд сууриссан цэвэр цагаан хоолны ач тус, Гуань Инь аргын бясалгалаар авшиг хүртэхүй, оюун санааны хамгийн дээд эцсийн замналын талаар түүний айлдварууд багтсан буй. "Агшин зуур билэг нээгдэхүйн түлхүүр" товхимол Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэргэн оюун билэг үнэнийг эрэгчдийн цангааг тайлж, гэгэн итгэлийг бэлэглэдэг юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай: "Дотоод дахь амар амгаланд хүрвэл бидэнд бүх юм буй болно. Сэтгэл ханамж, хорвоогийн хийгээд тэнгэрлэг бүх хүсэл Бурхны хаант улсаас тэтгэгдэн бүтэж, дотооддо мөнхийн эз зохирол, мөнх билэг ухаан, бүхний чадагч хүчээ бид ухааран таних болно. Хэрвээ бид үүнийг өөртөө олж авахгүй бол ямар ч хөрөнгө мөнгө, эрх мэдэл, албан тушаал байлаа гээд хэзээ ч сэтгэл ханамжийг олж үл чадна" хэмээн айлдсан билээ.

Товхимлыг дараах хаягаар аваарай. <http://sb.godsdirectcontact.net/>
Товхимлыг дуртай хэлрүүгээ оруулыа гэвэл: divine@Godsdirectcontact.org
Товхимлыг үнэгүй татаж авах хаяг: <http://www.Godsdirectcontact.us/com/sb/>



Шувууд миний амьдралд

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бичсэн "Шувууд Миний Амьдралд" хэмээх өнгө будаг үзэсгэлэнтэй сайхнаар хосолсон ном нь амьтдын дотоод ертөнцөд биднийг урьж байна. Алагчлал үгүй хайраа тэдэнд зориулбал тэд огт эргэлзээгүйгээр бидэнд зүрх сэтгэлээ ямар ч саадгүй нээдэг билээ. Энэ бол хуудас бүрээс нь энэрэл хайр, эв зохирол гэрэлтсэн гайхамшигтай номоороо Төгс Гэгээрсэн Их Багш маань бидэнд амьтад маш ариун бөгөөд сайхан сүнстэй гэдгийг ойлгуулж, амьтдын оюун санааг ойлгоход маань бидэнд тус дөхөм болж байна. Амьтад бол хүмүүс бидний сайн анд нөхөр. Хүн бүр энэхүү гайхамшигт номыг авч уншаарай.

Эрин зууны хайр

Би уншигч аbugай та бүхэнд энэ номыг уншаарай хэмээн зөвлөх байна. Найрагч үгийн шинэ соргог, эв зохиролтой хэмнэлийг шүлэг найрагтаа шингээнээрээ гоо үзэсгэлэн, мөнх оршихуйн ертөнцийг бүтээдэг төдийгүй бас шүлгийн оргилуун, чамин тансаг зохиомжийг цогцлоодог. Хамгийн гайхамшигтай нь эдгээр шүлгүүд зөн билгээс төрж, хүмүүний сэтгэлийг баясгах уvdис дүүрэн байдаг.

Миний амьдрал дахь ноход

"Ноход бидэнтэй зэрэгцэн Газар дэлхий дээр ямар үзэсгэлэнтэй сайхан мөр үлдээдгийг уншигчид маань зэрвэс ч болов мэдж яваасай, тэднээр дамжуулж бусад төрөлтнүүдийн тухай улам ихийг ойлгох мэдээсэй гэж хүснэم." Энэхүү номонд нохойнуудын зан авир нь өөр өөр боловч эрхэм ганц эзэндээ зориулсан хайр нь ижил бөгөөд илэрхий. Тэдний алиа хошин зан ухаан болон олон эрхэм ариун чанарууд нь угтаа нэг л эх сурвалжаас гаралтай билээ.

Эрхэм Ариун Амьтад

Тавдугаар Алтан жилийн (2008 он) босгоор амжилттай алхахий дор Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дэлхийн хүн төрөлхтөнд шинэ жилийн баярын бэлэг болгон "Эрхэм ариун амьтад" номыг өргөн барьсан билээ. Их Багш өөрөө гэрэл зургуудыг нь авч, зохиомжилсон энэ номын хуудаснаа Тэрбээр нур хавиар илрүүлсэн нээлтүүдээ гайхамшигтай яруу шүлгээр илэрхийлж, шидэт байгаль, хээрийн амьтдын зургаар чимэглэсэн нь энэ номыг урлагийн хосгүй бүтээл болгосон билээ.

ЭРҮҮЛ МЭНД

ГЭГЭНТНҮҮД

ЗӨН БИЛЭГ

БЯСАЛГАЛ


ТЭНГЭРЛЭГ ГАЛ ТОГОО

ШИНЖЛЭХ УХААН

ЕРТӨНЦ

ОЮУНЛАГ ЗОЧИН

НОГООН АМЬДРАЛ



ИХ ОЮУНЛАГ ХҮН СЭТГҮҮЛ

2012 ОНЫ ХОЁРДАХЬ УЛИРЛЫН ЗАХИАЛГА АВЧ БАЙНА

ТУС СЭТГҮҮЛ НЬ ИХ ОЮУНЛАГ ХҮМҮҮС БОЛОН ЭРТ ЭДҮГЭЭГИЙН ОЮУН САНААНЫ ИХ БАГШ НАРЫН СУРГААЛ НОМЛОЛ, БЯСАЛГАЛЫН АРГУУД, ДАЛД ЕРТӨНЦИЙН НУУЦ, ШИНЖЛЭХ УХААН ТАНИН МЭДЭХҮЙН МЭДЭЭЛЛИЙГ ТОЛИЛУУЛАХ БОЛНО.

Захиалгын үнэ: 3500 төгрөг, улирлын захиалгын үнэ 10500 төгрөг, зарах үнэ 4500 төгрөг

Манай сэтгүүлийг **Монгол шуудан компани**, **Улаанбаатар шуудан компани**, **Түгээмэл шуудан компани**, **Номин компаний салбар дэлгүүрүүд** болон **бясалгалын төвүүд**, **"Loving Hut"** Олон Улсын Сүлжээ Веган Ресторан, **Ногоон хоолны газруудаар дамжуулан захиалж, худалдан авч үнших боломжтой**.

УТАС: 99873776, 91168686

ХААН БАНК 5030078282
Л.Алтанхуяг

ХААН БАНК 5087108010
Их оюунлаг хүн сэтгүүл